

“ТӨМӨР ЗАМААР АЧАА ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ”-ИЙН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль, Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн төмөр замаар ачаа тээвэрлэхтэй холбоотой суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, тээвэр зуучлагч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төмөр замаар ачаа тээвэрлэгч, суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, тээвэр зуучлагч нар энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томьёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төмөр замын тээврийн нийтлэг дүрэм болон үндэсний стандартад заасан утгаар ойлгож хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АЧААНЫ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, ЗӨВШИЛЦӨХ

2.1. Ачааны захиалга хүлээн авах:

2.1.1. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, тээвэр зуучлагч төмөр замаар ачаа тээвэрлүүлэх захиалгыг орон нутгийн харилцаанд ачаа илгээх өртөөнд, олон улсын харилцаанд тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад ирүүлэх;

2.1.2. Ачаа тээвэрлүүлэх захиалгад илгээх болон хүрэх өртөө, хүлээн авах болон салбар замын нэр, код, ачааны нэр, түүний уялдуулсан код, илгээлтийн төрөл, вагон, чингэлгийн төрөл, эзэмшигч байгууллагын нэр, ачааны жин, тоо хэмжээ, сав, баглаа, боодлын төрөл, илгээгч, хүлээн авагч, түүний хаяг, харилцааны төрөл /төмөр замын шууд харилцаа, холимог харилцаа гэх мэт/ зэрэг өгөгдлийг тусгах;;

2.1.3. Олон улсын харилцаанд тээвэрлэгдэх ачааны захиалгад хилийн дамжин өнгөрөх өртөөдийг заах;

2.1.4. Вагоноор тээвэрлэгдэх ачааны захиалгад вагоны төрөл / битүү, хагас, тавцант, цистерн, хоппер г.м /-ийг заах;

2.1.5. Чингэлгээр тээвэрлэгдэх ачааны захиалгад чингэлгийн төрөл /их, дунд, бага даац, хөргүүртэй г.м./-ийг заах;

2.1.6. Ачаа тээвэрлүүлэх захиалгад илгээлтийн төрөл /вагон, чингэлэг, жижиг илгээлт, өөрийн гол дээр тээвэрлүүлэх/-ийг заана.

2.2. Захиалгыг тээвэрлэгч хүлээн авах, зөвшилцөх:

2.2.1. Илгээгч, тээвэр зуучлагч ачаа тээвэрлүүлэх захиалгыг орон нутгийн харилцаанд тээвэрлэх сар эхлэхээс 10 хоногийн өмнө, олон улсын харилцаанд 15 хоногийн өмнө тус тус төмөр замын тээврийн байгууллагын (өртөө) ирүүлэх ба тээвэрлэгч нь сарын нэмэлт захиалгыг зөвшилцөж болно

2.2.2. Захиалга өгсөн огноог тээвэрлэгчийн хүлээн авсан өдрөөр тогтоох бөгөөд тээвэрлэгч нь өгсөн захиалгын хуудсанд бүртгэлийн дугаарыг бичих;

2.2.3. Захиалгын хуудсанд ачилт хийх өдрийг заасан байна;

2.2.4. Ачаа тээвэрлүүлэх захиалгыг тээвэрлэгчид цахим болон албан бичгээр биечлэн эсвэл шуудангаар ирүүлнэ. Талууд урьдчилан тохиролцсон тохиолдолд бусад хэлбэр /факс/ цахим, и-мэйл зэрэг гэх мэт/-аар захиалгыг ирүүлж болно;

2.2.5. Ачаа тээвэрлүүлэх захиалгыг цахим хэлбэрээр ирүүлэх бол талууд цахим хэлбэрээр бичиг баримт солилцох гэрээ байгуулж, цахим болон тоон гарын үсгээр баталгаажуулсан байна. Тээвэрлэгч ачаа илгээгчийг захиалгын маягтаар хангах;

2.2.6. Ирүүлсэн захиалга нь өгөгдлийн дагуу бүрэн бөглөж, ачаа илгээгч гарын үсэг зурж, тэмдэг тавьж баталгаажуулсан байна;

2.2.7. Цахим хэлбэрээр ирүүлсэн захиалгыг тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан хүлээн авч, тоон гарын үсэг зуруулж, баталгаажуулах;

2.2.8. Ачаа илгээгч нь дайвар үйлчлүүлэгч байвал салбар зам эзэмшигчтэй тохиролцсоны дараа захиалгын хуудсанд "Зөвшилцсөн" гэсэн тэмдэглэл хийлгэсэн байх;

2.2.9. Захиалгад заагдсан мэдээллийн үнэн зөв эсэхийг ачаа илгээгч хариуцна. Захиалга нь ямар нэгэн засваргүй, товчлолгүй, тодорхой бичигдсэн байх;

2.2.10. Энэ журмын шаардлага хангаагүй захиалгын хуудсыг тээвэрлэгч нь ачаа илгээгчид буцаах;

2.2.11. Тээвэрлэгч нь ирсэн захиалгыг нэг хоногийн дотор судлан тээвэрлэлтийг гүйцэтгэх боломжтой гэж үзвэл захиалгын хуудасны "тээвэрлэгчтэй зөвшилцсөн" мөрөнд "зөвшөөрөв", "хэсэгчлэн зөвшөөрөв" гэсэн тэмдэглэгээг хийж, тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан гарын үсэг зурна;

2.2.12. Зөвшөөрсөн болон хэсэгчлэн зөвшөөрсөн захиалгыг төмөр замын тээврийн байгууллага, тээвэрлэгчтэй зөвшилцөхөөр явуулах;

2.2.13. Хэсэгчлэн зөвшөөрөх гэдэг нь тээвэрлэгч өгсөн захиалгын тээвэрлэгдэх ачааны хэмжээг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төрөл, чиглэл зэргийн боломжийг үндэслэн өөрчлөхийг хэлнэ.

2.3. Тээвэрлэгч нь дараах тохиолдолд ачаа тээвэрлүүлэх захиалгыг зөвшилцөхөөс татгалзах эрхтэй:

2.3.1. Ачаа тээвэрлэх чиглэлд ачаа ачихыг хязгаарласан, зогсоосон;

2.3.2. төмөр замын тээврийн байгууллага, тээвэрлэгч захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.3.3. Тээвэрлэлтийг гүйцэтгэх техник технологийн бодит боломжгүй;

2.3.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр татгалзсан тохиолдолд "захиалгыг зөвшөөрсөн огноо" гэсэн мөрөнд "татгалзсан" гэсэн тэмдэглэл хийж, шалтгааныг зааж ачаа илгээгчид буцаана.

2.4. Захиалгыг төмөр замын тээврийн байгууллага хүлээн авах, зөвшилцөх:

2.4.1. Төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь тээвэрлэгчээс ирүүлсэн ачаа тээвэрлүүлэх захиалгыг олон улсын төмөр замын шууд болон шууд бус, холимог харилцаанд тээвэрлэх бол 10 хоногийн дотор зөвшилцөн, захиалгыг зөвшилцсөн үр дүнгийн талаар тэмдэглэл хийж буцаана. Орон нутгийн харилцаанд тээвэрлүүлэх бол төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий албан тушаалтантай зөвшилцсөнөөр өртөөний болон ачиж буулгах ангийн дарга 2 хоногийн дотор үр дүнгийн талаар тэмдэглэл хийнэ;

2.4.2. Төмөр замын тээврийн байгууллага нь ачаа тээвэрлүүлэх захиалгын өгөгдлийг бусад төмөр замын тээврийн байгууллага, бусад төрлийн тээврийн байгууллага болон гадаад орны төмөр замтай зөвшилцөнө

2.4.3. Төмөр замын тээврийн байгууллага нь захиалгыг хянаж захиалгын хуудасны зөвшилцсөн тусгай хүснэгтэд "зөвшөөрөв", "хэсэгчлэн зөвшөөрөв", "татгалзав" гэсэн тэмдэглэл хийж огноог, суурь бүтэц эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсгээ зурж тэмдэг дарна

2.5. Төмөр замын тээврийн байгууллага нь дараах тохиолдолд тээвэрлэгч болон вагон эзэмшигчээс ирүүлсэн захиалгыг зөвшилцөхөөс татгалзах эрхтэй:

2.5.1. Төмөр замын тээврийн байгууллага, тээвэрлэгч болон вагон эзэмшигчийн хооронд гэрээ байгуулаагүй;

2.5.2. Холимог тээвэр гүйцэтгэх тээврийн байгууллага тээвэрлэлтийн захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.5.3. Гадаад орны холбогдох төмөр замын тээврийн байгууллага захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.5.4. Бусад төмөр замын тээврийн байгууллага захиалгыг зөвшилцөхөөс татгалзсан;

2.5.5. Ачаа тээвэрлэх чиглэлд /замнал/ ачаа ачихыг хориглосон, хязгаарласан;

2.5.6. Тээвэрлэлтийг гүйцэтгэх техник технологийн бодит боломжгүй;

2.5.7. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл зэрэг болно.

2.6. Тээвэрлэгч нь ачаа тээвэрлүүлэх захиалгын хуудсыг төмөр замын тээврийн байгууллагаас хүлээж авсны дараа захиалгын хуудасны "Захиалгыг зөвшилцсөн огноо, мөрөнд "зөвшөөрөв", "хэсэгчлэн зөвшөөрөв", "татгалзав" гэсэн тэмдэглэл хийж он, сар, өдрийг зааж тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан гарын үсгээ зурж огноог бичнэ.

2.7. Тэмдэглэл хийгдсэн ачаа тээвэрлүүлэх захиалгын хуудсыг ачаа илгээгчид ачилт эхлэхээс 3 хоногийн өмнө ирүүлнэ. Тээвэрлэлтийг татгалзсан болон хэсэгчлэн зөвшөөрсөн тохиолдолд ачаа илгээгчид шалтгааныг зааж явуулна.

2.8. Хэсэгчлэн зөвшөөрсөн ачаа тээвэрлүүлэх захиалгыг ачаа илгээгч зөвшөөрөхгүй бол тээвэрлэлт эхлэхээс 2 хоногийн өмнө энэ тухайгаа тээвэрлэгчид, тээвэрлэгч нь төмөр замын тээврийн байгууллагад мэдэгдэнэ. Энэ тохиолдолд тооцооны хуудас бүрдүүлэхгүй бөгөөд ачаа тээвэрлүүлэх захиалга биелүүлээгүй торгуулийг ачаа илгээгч, тээвэрлэгчээс нэхэмжлэхгүй. Хэсэгчлэн зөвшөөрсөн захиалгыг татгалзсан хариу ачаа илгээгчээс ирүүлээгүй бол тээвэрлэгч захиалгыг биелүүлж эхэлнэ.

2.9. Ачаа илгээгч нь тээвэрлэгчид зөвшилцсөн ачаа тээвэрлүүлэх захиалгад өөрчлөлт оруулах талаар бичгээр хандаж болох ба үүнд төмөр замын тээврийн байгууллагатай зөвшилцсөнөөр ачаа хүрэх өртөөдөөр нь өөрчлөн хуваарилах, илгээх өртөөг өөрчилж болно. Хаяг сольсны хураамжийг ачаа илгээгч тээвэрлэгчид төлнө.

2.10. Төлөвлөгөөт гэрээтэй үйлчлүүлэгчийн захиалгын нөхцөлийг ачилтын өртөөнд тооцооны хуудсанд бичнэ.

2.11. Тээвэрлэгч нь ачаа тээвэрлүүлэх захиалгад заасан төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төрлийг энэхүү журамд заагдсан бусад төрлийн хөдлөх бүрэлдэхүүнээр сольж өгөх эрхтэй бөгөөд энэ тухайгаа ачаа илгээгчид вагон ачилтад тавьж өгөхөөс өмнө мэдэгднэ.

2.12. Олон улсын төмөр замын шууд болон шууд бус харилцаанд мөн далайн боомтоор тээвэрлэгдэх ачааны хөдлөх бүрэлдэхүүнийг сольж өгөх бол төмөр замын тээврийн байгууллагатай зөвшилцөнө.

2.13. Гэр ахуйн хэрэгцээний болон бусад арилжааны бус шинжтэй ачааны захиалгыг тээвэрлэлт эхлэхээс 3 хоногийн өмнө тээвэрлэгчид өгч болно.

2.14. Тусгай тээвэрлэлтэд цэргийн, онцгой нөхцөл байдлын үеийн захиалгыг "тусгай тээвэрлэлтийн журам"-ын дагуу хүлээн авна.

2.15 Үйлдвэрийн зориулалттай төмөр замын ачаанд тооцооны хуудас бичих, дүгнэх:

2.15.1. тооцооны хуудсыг тээвэрлэлтийн захиалгыг гүйцэтгэхэд тогтоосон маягтын дагуу хөтөлнө;

2.15.2. тооцооны хуудсанд тайлант хоног бүрийн төгсгөлд тээвэрлэгч, ачаа илгээгч гарын үсэг зурж баталгаажуулна. Тооцооны хуудсанд заасан мэдээллийг ачаа илгээгч зөвшөөрөхгүй бол "Зөвшөөрөхгүй" гэж тэмдэглэл хийнэ;

2.15.3. тээвэрлэгч ба ачаа илгээгчийн тооцооны хуудсыг цахим хэлбэрээр хөтлөх үед харилцах нөхцөл журмыг тэдгээрийн хоорондох цахим хэлбэрээр бичиг баримт солилцох тухай гэрээг үндэслэн хөтөлнө;

2.15.4. тооцооны хуудасны загварыг тээвэрлэгч тогтооно;

2.15.5. тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан тооцооны хуудсыг 3 хувь үйлдэх бөгөөд захиалгын хүчинтэй хугацаа дуусгавар болоход дүгнэж 1 хувийг ачаа илгээгчид өгнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АЧААГ ТЭЭВЭРЛЭЛТЭД ХҮЛЭЭН АВАХ

3.1. Ачаа илгээгч нь төмөр замаар тээвэрлүүлэх ачааны сарын захиалгыг сар эхлэхээс 10 хоногийн өмнө, улирлаар хуваарилсан жилийн захиалгыг тухайн жил эхлэхээс 2 сарын өмнө тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад албан ёсоор ирүүлнэ. Ачаа илгээгч захиалгадаа ачааны нэр, төрөл, жин, илгээх ба хүрэх өртөө /зам/, экспортын ачаа очих улсын, орон нутгийн тээвэр очих замын нэрийг тодорхой заах ба эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.2. Төмөр замын тээврийн байгууллага нь экспортын ачааны хэмжээг очих ба дамжин өнгөрөх орны төмөр замтай сар бүр тохиролцоно.

3.3. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага нь дамжин өнгөрөх болон очих орны төмөр зам тухайн сард хүлээн авах боломжтой ачааны нэр, төрөл, тоо хэмжээнд нийцүүлэн ачилт хийхийг зөвшөөрсөн шуурхай шийдвэрийг тээвэрлэх төмөр замуудын харьяа тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга нарт өгч тээвэрлэлтийг зохион байгуулна. Энэхүү шуурхай шийдвэрийг үндэслэн ачаа илгээгч нь ачилтад вагон тавиулах захиалгаа илгээх тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад өгнө. Илгээгчийн захиалгад ачих ачааны нэр, төрөл, тоо хэмжээ, вагон тавиулах салбар замын нэр, ачилт эхлэх хугацаа зэргийг тодорхой заасан байна.

3.4. Ачааг вагон, чингэлэг, жижиг илгээлтүүдээр болон өөрийн гол дээр тээвэрлэлтэд хүлээн авна.

3.5. Ачаа илгээгч нь орон нутагт төмөр замаар ачаа тээвэрлүүлэхэд захиалгын хуудас, /байгууллага бол албан бичиг/ падаан, орлох падааны хамт бөглөж, тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргаас зөвшөөрөл авч тооцооны газарт өгнө. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад тухайн ачааг ачиж дуусах хүртэл падаан нь ачаа илгээгчид байна.

3.6. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга нь илгээгчийн ачааг ачихад бэлэн эсэхийг тодруулж зөвшөөрөл өгөх үүрэгтэй. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын тооцооны ажилтан илгээгчээс захиалгыг хүлээн аваад "ачилтад вагон тавих захиалгын бүртгэлийн дэвтэр" хөтөлж өртөөний ачааны зохицуулагч, зохицуулагчгүй өртөөнд өртөөний жижүүрт бүртгүүлэхээр мэдэгдэнэ.

3.7. Зайлшгүй тохиолдолд вагоны зогсолтыг багасгах зорилгоор зарим ачааны орон нутгийн тээвэрлэлтийг эрх бүхий албан тушаалтны шуурхай шийдвэрээр зохицуулж болно.

3.8. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч-ачаа илгээгч нь экспортын ачааны тээврийн падаанд үнийн баримт /счөт фактур/ заавал хавсаргахын дээр шаардлагатай бол баглаа, боодлын болон бусад онцлог шинжийг тодорхойлсон баримт /ачааны гарал үүслийн болон чанарын гэрчилгээ /-ыг хавсаргана.

3.9. Ачаа илгээгч нь мал амьтан, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, малын тэжээл зэрэг ачааг экспортод тээвэрлүүлбэл мал эмнэлгийн гэрчилгээг орос, англи, эсхүл хүлээн авагч орны хэл дээр үйлдэж, падаанд хавсаргана. "мал амьтан" гэдэгт гэрийн тэжээмэл болон зэрлэг амьтан, мөн түүнчлэн циркийн болон туршилт судалгааны зориулалттай амьтад багтана. "мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн" гэдэгт ангийн олдвор, ангийн арьс, мах, махан бүтээгдэхүүн, малын арьс шир, ноос ноолуур, дэл сүүл, хөөвөр, хялгас, яс, яс ба цусны гурил зэрэг орно. Өвс, хивэг, будаа, багсармал тэжээл зэргийг малын тэжээл гэнэ.

3.10. Ачаа илгээгч нь ургамлын гаралтай бүтээгдэхүүн болох төрөл бүрийн ургамал, хүнсний ногоо, жимс, ургамлын үр зэрэг ачааг төмөр замаар тээвэрлүүлэхэд ургамал хорио цээрийн гэрчилгээ /зөвшөөрөл/-г холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагаас зохих журмын дагуу авч тээврийн падаанд хавсаргана.

3.11. 3.11. Тээврийн падаанд хавсаргасан баримтууд /зөвшөөрөл, гэрчилгээ, сертификат/ дээр бичсэн бичлэг, тоо, тэмдэглэл нь ямар нэг засваргүй, тод, уншигдахуйц байхын зэрэгцээ мэргэжлийн хяналтын байгууллагын тэмдэг, албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна. Хавсралт бичиг баримтны бүрдүүлэлтэд тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын тооцооны ажилтан хяналт тавина.

3.12. Ачаа ачих вагон ба чингэлгийн төрлийг илгээгч сонгоно.

3.13. Тээвэрлэгчийн мэдлийн вагон, чингэлгийг тээвэрлэлтэд бэлтгэхийг тээвэрлэгч хариуцах ба тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, хооронд байгуулсан гэрээгээр ачаа илгээгч хариуцан гүйцэтгэж болно. Хэрэв вагон ба чингэлэг нь тээвэрлэгчийн эзэмшлийн бус бол ачаа илгээгч тэдгээрийг тээвэрлэлтэд бэлтгэх үүргийг хүлээнэ.

3.14. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, нь тухайн ачааг тээвэрлэхэд зориулагдсан тусгай зориулалтын нэмэлт тоноглолоор тоноглогдсон вагон, чингэлэгтэй байж болох ба тээвэрлэгчтэй гэрээ байгуулан тээвэрлэгчийн эзэмшлийн вагонд нэмэлт тоноглол хийж болно.

3.15. Ачааг вагонд ачсаны дараа ачилт гүйцэтгэсэн тал нь вагон, чингэлгийн гадна хана, вагоны явах анги, авто угсрааны хэсэгт байгаа ачааны үлдэгдлийг цэвэрлэнэ.

3.16. Ачаа тээвэрлэхээр сонгосон вагон ба чингэлэг нь тухайн ачааг ачиж тээвэрлэхэд тэнцэх, эсэхийг ачилт хариуцан гүйцэтгэж байгаа тал тогтооно. Үр тариа, мал, амьтан, ургамлын гаралтай хорио цээрийн тусгай зөвшөөрөл шаардсан ачааг энэхүү журмын 10 дугаар бүлэг /хорио цээртэй ачааг тээвэрлэх/-т заасны дагуу тээвэрлэнэ.

3.17. Ачаа тээвэрлэхэд зориулсан вагон ба чингэлэг нь урьд өмнө ачсан ачааны үлдэгдэлгүй, бэхэлгээ бүрэн авсан, цэвэрлэгдсэн байна. Өртөө нь ачаа ачих вагоныг ачаа тээврийн болон техникийн үзлэгт оруулах ба уг вагон ачилтад тэнцсэн тохиолдолд тавьж өгнө.

3.18. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан вагоныг ачилтад тавьсан тохиолдолд вагонд санамж нээж, ачаа илгээгчид вагоныг бүрэн бүтэн хүлээлгэн өгснийг баталгаажуулан санамжид гарын үсэг /тоон эсхүл бичгэн/ зуруулна.

3.19. Ачаа илгээгч нь тээвэрлүүлэх ачаагаа үндэсний стандартын /ачилтын техникийн нөхцөл/ дагуу баглаж боох, хайрцаг, торхонд хийх, савлаж уутлахаас гадна тоолох боломжтойгоор урьдчилан бэлтгэх үүрэгтэй. Ачааг тээвэрлэлтэд бэлтгэхэд вагонд ачаа ачих, бэхлэх техникийн нөхцөлийн шаардлагыг баримтална.

3.20. Экспортод ачаа тээвэрлэхэд вагоныг гаалийн хяналтын талбайд тавьж ачуулна. Ачаа илгээгч нь гаалийн хяналтын бус талбайгаас ачилт хийлгэх бол гаалийн байгууллагад албан ёсоор хүсэлт гаргана. Гаалийн байгууллагын удирдах ажилтан илгээгчийн хүсэлтийн дагуу гаалийн байцаагч томилж, тэмдгээр баталгаажуулсан тохиолдолд төмөр замын байгууллага вагоныг гаалийн хяналтын бус талбайд тавьж экспортын ачааг ачуулна.

3.21. Аюултай ачааг тээвэрлүүлэхэд ачаа илгээгч нь төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журамд нийцүүлэн вагон, чингэлэг, ачааны байрт аюулын зэрэг, тэмдэглэгээний наадас заавал тавьсан байна.

3.22. Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, вагон ба чингэлэг, ачааг гэмтээхгүй байх, ачих буулгах ажлыг механикжуулах боломжтой нөхцөлийг хангасан байхаар ачааг вагон ба чингэлэгт ачиж бэхэлнэ.

3.23. Вагон ба чингэлэгт ачаа ачихад зайлшгүй шаардагдах бэхэлгээний болон дагалдах хэрэгсэл /ачааг баглах боох утас, модон хаалт, зуух г.м/-ийг илгээгч бэлдэх ба эдгээрийг ачилтыг хариуцан гүйцэтгэж байгаа тал вагонд бэхэлж байрлуулна.

3.24. Нэг вагон ба чингэлэгт өөрийн шинж чанараараа нэг нь нөгөөгөө муутгах, гэмтээх ачааг хамт ачиж болохгүй.

3.25. Вагон ба чингэлэгт ачааг ачихад ачилтын техникийн нормыг баримтална. Ачилтын техникийн норм нь тогтоогдоогүй ачааг вагон ба чингэлгийн багтаамжийг дүүртэл ачих ба даац хэтрүүлж болохгүй.

3.26. Ачааг тээвэрлэлтэд өгөхдөө ачаа илгээгч падаанд ачааны жин, ширхэгийн ачаа бол ачааны байрын тоог заана. Ачааны жинг ачилтыг хариуцан гүйцэтгэж байгаа тал тодорхойлж падаанд заана. Вагон ба чингэлэгт ачсан ачааг жинлэх, стандартын сав баглаатай бол ачааны байр тус бүр дээр заасан жингийн нийлбэрээр тооцоолох эсвэл хэмжих хэрэгсэл ашиглах зэргээр тогтооно. Ачаа илгээгч нь ачааны жинг тодорхойлоход "тооцоолох", "хэмжих", "стандарт хэмжээгээр бодох" зэрэг аргыг хэрэглэнэ.

3.27. Вагонд ачсан ачаа нь өөрийн шинж чанараараа вагоны даацаас хэтэрч болзошгүй, мөн түүнчлэн овоолмог, нурмаг ачааны жинг заавал вагон пүүгээр тодорхойлно. Вагон пүүгүй бол 3.26 заалтыг мөрдөнө.

3.28. Цистернд ачсан шингэн ачааны төвшинг хэмжиж, эзлэхүүнийг нарийн хэмжүүрийн /калибровкийн/ тусгай хүснэгтийг ашиглан ачааны жинг тодорхойлно. Энэ үед илгээгч нь цистерн дэх ачааны төвшний өндөр, тухайн өдрийн температур, нягтыг падаанд тодорхой бичнэ.

3.29. Чингэлэг дэх ачааны жинг илгээгчийн тодорхойлсон жингээр тээвэрлэлтэнд хүлээн авах ба шаардлагатай үед жинлэж болно.

3.30. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааны байр бүрт төмөр замын тэмдэглэгээг /хүртвэрт нь явуулах ачааг тээвэрлэлтэд хүлээж авах дэвтэрт бүртгэсэн дэс дугаарыг бичиж зураас татаад байрын тоог бичиж, хуваарьт нь илгээх өртөөний кодыг бичнэ/ үйлдэнэ.

3.31. Төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий ажилтан нь ачилт хийсэн вагон, чингэлгийг дараах байдлаар шалгаж, энэхүү журмын 3.32-т заасан алдаа дутагдалгүй тохиолдолд ачилтын дэвтэр (цахим, цаасан)-т вагоны дугаар, ломбо, бусад тэмдэглэгээг бүртгэж, хүлээн авна. Үүнд:

3.31.1. Салбар замд ачигдсан вагон, чингэлэгт гадна үзлэг хийж тээвэрт тэнцэх эсэхийг шалгах;

3.31.2. Суурь бүтэц эзэмшигчийн салбар замд ачсан вагон, чингэлгийн хаалга, нээлхий хаагдсан, ломбодсон, ачааны нэр төрөл, тоо, хэмжээ ачилтын захиалгатай тохирч байгаа эсэхийг шалгах;

3.31.3. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачааг техникийн нөхцөл, үндэсний стандартын дагуу ачиж бэхэлсэн, ломбодсон, ачааны нэр төрөл, тоо хэмжээ ачилтын захиалгатай тохирч байгаа эсэхийг шалгах;

3.31.4. Тээвэрлэгчид үл харъяалагдах өөрийн гол дээр тээвэрлэх вагон, чингэлгийн хоосноор тээвэрлүүлэх илгээгчийн захиалга, хүсэлтийг үндэслэн вагон дугаар, ломбоны тэмдэглэгээг шалгах.

3.32 тээвэрлэлтэд тэнцэхгүй сав, баглаа, боодолтой, техникийн нөхцөл, үндэсний стандартын шаардлага хангаагүй ачсан ачааг тээвэрлэлтэд хүлээн авч, явуулахгүй байх ба алдаа дутагдлыг арилгах хүртэл санамжийг хаахгүй нээлттэй хэвээр үлдээнэ.

3.33. Экспортын ачааны падаанд "гаалийн хяналтад байгаа" болон гаалийн байцаагчийн тэмдэг дарагдсан тохиолдолд явуулах өртөөнд тооцооны ажилтан хавсралт бичиг баримтын мэдээллийг үндсэн бичиг баримттай тулгаж шалган вагоны хуудас, санамж, падааныг үндэслэн замын хүснэгт үйлдэж, тээврийн тооцоо хийнэ.

3.34. Илгээх өртөөнд ачаа илгээгч тээвэрлэлттэй холбоотой төлбөрөө төлсний дараа падаан, орлох падааны зохих хүснэгтэд илгээх өртөөний хуанлийн дардас дарж, орлох падааныг ачаа илгээгчид өгнө. Энэ нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан нотолгоо болно.

3.35. Ачаа илгээгчийн хүсэлтээр ачааг тээвэрлэлтэд үнэ зарлаж хүлээн авч болно.

3.36. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачигдсан авто машин, техник болон өөрөө явагч техникийг тээвэрт хүлээн авахдаа тухайн ачааны амархан авагдах эд анги болон ломбоны тоог заасан жагсаалтыг 3 хувь бичүүлж, 1 хувийг нь кабины хэсэгт харагдахуйцаар наана.

3.37. Ачаа илгээгчийн хүсэлтээр ачааг тээвэрлэлтэд үнэ зарлаж хүлээн авч болно.

3.38. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачигдсан авто машин, техник болон өөрөө явагч техникийг тээвэрт хүлээн авахдаа тухайн ачааны амархан авагдах эд анги болон ломбоны тоог заасан жагсаалтыг 3 хувь бичүүлж, 1 хувийг нь кабины хэсэгт харагдахуйцаар наана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ТЭЭВРИЙН БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ

4.1. Тээврийн бичиг баримтад падаан, замын хүснэгт, орлох падаан, нөхөн илгээлтийн бичиг багтана. Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан тээврийн бичиг баримтыг төмөр замаар орон нутгийн харилцаанд ачаа тээвэрлэхэд бүрдүүлж бичнэ. Төмөр замын тээвэрлэлтэд шаардагдах бичиг баримтуудыг бүрдэл болгосны дараа тээврийн бичиг баримтын маягт, хүснэгтийг асуултын дагуу тод, цэвэр гаргацтай, бүрэн гүйцэд, үнэн зөв бичиж гарын үсэг зурж, тэмдэгээр баталгаажуулсан байна. Ачаа илгээгчээс тээвэрлэлтэд шаардагдах падаан болон хавсралт бичиг баримтыг хүлээн авч вагон хуудас, замын хүснэгтийг үйлдэнэ. Дээрх баримтуудыг цахим хэлбэрээр үйлдэж болох бөгөөд энэ тохиолдолд тоон гарын үсгээр баталгаажуулна. Цахим бичиг баримт нь цаасан падаантай адил үнэлэгдэх бөгөөд ижил үүрэг гүйцэтгэнэ.

Нэгдүгээр хүснэгт

Орон нутгийн харилцааны тээврийн баримт бичиг

Д/д	Хуудасны нэр	Хэнд зориулсон	Хуудасны зориулалт
1	Эх падаан	Хүлээн авагчид	Ачааг хүрэх өртөө хүртэл дагалдана.
2	Орлох падаан	Илгээгч	Тээвэрлэлтийн гэрээ хийж дуусмагц ачаа илгээгчид олгоно.
3	Замын хүснэгт	Тээвэрлэгчид	Ачааг хүрэх өртөө хүртэл дагалдана.
4	Замын хүснэгтийн үлдэх хувь	Тээвэрлэгчид	Ачааг тээвэрт хүлээн авсан өртөөнд

4.2. Төмөр замаар орон нутгийн харилцаанд ачааг тээвэрлэх тээврийн бичиг баримт нь дараах баримтуудаас бүрдэнэ:

4.2.1. "Падаан" нь ачаа илгээгч тээвэрлэгчийн хооронд байгуулсан гэрээ болно. Ачаа илгээгч нь нүүрэн талын тод шугамаар хүрээлсэн хэсгийг бичиж тээвэрлэгчид хүлээлгэж өгнө. Энэ падаан нь хүрэх өртөө хүртэл ачааны хамт дагалдан очиж хүлээн авагчид олгогдоно. Энэ олголтоор тээвэрлэлтийн гэрээ дуусгавар болно.

4.2.2. "Замын хүснэгт" нь замын хүснэгт, замын хүснэгтийн үлдэх хувь гэсэн хоёр хуудаснаас бүрдэнэ. Падааныг үндэслэж замын хүснэгтийг үйлдэх бөгөөд эх хувь нь тээвэрлэгчид үлдэж хүрэх өртөөнд ачааны хамт очно. Ачааг олгох өртөө нь ачаа олгосон тухай замын хүснэгтийн зохих хүснэгтэд тэмдэглэл хийж ачаа хүлээлцсэнийг нотлож хүлээн авагчаар гарын үсэг зуруулна. Замын хүснэгтийн эх хувийг буулгалтын тайлантай үлдвэр хувийг ачилтын тайлантай тус тус тээвэрлэгчийн санхүү бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллагад явуулна.

4.2.3. "Орлох падаан" нь ачааг тээвэрлэгч тээвэрт хүлээн авсныг нотлох баримт болно. Орлох падааныг ачаа илгээгч, падааны хамт бөглөж тээвэрлэгчид өгнө. Орлох падааны тод хар хүснэгт дэх асуултуудыг ачаа илгээгч бөглөнө. Орлох падаанд илгээх өртөөний хуанлийн дардас дарж тээвэрлэгч нь ачаа илгээгчид өгнө.

4.3. Тээврийн бичиг баримт засвартай балласан байж болохгүй. Тээвэрлэгч тээврийн бичиг баримтад өөрчлөлт хийх бол гарын үсэг болон өртөөний тэмдгээр баталгаажуулсан байна.

4.4. Падаан, орлох падааныг ачаа илгээгч үнэн зөв бичсэн эсэхийг тээвэрлэгч шалгах үүрэгтэй.

4.5. Тээвэрлэгч тээврийн бичиг баримтын маягтаар ачаа илгээгчийг хангана.

4.6. Падаан, орлох падаан, замын хүснэгт, замын хүснэгтийн үлдвэрийн бүх асуултуудыг үнэн зөв бөглөх бөгөөд тэдгээрт зориулагдсан хүснэгтэд багтаан бичнэ. Падааныг орлох падаантай, замын хүснэгтийг замын хүснэгтийн үлдвэртэй хамт бичнэ.

4.7. Дараах ачаанд нэг тээврийн бичиг баримт үйлдэж болохгүй. Үүнд:

4.7.1. Өөрийн шинж чанараар нэг вагонд тээвэрлэж болохгүй ачаануудад,

4.7.2. Урьдчилан сэргийлэх тусгай нөхцөл сахих шаардлагатай ачаануудад,

4.7.3. Ариун цэвэр, мал эмнэлэг болон бусад журмыг сахих шаардлагатай ачаануудад.

4.8. Тогтмол дулаант тусгай зориулалтын вагонд хялбар муудах ачааг тээвэрлэхэд ачааны вагон бүрт тээврийн бичиг баримт үйлдэнэ.

4.9. Тээврийн бичиг баримтын хүснэгт бүрт код бичихэд зориулагдсан тусгай нүд байна.

4.10. Ачаа илгээгч, тээвэрлэгч тээврийн бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

4.10.1. Илгээгч орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримтын 2, 10-18, 21-24 хүснэгтийг доорх байдлаар бичнэ;

4.10.2. Тээврийн бичиг баримтын "2. Хурд" хүснэгтэд "их", буюу "бага" "суудлын" гэж бичнэ. Тухайн илгээлтийн ачаа их хурдтай тээвэрлэгдэж байвал тээврийн бичиг баримтын дээд, доод ирмэг нь улаан өнгийн эмжээртэй байна;

4.10.3. Тээврийн бичиг баримтын "10. Явуулах өртөө" хүснэгтэд тээвэрлэгчийн тарифт заасан илгээх өртөөний бүтэн нэрийг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд өртөөний кодыг бичнэ;

4.10.4. Тээврийн бичиг баримтын "11. Хүрэх өртөө" хүснэгтэд тээвэрлэгчийн тарифт заасан хүрэх өртөөний бүтэн нэрийг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд өртөөний кодыг бичнэ;

4.10.5. Тээврийн бичиг баримтын "12. Илгээгч, түүний хаяг" хүснэгтэд илгээгчийн нэр ба түүний шуудангийн хаягийг товчлолгүйгээр тодорхой заана. Илгээгч нь иргэн буюу хуулийн этгээд байх бол түүний регистр, утасны дугаарыг бичнэ;

4.10.6. Тээврийн бичиг баримтын "13. Хүлээн авагч, түүний хаяг" хүснэгтэд хүлээн авагчийн нэр ба түүний шуудангийн хаягийг товчлолгүйгээр тодорхой заана. Хүлээн авагч нь иргэн буюу хуулийн этгээд байх бол түүний регистр, утасны дугаарыг бичнэ;

4.10.7. Тээврийн бичиг баримтын "14. Илгээгчийн марк, тэмдэг" хүснэгтэд тээвэрт хүлээлгэн өгөх ачаан дээр илгээгчийн марк тэмдэглэлийг хийсэн бол тухайн марк тэмдгийг заана. Ачааг чингэлгээр болон хоосон чингэлэг тээвэрлэх бол чингэлгийн төрөл, сери, дугаарыг бичнэ;

4.10.8. Тээврийн бичиг баримтын "15. Байрын тоо" хүснэгтэд илгээлтэд орсон ачааны байрны тоог зааж бичнэ. Хэрэв илгээлтийг чингэлгээр тээвэрлэвэл хүртвэрт чингэлгийн тоо, даацыг хуваарьт чингэлэгт орсон ачааны байрын тоог бичнэ. Хэрэв задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны байрын тоо 100-гаас дээш бол "овоолмог", нурмагаар ачсан бол "нурмаг", юулж ачсан шингэн ачааг "юүлмэг" гэж тус тус заана. Ачааг ачмагаар ачихад хүртвэрт ачмагийн тоог, хуваарьт нэг ачмагт орсон ачааны ширхэгийн тоог бичнэ;

4.10.9. Тээврийн бичиг баримтын "16. Баглааны төрөл" хүснэгтэд ачааны сав, боодлын төрлийг заана. Жишээ нь: "хайрцаг", "торх", "сагс", "ачмаг" г.м. Ачааг чингэлгээр тээвэрлэвэл хүртвэрт "чинг" хуваарьт чингэлэгт ачсан ачааны сав, баглааны төрлийг заана;

4.10.10. Тээврийн бичиг баримтын "17. Ачааны нэр" хүснэгтэд ачааны нэрийн нэгдсэн жагсаалт болон тарифт заасан ачааны нэрийг тодорхой зааж бичнэ. Тээвэрлэлтийн хэрэгсэл ашиглаж ачилт хийх үед ачааны нэрийн дор тусдаа мөрөнд хэрэглэсэн тээвэрлэлтийн хэрэгслийн нэр болон тоог бичнэ. Мөн ачааг илгээгчийн үйлчлэгчтэй тээвэрлэх үед үйлчлэгчийн нэр, регистрийн дугаарыг бичнэ. Цистерн болон бункерт вагонд шингэн ачаа тээвэрлэвэл ачааны өндөр, нягтрал, ачааны хэм зэргийг бичнэ. Чингэлэгтэй ачаа болон хоосон чингэлэг тээвэрлэвэл "чинг/ачааны нэр", "хоосон чинг" гэж бичнэ. Аюултай ачаа тээвэрлэвэл тухайн ачааны ослын картын дугаар, аюултай ачааны мэдэгдэл, ачааны шифрийг ачааны нэрийн дор бичнэ;

Зөвлөмж: ангиллын шифр 2112. Хэтрүү овортой ачаа бол оврийн индексийг бичнэ, жишээ нь индекс н-2230. Ачаа эзэмшигчийн буюу түрээсийн вагонд ачаа эзэмшигчийн зүтгүүрээр ачаа тээвэрлэвэл ачааны нэрийн дор "эзэмшигчийн вагонд", "түрээсийн вагонд", "ачаа эзэмшигчийн зүтгүүртэй вагонд" гэх мэтээр зааж бичнэ. Тээвэрлэгчийн хөдлөх бүрэлдэхүүн, вагоныг тоноглон ачаа тээвэрлэвэл энэ тухай /нэр, тоо, жин/ бичнэ. Энэхүү журамд тарифын мөрдлөг, ачаа байрлуулах болон бэхлэх техникийн нөхцөлд дурдсан бусад мэдээллийг заана. Хэрэв эдгээр мэдээллүүд нь энэхүү хүснэгтэд багтахгүй бол падааны "илгээгчийн тэмдэглэл" хүснэгтэд бичнэ. Энэхүү хүснэгтийн баруун дээд буланд ачааны кодыг бичнэ;

4.10.11. Тээврийн бичиг баримтын "18. Ачааны жин" хүснэгтэд ачааны жинг илгээгч тодорхойлсон бол илгээгч, төмөр замын байгууллага тодорхойлсон бол төмөр зам гэсэн зохих хүснэгтийг бичнэ. Чингэлэг, ачмаг буюу тээвэрлэлтийн бусад хэрэгсэл ашиглаж тээвэрлэх бол тэдгээрийн жин болон нийт жинг зааж бичнэ. Нэг илгээлтээр зөвшөөрөгдсөн хэд хэдэн ачаа тээвэрлэвэл ачаа тус бүрийн жин болон нийт жинг бичнэ;

4.10.12. Тээврийн бичиг баримтын "21. Байрын тоо" /үсгээр/ хүснэгтэд тээврийн бичиг баримтын 18-р хүснэгтэд бичсэн байрын тоог үсгээр бичих буюу нурмаг, овоолмог, юүлмэг гэж байвал тэдгээрийг бичнэ;

4.10.13. Тээврийн бичиг баримтын "22. Жингийн дүн" /үсгээр/ хүснэгтэд тээврийн бичиг баримтын 21-р хүснэгтэд заасан жингийн дүнг үсгээр бичнэ;

4.10.14. Тээврийн бичиг баримтын "23. Жинг тодорхойлсон арга" хүснэгтэд жинг пүүлж эсвэл жинг тооцоолох аргаар тодорхойлсон аль нь болохыг бичнэ;

4.10.15. Тээврийн бичиг баримтын "24. Илгээгчийн төлөөлөгч" хүснэгтэд тээврийн бичиг баримтад бичсэн зүйлийн үнэн зөвийг баталж илгээгчийн төлөөлөгч нэрээ бичиж, гарын үсэг зурна.

4.11. Тээвэрлэгч орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримтын хүснэгтийг доорх байдлаар бичнэ: /1, ачаа хүргэх хугацаа, 3-9, 19-20, 25-32, тээвэрлэлтийн зай, 34-48/

4.11.1. Тээврийн бичиг баримтын "1. Онцгой тэмдэглэл" хүснэгтэд тээвэрлэлтийн үед онцгой нөхцөл шаардагдан тээвэрлэдэг мэдэгдлүүдийг бичнэ. Жишээ нь: "хамгаалалт", "нөхөн илгээлт", "довоос буулгаж болохгүй", "халхлалттай", "түргэн гэмтэх" гэх мэт;

4.11.2. Тээврийн бичиг баримтын "3. Илгээлтийн төрөл" хүснэгтэд "| вагон | чингэлэг | жижиг |" эдгээр бичээсээс хэрэггүй зүйлийг чагталж дарна. Бүтэн вагоноор тээвэрлэх ачааг вагон илгээлтээр бол вагон, тусдаа вагон шаардлагагүй 5000 кг –аас бага жинтэй ачаа жижиг илгээлтээр бол "жижиг", чингэлэгт ачсан ачааг чингэлгийг илгээлтээр "чингэлэг" гэж тус тус бичнэ;

4.11.3. Тээврийн бичиг баримтын "4. Төлөвлөгөөт гэрээний №" хүснэгтэд өртөөнд хөтөлж байгаа сарын төлөвлөгөө гэрээ буюу захиалгын дугаарыг заана;

4.11.4. Тээврийн бичиг баримтын "5. Ачихыг зөвшөөрсөн" хүснэгтэд ачааг ачихыг зөвшөөрч огноог зааж тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргын нэрийг бичнэ.

4.11.5. Тээврийн бичиг баримтын "6. Вагоны дугаар" хүснэгтэд вагоны арал дээрх дугаар болон вагон эзэмшигчийн товчилсон нэрийг бичнэ;

4.11.6. Тээврийн бичиг баримтын "7. Вагоны төрөл" хүснэгтэд

Битүү вагоныг	кр
Хагас вагоныг	пв
Тавцант вагоныг	пл
Цистерн вагоныг	цс
Чингэлэг тээвэрлэгчийг	кт
Хоппер вагоныг	хп
Бусад төрлийн вагоныг	пр гэж тус тус тэмдэглэнэ.

4.11.7. Тээврийн бичиг баримтын "8. Даац" хүснэгтэд вагоны ханан дээр бичсэн даацыг бичнэ;

4.11.8. Тээврийн бичиг баримтын "9. Голын тоо" хүснэгтэд тухайн ачаа тээвэрлэх вагоны голын тоог бичнэ;

4.11.9. Тээврийн бичиг баримтын "19. Төмөр замын марклал" хүснэгтэд тээвэрт хүлээн авч байгаа ачаан дээр төмөр зам марклал хийсэн бол түүнийг бичнэ. Хийгээгүй бол бөглөхгүй;

4.11.10. Тээврийн бичиг баримтын "20. Ачаалсан ачаалалтын техникийн норм" хүснэгтэд ачааг төмөр замын байгууллага ачаалсан бол "төмөр зам", илгээгч ачаалсан бол "илгээгч" гэж бичнэ. Мөн ачаа ачилтын техникийн нормыг тонноор заана;

4.11.11. Тээврийн бичиг баримтын "25. Илгээхэд хураасан" хүснэгтэд ачааг илгээхэд хураасан хураамжийн дүнг үсгээр бичнэ;

4.11.12. Тээврийн бичиг баримтын "26. Тооцооны хэлбэр" хүснэгтэд ачаа илгээх үед тооцоог бэлэн мөнгөөр хийсэн бол "бэлнээр", "бэлэн бусаар" хийсэн бол чек болон шилжүүлгийн дугаарыг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд кодыг бичнэ;

4.11.13. Тээврийн бичиг баримтын "27. Тооцооны ажилтан" хүснэгтэд ачаа илгээх үед тээврийн хөлсний тооцоо хийсэн ажилтан нэрийг бичнэ;

4.11.14. Тээврийн бичиг баримтын "28. Олгоход хураасан" хүснэгтэд ачаа олгох үед хураасан хураамжийн дүнг үсгээр бичнэ;

4.11.15. Тээврийн бичиг баримтын "29. Тооцооны хэлбэр" хүснэгтэд ачаа олгох үед тооцоог бэлэн мөнгөөр хийсэн бол "бэлнээр", "бэлэн бусаар" хийсэн бол чек болон шилжүүлгийн дугаарыг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжинд кодыг бичнэ;

4.11.16. Тээврийн бичиг баримтын "30. Тооцооны ажилтан" хүснэгтэд ачаа олгох үед тээврийн хөлсний тооцоо хийсэн тооцооны ажилтан нэрээ бичиж гарын үсэг зурна;

4.11.17. Тээврийн бичиг баримтын "31. Хавсаргасан баримтууд" хүснэгтэд ачаа илгээгчийн тээврийн бичиг баримтанд хавсаргасан бүх дагалдах баримтыг зааж хавсаргахаас гадна хаягдал төмөрт тэсэрч дэлбэрэх зүйлгүй гэсэн тодорхойлолт, мал амьтанд мал эмнэлгийн бичиг, ургамлын гаралтай ачаанд ургамал хорио цээрийн бичиг, мод модон материалд байгаль орчны байцаагчийн зөвшөөрөл, хүнсний хялбар муудах ачаанд чанарын тодорхойлолт, баталгаа зэргийг тээвэрлэгч илгээгчээс шаардаж хавсаргана;

4.11.18. Тээврийн бичиг баримтын "32. Тарифын бүлэг" хүснэгтэд тарифын мөрдлөгт заасан тухайн ачааны бүлгийг заана;

4.11.19. Тээврийн бичиг баримтын "тээвэрлэлтийн зай" хүснэгтэд тээврийн хөлсийг тарифын хамгийн богино зайгаар бодож тооцоолсон зайг бичнэ;

4.11.20. Тээврийн бичиг баримтын "34. Илгээх үед" хүснэгтэд ачааг илгээх үед хураасан тээврийн хөлс, бусад хөлс хураамжийн дүн болон бүгд дүнг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжин дотор кодыг бичнэ;

4.11.21. Тээврийн бичиг баримтын "35. Олгох үед" хүснэгтэд ачааг олгох үед хураасан тээврийн хөлс, бусад хөлс хураамжийн дүн болон бүгд дүнг бичнэ. Хүснэгтийн дээд булан дахь дөрвөлжин дотор кодыг бичнэ;

4.11.22. Тээврийн бичиг баримтын "36. Ачих бэхлэх тухай" хүснэгтэд ачааны ачилтыг хариуцан хийсэн байгууллага энэ хүснэгтийг бичнэ. Вагонд ачааг ямар зураг техникийн нөхцөл, үндэсний стандартыг баримталж ачиж бэхэлснийг зааж, ачилтыг хариуцан хийлгэсэн албан тушаалтан түүний үнэн зөвийг баталж нэрээ бичиж гарын үсэг зурна;

4.11.23. Тээврийн бичиг баримтын "37. Ломбоны тухай тэмдэглэл" хүснэгтэд тээвэрлэгч, илгээгчийн аль ломбодсон нь вагон, чингэлэг, автотехник, битүүмжилсэн ачаанд тавьсан ломбоны тоо, хяналтын тэмдэг, ломбыг хаана зүүснийг тус тус зааж бичнэ;

4.11.24. Тээврийн бичиг баримтын "38. Төмөр замын тэмдэглэл" хүснэгтэд тээвэрлэлтийн явцад өртөөдөд гарсан саатал, сэлгэн ачилт хийсэн, ачааны бэхэлгээг зассан гэх мэт тэмдэглэгээг зааж бичнэ;

4.11.25. Тээврийн бичиг баримтын "39. Илгээгчийн тэмдэглэл" хэрвээ илгээгч ачааг үнэ зарлалттай тээвэрт хүлээлгэн өгсөн бол үнэ зарласан тухай тэмдэглэл хийх бөгөөд энэ тохиолдолд холбогдох тарифт заасны дагуу хураамж төлнө. Мөн энэ хүснэгтэд хүснэгтэд илгээгч зөвхөн ачаа хүлээн авагчид хамааралтай бусад тэмдэглэлийг хийнэ. Энэ нь төмөр замд ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээлгэхгүй. Жишээ нь: тээврийн бичиг баримтад засвар хийсэн тухай, үнэ зарлалттай ачаанд үнэ зарлалгүй тээвэрт хүлээлгэж өгсөн, түргэн гэмтэх ачааны

тээвэрлэлтийн нөхцөл зэргийг зааж бичнэ. Мөн ачааг хаана, хэнд яаж олгох, ямар зам дээр олгох гэх мэт заалтыг илгээгч бичнэ;

4.11.26. Тээврийн бичиг баримтын "40. Актын тухай тэмдэглэл" хүснэгтэд тээврийн болон ерөнхий маягтын акт тогтоох үед бичнэ. Тээврийн акт тогтоосон огноо, актын дугаар, ачааны ямар байдал /дутсан, гэмтсэн, муудсан/-д тогтоосныг бичнэ. Ерөнхий маягтын акт тогтоосон бол актын дугаар, огноог бичнэ;

4.11.27. Тээврийн бичиг баримтын "41. Хаяг сольсон тухай тэмдэглэл" хүснэгтэд ачааны хаяг соливол хэдийд ямар шийдвэрээр хаяг сольсон тухай бичнэ. Шийдвэр өгсөн хүний албан тушаалыг товчилсон байдлаар, шийдвэрийн дугаар, огноог тооцооны ажилтан бичнэ;

4.11.28. Тээврийн бичиг баримтын "42. Вагоныг буулгалтад тавьсан он, сар, өдөр, цаг" хүснэгтэд вагоныг салбар замд вагон тавьж өгөх, татаж авах гэрээгээр буулгалтад тавьж санамж нээсэн огноо, цагийг бичнэ. Тооцооны ажилтан санамжийг үндэслэн бичнэ;

4.11.29. Тээврийн бичиг баримтын "43. Вагон, буулгаж дууссан он, сар, өдөр, цаг" хүснэгтэд вагон чингэлгийг буулгаж дууссан огноог тээвэрлэгчийн эрх бүхий ачаа тээврийн ажилтны мэдэгдлээр тооцооны ажилтан санамжийг үндэслэн бичнэ;

4.11.30. Тээврийн бичиг баримтын "44. Ачааг олгох үед хийсэн тэмдэглэл" хүснэгтэд ачааг ямар байдалтай олгосон тухай тэмдэглэлийг хийнэ. Ачааг бүрэн бүтэн олгосон бол "ачааг бүрэн бүтэн олгосон" гэсэн тэмдэглэлийг хийнэ. Хэрэв олгох үед ачаа дутсан гэмтсэн муудсан бол тэр хэсгийг шалгаж ямар байдлаар олгосныг тогтоож тээврийн буюу ерөнхий маягтын акт тогтоож олгох ба хүрэх өртөөнд тогтоосон актын дугаарыг бичнэ;

4.11.31. Тээврийн бичиг баримтын "45. Илгээх өртөөний хуанлийн тэмдэг" хүснэгтэд илгээх өртөөний хуанлийн дардсыг тооцоо хийсэн тооцооны ажилтан тод дарсан байна;

4.11.32. Тээврийн бичиг баримтын "46. Хүрэх өртөөний хуанлийн тэмдэг" хүснэгтэд хүрэх өртөөний хуанлийн дардсыг ачааг өртөөнд ирмэгц хүрэх өртөөний тээврийн бичиг баримт хүлээн авч буй албан тушаалтан харагдахуйцаар дарна;

4.11.33. Тээврийн бичиг баримтын "47. Ачаа ирсэн тухай мэдэгдэл" хүснэгтэд ачаа ирмэгц төмөр замаар ачаа тээвэрлэх журамд заасны дагуу ачаа хүлээн авагчид мэдэгдээд хэнд, ямар утсаар, хэзээ мэдэгдсэн тухай тэмдэглэлийг хийнэ;

4.11.34. Тээврийн бичиг баримтын "48. Ачаа олгосон тухай тэмдэглэл, хуанлийн тэмдэг" хүснэгтэд хүлээн авагчид ачаа олгосон болон падаан /тээвэрлэлтийн гэрээний үндсэн баримт/ хүлээлгэж өгснийг нотлох баримт болгож хүрэх өртөөний хуанлийн дардас дарж, ачаа хүлээн авагч нэрээ бичиж гарын үсгээ зурна. Ачаа хүрэх өртөөний тооцооны ажилтан энэхүү хүснэгтийн тэмдэглэлийг заавал хийлгэх ба хийлгээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.11.35. Тээврийн бичиг баримтын "49. Дамжин өнгөрөх төмөр замын хуанлийн тэмдэг" хүснэгтэд хуанлийн тэмдэг дарна.

4.12. Нөхөн илгээлтийн бичиг баримтыг дараах тохиолдолд үйлдэнэ:

4.12.1. Олон улсын болон орон нутгийн харилцаанд тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэж байгаа хэд хэдэн вагоноос техникийн болон ачаа тээврийн зөрчил, бусад шалтгаанаар үндсэн бичиг баримтаас саатуулах тохиолдолд саатуулагдсан вагонд, мөн зам зуурын өртөөнд нэг вагоны ачааг 2 вагонд шилжүүлэн ачих тохиолдолд 2 дахь вагонд нөхөн илгээлтийн бичиг баримт үйлдэнэ;

4.12.2. Нөхөн илгээлтийн бичиг баримтад замын хүснэгтийг бөглөх бөгөөд замын хүснэгт нь ачааг дагалдаж хүрэх өртөөнд очно. Замын хүснэгтийн үлдэх хувь нь ачааг тээвэрлэгчид буюу нөхөн илгээлтийг хийсэн өртөөнд үлдэж тайланд оруулж тээвэрлэгчийн санхүү хариуцсан эрх бүхий байгууллагад хүргэгдэнэ.

4.13. Нөхөн илгээлтийн замын хүснэгтийг дараах байдлаар бөглөнө. Үүнд:

4.13.1. Замын хүснэгтийн "онцгой тэмдэглэл" хүснэгтэд "нөхөн илгээлт" гэж харагдахуйц бичнэ;

4.13.2. "онцгой тэмдэглэл" хүснэгтийг үндсэн илгээлтээс авч бичнэ;

4.13.3. "хурд" хүснэгтэд "их, бага" буюу суудлын" гэж бичнэ;

4.13.4. Замын хүснэгтийн 3-5 дахь хүснэгтийг бөглөхгүй;

4.13.5. Замын хүснэгтийн 6-9 дэх хүснэгтийг энэхүү журмын 4.11.6 -4.11.9-т заасныг баримтлан бичнэ;

4.13.6. "илгээх өртөө" хүснэгтэд нөхөн илгээлт үйлдсэн өртөөний нэрийг бичнэ;

4.13.7. "хүрэх өртөө" хүснэгтийг энэхүү журмын 4.10.4-д зааснаар бичнэ;

4.13.8. "илгээгч, түүний хаяг" хүснэгтэд "өртөөний дарга" гэж бичнэ. /нөхөн илгээлт үйлдсэн өртөөний дарга байна/;

4.13.9. "хүлээн авагч, түүний хаяг" хүснэгтэд "өртөөний дарга" буюу "дс" гэж бичнэ. Энэ нь хүрэх өртөөний дарга байна;

4.13.10. "ачааны нэр" хүснэгтэд "ачаа хүлээн авагчийн нэр, хаяг, үндсэн илгээлтийн дугаар"-ыг бичнэ. Мөн тээврийн акт, ерөнхий маягтын акт, ломбоны тухай бичнэ;

4.13.11. "илгээх өртөөний хуанлийн дардас" хүснэгтэд нөхөн илгээлт хийсэн өртөөний хуанлийн дардсыг нөхөн илгээлт хийсэн огноогоор дарна;

4.13.12. Нөхөн илгээлтийн замын хүснэгтийн 46, 47, 48 дахь хүснэгтийг энэхүү журмын 3.11.32, 4.11.33, 4.11.34-д заасны дагуу хүрэх өртөөнд бөглөнө;

4.13.13. Энэхүү журмын 4.13.1-4.13.12-т заагдаагүй нөхөн илгээлтийн замын хүснэгтийн өгөгдлүүдийг бөглөхгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР БҮЛЭГ ВАГОНЫГ ТЭЭВРИЙН НЭГ БИЧИГ БАРИМТААР ТЭЭВЭРЛЭХ

5.1. Илгээх өртөө, илгээгч, хүлээн авагч нь ижил, нэг төрлийн ачаатай бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар орон нутгийн харилцаанд тээвэрлэхэд энэ журмыг мөрдлөг болгоно.

5.2. Бүлгээр тээвэрлэгдэх ачааны тээврийн бичиг баримтад дагалдах хүснэгтийг хавсаргана.

5.3. Орон нутгийн харилцаанд нэг төрлийн ачаатай бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар ачаа илгээгчийн захиалгын дагуу тээвэрт хүлээн авна:

5.3.1. Нэг төрлийн ачаатай бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрт хүлээн авахдаа тээврийн бичиг баримтын 7-10 дахь хүснэгтэд "хавсралт хүснэгтийг үз" гэсэн бичилтийг хийнэ;

5.3.2. Бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэхдээ падааны хавсралт хүснэгтийг илгээгчээр бичүүлж илгээх өртөө хуанлийн дардас дарна;

5.3.3. "бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэх хүснэгт" нь тээврийн бичиг баримтын салшгүй хэсэг байх ба падаан, орлох падаан, замын хүснэгт болон замын хүснэгтийн үлдвэрт тус тус хавсаргана;

5.3.4. Тээврийн бичиг баримтын ачааны жин буюу 18 дахь хүснэгтэд тухайн бүлэг вагоны ачааны нийт жинг бичнэ;

5.3.5. Аяллын явцад тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэж байгаа бүлэг вагоноос техникийн болон ачаа тээврийн зөрчлөөр салах тохиолдолд хавсралт хүснэгтэд дурдсан салсан вагоны дугаарыг уншигдахаар дараад “38. Төмөр замын тэмдэглэл” хүснэгтэд актын дугаар болон ямар шалтгаанаар салсныг бичиж акт тогтооно;

5.3.6. Вагон салгасан өртөө нь уг вагоныг нөхөн илгээлтээр үндсэн илгээлтийн араас явуулахын тулд бүх холбогдох мэдээллийг актнаас авч нөхөн илгээлтийн замын хүснэгтэд бичнэ;

5.3.7. Тээврийн актын тухай үндсэн бичиг баримтад тэмдэглэл хийж актыг хавсаргаж явуулна;

5.3.8. Бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрлэх явцад хавсралт хүснэгтүүд үрэгдсэн тохиолдолд хүснэгтийг нөхөн хийж явуулна. Хүснэгтийг нөхөн хийсэн өртөө хуанлийн дардсыг дарна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРТ ЗАДГАЙ ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ДЭЭР АЧАА ТЭЭВЭРЛЭХ

6.1. Задгай хөдлөх бүрэлдэхүүн /хагас вагон, тавцант вагон, хоппер дозатор, думкар, транспортер/ дээр ачих ачаа нь тээвэрлэгчийн зөвшөөрч батлагдсан ачаа байна.

6.2. Хур тунадасны нөлөө болон гадны хүчин зүйлээс болж гэмтэх, устах, вагоны эд ангийг гэмтээх, зам төмрийн хэлхээг таслах, ослын нөхцөл байдал бий болгохуйц шинж чанартай ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэхгүй.

6.3. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачих ачааны нэрийн жагсаалтыг тээвэрлэгч гаргана.

6.4. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачааг дараах нөхцөлөөр тээвэрлэнэ:

6.4.1. Хэмжээ, жингээрээ бусад төрлийн вагон, чингэлэгт тээвэрлэх боломжгүй савтай, ширхэгийн ачаа эсвэл хур тунадаснаас хамгаалах шаардлагагүй нурмаг ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэнэ;

6.4.2. Ачааны шинж чанар, түүнийг ачиж буулгах төхөөрөмжөөс хамааран ачаа илгээгч хөдлөх бүрэлдэхүүнийг сонгоно;

6.4.3. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачааг ачиж бэхлэх техникийн нөхцөл, ачиж буулгах ерөнхий шаардлагуудыг баримтлан, вагоны бүрэн бүтэн байдлыг хангаж ачна;

6.4.4. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачих ачаа нь техникийн нөхцөл, ачааны бүрэн бүтэн байдлыг хангахуйц сав, баглаа, боодолтой байна. Сав, баглаа, боодол, хучлага нь амархан шатах материалаар хийгдсэн байж болохгүй;

6.4.5. Аюултай ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачихад төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг баримтална;

6.4.6. Аюултай ачааны жагсаалтад багтсан хар болон өнгөт металл, тэдгээрийн хайлшны хаягдал, үлдэгдлийг задгай хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэхэд аюултай ачаа тээвэрлэх үндэсний стандартын шаардлага хангасан байна. Өнгөт металл болон тэдгээрийн хайлшны хаягдал, үлдэгдлийг 300 кг-аас багагүй жинтэйгээр шахаж багцлах буюу тусгай чингэлэгт тээвэрлэнэ;

6.4.7. Жижиг ширхэглэл агуулсан ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачихын өмнө хүрээлэн байгаа орчныг бохирдуулахгүй, уг ачааны хорогдолгүй гэсэн баталгааг ачаа илгээгч гаргаж өгнө. Хагас болон тавцант вагоны хийцийн завсраар ачаа асгарч гоожихоор байвал ачаа илгээгч ачааны бүрэн бүтэн байдлыг хангах нэмэгдэл арга хэмжээг авна;

6.4.8. Жижиг ширхэглэл агуулсан ачааг малгайлж ачихад ачааг хийсэх, нурахаас сэргийлж вагоны тэвшийг өндөрлөн тоноглож ачна. Ачаа илгээгч тоноглолын хийцийг ачааны төрлөөр нь гаргаж өгнө. Баяжуулах үйлдвэрт ялгалтад явж байгаа ачааны гадаргууг /ялгасан буюу ердийн

нүүрснээс/ бусад бүх тохиолдолд ачаа илгээгч тээвэрлэлтийн нөхцөлд заасны дагуу чигжиж нягтруулж ачна. Энэ нөхцөлд малгайлалт нь трапец хэлбэртэй нуруулдаж ачсан байна. Малгайлалтын доод нягтруулсан хэсэг нь вагоны тэвшний дээд ирмэгээс илүү гарахгүй;

6.4.9. Ачааг нягтруулах, чигжихэд механикжсан болон бусад аргыг хэрэглэж болно;

6.4.10. Эрдэс, барилгын материалыг вагоны тэвшнээс дээш гарган ачих тохиолдолд малгайлалтын доод суурийн хэсэг нь вагоны тэвшний дээд ирмэгээс доош 50 мм-ээс багагүй зайд байна;

6.4.11. Ачааны нягтруулалтыг механик болон бусад аргаар хийхэд ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР НУНТАГ, НУРМАГ БА ОВООЛМОГ АЧАА ТЭЭВЭРЛЭХ

7.1. Төмөр замаар тээвэрлэгдэх нунтаг, нурмаг ба овоолмог ачааны жагсаалтыг тээвэрлэгч тогтооно. "нунтаг, нурмаг ба овоолмог" ачаа гэж үр тариа, нүүрс, жонш гэх мэт ачааны тоо, ширхэг, байрын тоог тогтоох боломжгүй ачааг хэлнэ.

7.2. Нунтаг, нурмаг ба овоолмог ачааны шинж чанар, баглаа, боодлоос хамааран тээвэрлэх хөдлөх бүрэлдэхүүний төрлийг сонгоно.

7.3. Нэг вагонд овоолмогоор тээвэрлэхээр мэдүүлсэн ачааны байрын тоо 100 ширхэгээс их болон байрын тоог тодорхойлох боломжгүй ачааг овоолмогоор хүлээн авна.

7.4. Хур тунадас, чийг ба тоос шорооноос хамгаалах шаардлагатай ачаа /гурил, үр тариа, цемент, эрдэс бордоо зэрэг/-г тусгай зориулалтын битүү вагон, тусгай зориулалтын чингэлэгт тээвэрлэнэ. Баглаа, боодолтой овоолмог ачааг тээвэрлэхэд битүү вагон ашиглаж болно. Битүү вагонд овоолмогоор тээвэрлэх ачааг илгээгч хаалганы хаалтыг тавьж суурилуулсан тохиолдолд тээвэрлэнэ. Битүү вагоны хаалганд овоолмог ачааг зайлуулахаар нурахаас хамгаалж хаалга хоорондын хөндийд сараалж, самбар, хаалт, хашлагыг бат бөх материалаар чанартай хийнэ.

7.5. Хур тунадас, чийгнээс хамгаалах шаардлагагүй ачааг тусгай зориулалтын вагон /думпкар, хоппер-дозатор зэрэг/-д нунтаг, нурмаг ба овоолмогоор тээвэрлэнэ. Тусгай зориулалтын вагонд ачааг тээвэрлэх ба түүн дотор битүү тэвштэй хагас вагон бол төмөр замын тээврийн бичиг баримтны "илгээгчийн тэмдэглэл" хүснэгтэд "тусгай зориулалтын вагонд /ачааны нэрийг заана/ тээвэрлэхээр хүлээн авагчтай тохиролцсон. Буулгах тоног төхөөрөмжтэй." гэж тэмдэглэнэ.

7.6. Нунтаг, нурмаг ачаа тээвэрлэх вагоны тэвш, ачих буулгах төхөөрөмж, нээлхийн тагийг ачаа гоожиж, асгарахгүйгээр нягт шахаж хаасан байна. Урьд тээвэрлэсэн ачааны үлдэгдлийг бүрэн цэвэрлэсэн, ломбодож битүүмжлэх төхөөрөмж нь гэмтэлгүй, нээлхий онгойхоос хамгаалсан төхөөрөмжийг хаасан байна. Нунтаг, нурмаг ачааг ачихын өмнө илгээгч ачаа гоожихгүй байхаар вагоныг чигжиж битүүлнэ.

7.7. Улсын мал эмнэлэг, хорио цээрийн хяналтан дор тээвэрлэх ачааг 10 дугаар бүлэг /хорио цээртэй ачааг тээвэрлэх/-т зааснаар тээвэрлэнэ.

7.8. Үр тариа зэрэг чийгшилтэй тээвэрлэгдэх ачааг үндэсний стандартыг баримтлан тээвэрлэнэ.

Зөвлөмж: үр тарианы тээвэрлэлтийг 17 хувь хүртэлх чийгшлээр нь тооцно. Үүнд: үр тариа, шошны төрлийн ургамал-17 хувь хүртэл, хонхорцог хаягдал-15 хувь хүртэл, тослогт ургамлын үр-10 хувь хүртэл, наранцэцгийн үр-8 хувь хүртэл бүх нөхцөл.

7.9. Нунтаг, нурмаг ба овоолмог ачааны тээвэрлэлтийн тээврийн бичиг баримтыг бүрдүүлэхэд эх падааны "байрын тоо" хүснэгтийн алинд нь хамаарахыг ачаа илгээгчийн тодорхойлсноор "нунтаг нурмаг" буюу "овоолмог" гэж бичнэ.

7.10. Бага хэмд хөлдөх ачааг төмөр замаар тээвэрлэхэд ес дүгээр бүлэгт /түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх/-т заасныг баримтална.

7.11. Бага хэмд хөлдөх, чийгшилтэй, овоолмог ба нунтаг, нурмаг ачааг хүйтний улиралд тээвэрлэхэд вагон хана, шаланд болон өөр хоорондоо барьцалдаж, наалдахаас хамгаалах арга хэмжээ авна.

7.12. Овоолмог ба нунтаг, нурмаг ачааг хагас вагонд тээвэрлэхдээ нэг нээлхий дээрх ачааны даралтыг 6 тонноос ихгүй, нээлхийгээр буух ачааны хэмжээ 400х400 мм-ээс бага хэмжээтэй ачааг вагоны шалаар жигд тарааж трапец хэлбэрээр нуруулдаж ачна.

7.13. Овоолмог ба нунтаг, нурмаг ачааг тээвэрлэхээр ачилтыг хийж гүйцэтгэхдээ ачааг өөрөө уугих, шатахаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээг ачаа илгээгч авна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ЧИНГЭЛЭГТ АЧАА ТЭЭВЭРЛЭХ

8.1. Өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр төмөр замаар бүх төрлийн чингэлгийн тээвэр гүйцэтгэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Зөвлөмж: овор хэмжээ, хэв бичээс, дугаар, бохир жин, хийц нь стандартын дагуу хийгдсэн, ачаа ачих зориулалттай, ачааны бүрэн бүтэн байдлыг хангаж, нэг болон хэд хэдэн төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэж болох, ачиж буулгах, шилжүүлэн ачих үед механикжсан хэрэгсэл ашиглаж болохуйц тээврийн хэрэгслийг чингэлэг гэж ойлгоно.

8.2. Чингэлгүүдийг их, дунд, бага даацын гэж ангилахаас гадна түгээмэл ба тусгай зориулалтын гэж ангилна. Түгээмэл зориулалтын чингэлгээр ширхэгийн сав баглаа боодолтой олон нэр төрлийн ачаа, тусгай зориулалтын чингэлгээр зөвхөн нэг төрлийн болон тусгай нөхцөл шаардсан ачааг /цемент, шингэн, нурмаг г.м./ тээвэрлэнэ.

8.3. Чингэлгийн дугаар, хэв бичээс нь хоёр мөрөөр бичигдсэн байна:

8.3.1. дунд даацын чингэлэг дэх эхний мөрний дугаар нь 9 оронтой тооноос бүрдэнэ. Эхний нэг оронтой тоо чингэлгийн төрөл хэмжээг, дараачийн 7 оронтой тоо нь чингэлгийн дэс дугаарыг, сүүлчийн 9 дэх орон нь хяналтын тоо /дугаар зөв бичигдсэнийг шалгах/-г тус тус заана. Хоёр дахь мөр нь 5 оронтой тооноос бүрдэх бөгөөд эхний 3 орон нь хэний эзэмшил болохыг, дараачийн 2 орон нь хийц, зориулалтыг харуулна.

Жишээ нь: 3 1999900 6;
804 00.

Тайлбар:	<u>3</u>	- бохир жин /3 тонн/;
	<u>1999900</u>	- серийн дугаар;
	<u>6</u>	- хяналтын тоо.
	<u>804</u>	- Украины эзэмшлийн чингэлэг;
	<u>00</u>	- хийцийн онцлог.

8.3.2. их даацын чингэлэг дэх эхний мөрөнд чингэлэг эзэмшигчийг тодорхойлох 4 үсгээс бүрдсэн товчилсон нэр, түүний дараа 6 оронтой тооноос бүрдсэн чингэлгийн дугаар, 7 дахь орон нь хяналтын тоог заана. 4 үсгэн бичээсийн сүүлчийн "U" үсэг нь ачааны чингэлэг гэсэн шинж чанарыг заана. Эхний 3 үсэг нь чингэлэг эзэмшигчийн олон улсын бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн нэрийг заана. Хоёр дахь мөрөнд дугаар нь 2 хэсгээс бүрдэх ба үсгэн ба тоон гэсэн үсгээр тэмдэглэсэн хэсэг нь латин үсгээр эзэмшигч орны товчилсон нэрийг заана.

Жишээ нь: RZDU 1234569;
RU 2310.

Тайлбар: <u>RZD</u>	- эзэмшигч төмөр замын код /Оросын төмөр зам/;
<u>U</u>	- ачааны чингэлэг гэсэн шинж чанарыг агуулна;
<u>123456</u>	- чингэлгийн дэс дугаар;
<u>9</u>	- хяналтын тэмдэг.
<u>RU</u>	- улсын код /Оросын Холбооны Улс/;
<u>23</u>	- чингэлгийн хэмжээсүүдийг харуулах код /2-урт-6058 мм,
3-өндөр-2591мм/;	
<u>10</u>	- чингэлгийн төрөл /10-түгээмэл зориулалтын/

8.3.3. чингэлэг дээр дараах хэв бичээсүүд байна:

- Хаалган дээр-Дээд бохир жин /MGW/, чингэлгийн өөрийн жин /TARE/ килограммаар /kg/, фунтаар /lb/ бичсэн байна. Жишээ нь: ICC төрлийн чингэлгийн дээд бохир жинг 24000 кг биш харин 24384 кг. Энэ нь фунтыг кг-д нарийвчлалтайгаар шилжүүлсэнтэй холбоотой ба зөвшөөрөгдөх хэмжээнд нөлөөлөхгүй.
- Хажуугийн ханан дээр: Ээлжит их засвар хийгдсэн хугацааг /он, сар/ бичнэ.

8.4. Чингэлгээр тээвэрлэх ачааг тээвэрт хүлээн авах:

8.4.1. Их болон дунд даацын чингэлгээр ачаа тээвэрлэхэд төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журмыг баримтлан тээвэрлэнэ;

8.4.2. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан ачаа илгээгчээс өгсөн захиалгын дагуу тээвэрлэх ачаанд нь тохирох чингэлгийг ачилтад тавьж өгч ачуулна. Дунд, их даацын түгээмэл чингэлгээр жижиг илгээлтийн ширхэгийн ачааг савлалгүйгээр, буюу хялбарчилсан савлалттайгаар, анхдагч сав, баглаа, боодлоор тээвэрлэнэ. Боодлын хатуулгатай цаасан уут, картон хайрцаг, модон жийрэг, сараалжин модон хайрцаг зэргээр дараах нэр төрлийн барааг чингэлгээр тээвэрлэж болно. Үүнд: өргөн хэрэглээний төрөл бүрийн бараа /бэлэн хувцас, бөс даавуу, сүлжмэл эдлэл, жижиг бараа, төрөл бүрийн чихэр, эмийн бараа, радио болон цахилгаан бараа, ном гэх мэт/, үйлдвэрлэлийн зориулалтын бүтээгдэхүүн /машины сэлбэг хэрэгсэл, багаж, будгийн зүйлс, химийн хайрцаглаж савласан бүтээгдэхүүн, овор хэмжээ багатай тоног төхөөрөмж/, иргэдийн гэр ахуйн хэрэглэл орно;

8.4.3. Ачих ачаа нь чингэлгийг гэмтээж бохирдуулахааргүй байвал зохино. Эвгүй үнэртэй, нойтон давсалсан арьс шир зэргийг ачихгүй байхыг хатуу анхаарна;

8.4.4. Чингэлэгт ачиж байгаа ачаа нь сав баглаа боодолтой, хэд хэдэн төрлийн ачааг хамт ачсан тохиолдолд бусад ачааг гэмтээхгүй, бохирдуулахгүй байх шаардлагыг хангасан байна;

8.4.5. Сэлбэг хэрэгсэл, зэврэлтээс хамгаалж тосолгоо хийсэн, материал техникийн хангамжийн төмөрлөг эдлэхүүнийг ачихын өмнө ачаа илгээгч нь зузаан цаас, зориулалтын бусад зүйлээр чингэлгийн хана, шалыг доторлож бохирдолт, гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй. Чингэлгийн хана, шалыг бохирдуулах гэмтээж болох ачаа ачсан тохиолдолд шаланд нь дэвсгэр, хананд нь жийрэг бүтээлэг хэрэглэнэ;

8.4.6. Шингэн ачааг чингэлэгт тээвэрлэхэд сав /модон, төмөр торх, хуванцар сав/ нь эвдрэхгүй байх давуу талыг харгалзана. Шилэн савтай шингэн ачааг тээвэрлэхэд гадна талд нь хатуу цаасан хайрцаг, модон сагс бусад баглаа боодлыг хэрэглэнэ;

8.4.7. Их даацын чингэлэгт ачих ачааны нэг байрын жин 1500 кг-аас ихгүй байна. Дунд даацын чингэлэгт ачих ачааны жин нь 120 кг-аас хэтрэхгүй байна;

8.4.8. Чингэлэгт түргэн муудах ачаа тээвэрлэхэд энэхүү журмын ес дүгээр бүлэг /түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх/-т заасныг баримтална;

8.4.9. Чингэлэгт аюултай ачаа тээвэрлэхэд төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг баримтална;

8.4.10. Чингэлэгт ачсан ачааны жинг чингэлгийн даац /хэв бичээст заасан даац/-аас хэтрүүлэхгүйгээр ачуулна. Чингэлэгт ачих ачааны жинг ачаа илгээгч тодорхойлох бөгөөд үнэн зөв мэдүүлнэ. Шаардлагатай бол төмөр замын байгууллага ачааны жинг тодорхойлж болно;

8.4.11. Чингэлэгт ачаа ачиж дууссаны дараа чингэлгийг энэхүү журмын 18 дугаар бүлэг /вагон, чингэлэг ломбодох/-т заасны дагуу ломбодно;

8.5.12. Чингэлгээс ачааг буулгасны дараа төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчоор ачааны үлдэгдэл, сав, баглаа боодол, бэхэлгээний үлдэгдлийг цэвэрлүүлж хүлээн авна;

8.5.13. Чингэлэгийн ачаа ачихын өмнө техникийн байдалд үзлэг хийнэ.

А) төмөр замын тээврийн байгууллагын чингэлэгт ачаа ачих үед техникийн болон ачаа тээврийн үзлэгийг суурь бүтэц эзэмшигчийн эрх бүхий ажилтан хийж ачилтанд өгнө. Ямар нэгэн гэмтэл илэрвэл акт тогтоох ба тухайн ачаанд тохирохгүй бол өөр чингэлэг сольж өгнө. (Хуулийн нэр томъёо өөрчлөгдсөн)

Б) тээвэрлэгчид үл харьяалагдах чингэлэгийн техникийн болон ачааны бүрэн бүтэн байдлыг илгээгч хариуцна.

8.5.14. Чингэлгээр үнэ зарласан ачааг тээвэрлэхэд энэхүү журмын 15 дугаар бүлэг /үнэ зарласан ачааг тээвэрлэх/-т заасныг баримтална;

8.5.15. Чингэлэгт тээврийг чингэлэг тээвэрт нээлттэй өртөөдийн хооронд гүйцэтгэх ба чингэлэг тээвэрт хаалттай өртөөнд зөвхөн онцгой нөхцөлд ачаа хаяглаж болох бөгөөд тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр гүйцэтгэнэ. Чингэлэг тээвэрт нээлттэй өртөөдийн жагсаалтыг төмөр замын тээврийн байгууллага тогтооно; (Хуулийн нэр томъёо өөрчлөгдсөн)

8.5.16. Чингэлэгт ачааг ачихад хана, шаланд өгөх даралт жигд, гулсахгүй, чингэлгийн хаалга чөлөөтэй хаагдаж, нээгдэж байхаар ачаална;

8.5.17. салбар зам, талбайд ачилт, буулгалтын ажиллагааг төмөр замын хүч хэрэгслээр, салбар замд ачих, буулгах ажлыг илгээгч, хүлээн авагчийн хүч хэрэгслээр гүйцэтгэнэ. Ачааг чингэлэгт ачих, буулгах ажлыг илгээгч, хүлээн авагч өөрсдөө гүйцэтгэнэ. Чингэлгийг вагон буюу автомашинд ачих, буулгах ажлыг зам талбайд эзэмшигч, замд тээвэрлэгч гүйцэтгэнэ;

8.5.18. Илгээгч чингэлэгт ачаа ачихад ачаа тус бүрийн үнэ, байр бүрт байгаа ачаа барааны нэрийг нэг бүрчлэн үнэн зөв бичсэн жагсаалт үйлдэж, чингэлэг болгоны дотор хийх бөгөөд энэ жагсаалт нь илгээгчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан байна;

8.5.19. Ачаа илгээгчийн агуулахаас ачигдаж ирсэн ачаатай чингэлгийг нийтийн хэрэглээний зам, талбайд хүлээн авахад чингэлэгт гадна үзлэг хийж, чингэлгийн байдал, ломбо зэргийг шалган хүлээж авна. салбар замаас ачигдсан чингэлэгт тавьсан илгээгчийн ломбоны дугаар бичиг баримтад заасан ломбоны тэмдэглэгээтэй зөрснөөс үүдэн гарсан салбар зам эзэмшигч хариуцна;

8.5.20. Вагонд чингэлгийг иж бүрдлээр ачна. Вагоны багтаамжийг бололцоогоор нь бүрэн ашиглана;

8.5.21. Вагонд ачих чингэлгийн иж бүрдлийг техникийн нөхцөлийн дагуу бүрдүүлнэ.

8.6. Чингэлгийн тээвэрлэлтийн падаан бөглөх.

8.6.1. Ачаатай явах чингэлэг бүрт илгээгч падаан бичнэ. Падаан нь чингэлгийн тээвэрлэлтийн үндсэн бичиг баримт /гэрээ/ мөн. Ачаа илгээгч болон тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ачаа тээврийн ажилтан падааны бүх хүснэгтийг бүрэн бөглөсөн байна.

8.6.2. Чингэлгийн падааныг энэхүү журмын 4 дүгээр бүлэг /орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримт бүрдүүлэх/-т заасны дагуу гүйцэтгэнэ.

8.6.3. Олон улсын харилцаанд хоосон их даацын чингэлгийг тээвэрлэх үед тээврийн бүрэн бичиг баримттайгаар тээвэрлэнэ.

8.6.4. Орон нутгийн харилцаанд хоосон чингэлэг тээвэрлэхэд тээврийн бичиг баримт үйлдэн тээвэрлэнэ.

8.6.5. Чингэлэг ачсан вагон бүрт вагоны хуудас бичнэ.

8.7. Ачаа илгээгч, хүлээн авагч чингэлгээр тээвэрлэх ачааны хүрэх өртөөг өөрчлөх тухай бичгэн хүсэлт тээвэрлэгчид ирүүлснээр энэхүү журмын 20 дугаар бүлэг /илгээлтийн хаяг солих/-т заасны дагуу хаягийг солино.

8.8. Чингэлэгтэй ачаа нь хүргэх хугацаандаа ирээгүй тохиолдолд хүлээн авагчийн хүсэлтийн дагуу эрэл хийж чингэлэг байгаа газар, саатсан шалтгааныг тодруулж хариу өгнө.

8.9. Чингэлэгтэй ирсэн ачааг олгох, авто тээврээр үйлчлэх:

8.9.1. Чингэлгээр тээвэрлэн ирсэн ачааг олгоходоо чингэлгийн ломбыг шалгаж ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгөх ба ачаа хүлээн авагч хүсвэл тээвэрлэгчийн эрх бүхий ачаа тээврийн ажилтан байлцуулан тоолж хүлээлгэж өгнө.

8.9.2. Ачаа нь дутсан, гэмтсэн байвал тээврийн акт тогтооно.

8.9.3. Чингэлгээр ирсэн ачааг хүлээн авагчийн хүсэлтээр автотээврийн хэрэгслээр тухайн байгууллагын ачаа буулгах байр, агуулах хүртэл хүргэж өгч болно.

8.9.4. Гаалийн бүрдүүлэлт хийгдэх бол гаалийн байгууллага шалгаж ачааг эзэнд нь олгохыг зөвшөөрсөн тухай тэмдэглэл хийгдсэний дараа олгоно.

8.9.5. Чингэлэгтэй ачааг холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, төлбөр тооцоог хийж дууссаны дараа талбайгаас гаргана.

8.9.6. Байгууллагаас татаж авчрах чингэлгийг ачааны үлдэгдлээс цэвэрлүүлж, техникийн үзлэг хийж хүлээн авна.

8.10. Чингэлгээр ачаа тээвэрлэх үед тээврийн хөлс болон бусад хураамжийг тогтоосон тарифын дагуу хураана.

8.10.1. Тээвэрлэлтийн болон нэмэгдэл төлбөрийн тооцоог ачаа илгээх, хүрэх өртөөнд хийх ба хөлсийг бэлэн мөнгө, шилжүүлэг, төлбөрийн карт, нэхэмжлэлээр тооцно;

8.10.2. Олон улсын төмөр замын ачааны харилцаанд чингэлэг ашигласны төлбөрийг төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллагаас баталсан вагон эдэлгээний дүрмийн дагуу тээвэр зуучлагчтай тооцно.

8.11. Чингэлгээр ачаа тээвэрлэх захиалгыг энэхүү журмын 2 дугаар бүлэг /ачааны захиалга хүлээн авах, зөвшилцөх/-т заасны дагуу байгууллага, иргэдээс хүлээн авна.

8.12. Чингэлэг тээвэрлэлтийн тайланг тээвэрлэгч сар, улирал, жилээр гаргана.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ТҮРГЭН ГЭМТЭЖ, МУУДАХ АЧААГ ТЭЭВЭРЛЭХ

9.1. Түргэн гэмтэж, муудах ачааг тусгай зориулалтын /хөргүүрт, тогтмол дулаант зэрэг/ болон тээвэрлэлтийн шаардлага хангасан битүү вагонд тээвэрлэнэ.

Зөвлөмж: түргэн гэмтэж, муудах ачаа гэж төмөр замаар тээвэрлэх үед гадны температурын нөлөөлөл, арчилгаа үйлчилгээний хүчин зүйлийн улмаас гэмтэж чанар нь алдагдах эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг ойлгоно.

9.2. Олон улс болон орон нутгийн тээврээр түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэхдээ олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийг мөрдөнө.

9.3. Ачаа илгээгч нь ачааг тээвэрлэлтэд хүлээлгэж өгөхдөө ачаа тээвэрлэх хугацаа, тээвэрлэх үеийн цаг агаарын нөхцөл, байдлыг харгалзан тухайн төрлийн ачааг тээвэрлэх хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг сонгоно.

9.4. Түргэн гэмтэж, муудах ачааны сав, баглаа, боодолд дараах шаардлагыг тавина.

9.4.1. Тээвэрлэлтэд хүлээлгэн өгөх ачаа үндэсний стандарт, чанарын шаардлага хангасан байна;

9.4.2. Тээвэрлэлтэд хүлээлгэн өгөх ачааны сав, баглаа, боодол нь бат бөх, гэмтэж, бохирдоогүй, ачаа асгарч гоожсон шинж тэмдэггүй, гар болон механикжсан аргаар ачих буулгах боломжийг хангасан байна;

9.4.3. Түргэн гэмтэж, муудах ачааны сав, баглаа, боодол дээр давхарлаж хураах тоо, хадгалалтын нөхцөл зэргийг тогтоосон тэмдэглэлүүд байх шаардлагатай;

9.4.4. Түргэн гэмтэж, муудах ачааг модон буюу хатуу цаасан хайрцаг, сагс, тор, тусгай тавиур, бидон, торх гэх мэтийн сав, баглаа, боодолтой тээвэрлэнэ. Тухайлбал, төмс, лууван, манжинг хайрцаг болон шуудай савтай, улаан лооль, манжин, сармис, өргөст хэмх, алим, усан үзэм, нимбэг, бэрсүүт жүржийг хайрцагтай тээвэрлэнэ;

9.4.5. Түргэн гэмтэж, муудах ачааг хураах өндрийг тогтоохдоо илгээгчийн заалтыг үндэслэнэ. Ачаа илгээгчийн зөвшөөрөлтэйгээр төмс, манжин, тарvas зэрэг ачааг битүү вагон дотор овоолж хурааж тээвэрлэхийг зөвшөөрнө;

9.4.6. Ачаа илгээгч нь тээврийн бичиг баримтад, чанарын гэрчилгээ, холбогдох бусад бичиг баримтыг хавсаргаж, тээвэрлэх нөхцөлд тохирох тухай тодорхойлолтыг тээвэрлэгчид гаргаж өгнө;

9.4.7. Түргэн гэмтэж, муудах ачаа илгээгч нь падааны "илгээгчийн онцгой тэмдэглэл" гэсэн хүснэгтэд түргэн гэмтэж муудах ачаа гэсэн тэмдэглэл хийж, тээвэрлэх нөхцөлийг заасан байна;

9.4.8. Ачаа илгээгч нь вагон тавиулахаар захиалсан хугацаанд ачаагаа ачуулах газарт зөөвөрлөж ирүүлсэн байна;

9.4.9. Ачаа илгээгч ачааг өртөөнд зөөвөрлөж ирүүлэх үед хөлдөх, хэт халахаас хамгаалсан байна;

9.4.10. Вагоныг ачих буулгах үед ариутгалыг ачаа илгээгч болон хүлээн авагчийн хүч, хэрэгслээр гүйцэтгэнэ.

9.5. Түргэн гэмтэж, муудах ачааг зориулалтын вагонд тээвэрлэнэ.

9.5.1. Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэхэд битүүмжлэл сайтай, ачааны үлдэгдлээс бүрэн цэвэрлэгдсэн, хаалга нь бүрэн хаагддаг, хана шалан дээр хадаасгүй, агааржуулах нээлхий нээгддэг, бүрэн бүтэн вагоныг ачилтад тавьж өгнө;

9.5.2. Вагоны ариутгалыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хүч, хэрэгслээр гүйцэтгэнэ;

9.5.3. Ачаа илгээгч нь вагон, чингэлгийн их бие дээр түргэн гэмтэж, муудах ачааны наадас наана.

9.6. Ачааг тээвэрлэлтэд хүлээн авах.

9.6.1. Тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан нь тээвэрлэлтэд хүлээж авах үед ачааны чанар, байдлыг гадаад үзлэгээр шалгаж, муудаж чанар нь алдагдсан эвгүй үнэртэй, исэлдсэн, хөлдсөн, сав баглаа боодол гэмтсэн эсэх, асгарч гоожсон зэрэг шинжүүд илт мэдэгдэж буй ачааг тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзах эрхтэй;

9.6.2. Ачааны байранд үзлэг хийх үед сав, баглаа, боодлыг задлах, үзлэг дууссаны дараа битүүмжлэх, дахин хураах ажиллагааг ачаа илгээгчийн хүч, хэрэгслээр гүйцэтгэнэ;

9.6.3. Нэг вагон болон чингэлэгт шинж чанар болон тээвэрлэх нөхцөлийн хувьд хоорондоо харшлахгүй, эвгүй үнэргүй ачааг хамт тээвэрлэхийг зөвшөөрнө. Хамт тээвэрлэхийг хориглосон ачааны жагсаалтыг тээвэрлэгч тогтооно;

9.6.4. Хамт ачиж болохгүй ачааг илгээгч тээвэрлэлтэд өгвөл ачилт хүлээн авах, тээвэрлэлт хийхээс татгалзах эрхтэй;

9.6.5. Тээвэрлэлтийн өөр өөр нөхцөл шаардагдах түргэн гэмтэх муудах ачааг нэг вагон болон чингэлэгт тээвэрлэхгүй.

9.7. Түргэн гэмтэж, муудах ачааг ачих:

9.7.1. Хайрцаг савтай ачааг тээвэрлэлтийн замд нурж унахааргүй, тогтвортой байрлуулж, шаардлагатай тохиолдолд бэхэлж /ачааг вагон, чингэлэгт ачих, бэхлэх техникийн нөхцөлийн шаардлагын дагуу/ вагонд ачна;

9.7.2. Илгээгч хүссэн тохиолдолд агааржуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хураалтын эгнээ хооронд тодорхой хэмжээний зайтай хураах ба ачааны байр эгнээ хооронд нурж унахаас хамгаалсан зөв өрөлт эсвэл нэмэлт бэхэлгээтэй байна;

9.7.3. Хураалтын эгнээний багц хооронд 150 мм-ээс илүү зайтай байвал бэхэлгээ хийнэ;

9.7.4. Бэхэлгээ хийх үед вагон, чингэлгийн төмөр хананд хадаас хадахгүй байхыг хатуу анхаарна;

9.7.5. Сав баглаатай ачааг вагоны хаалганаас 25 см зайтай хураана. Хаалганы зайд ачаа нурахаас хамгаалж 4 см-ээс багагүй зузаантай банзаар хашлага хийнэ;

9.7.6. Вагон, чингэлэгт ачих ачааны жин нь тээврийн хэрэгслийн тэвш дээр тэмдэглэсэн даацаас хэтрээгүй байна.

9.8. Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх:

9.8.1. Өртөөний дарга нь түргэн гэмтэх муудах ачаатай вагоны сэлгээний ажлыг шуурхай гүйцэтгэх болон тээврийн бичиг баримт бэлэн болсноос хойш эхний галт тэргээр явуулах, илгээгч хүссэн тохиолдолд ачааны хурдан галт тэргэнд холбох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэгтэй;

9.8.2. Түргэн гэмтэж, муудах ачаатай вагоныг галт тэрэгний бүрэлдэхүүнээс тээвэрлэлтийн замд салгахгүй. Вагонд гарсан гэмтлийг аль болохоор галт тэрэгний бүрэлдэхүүнээс салгахгүйгээр засварлах бөгөөд зайлшгүй салгах шаардлагатай бол тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны шийдвэрээр гүйцэтгэхийг зөвшөөрнө;

9.8.3. Түргэн гэмтэж муудах ачааны хаяг солихдоо ачаа хүргэх хугацааг харгалзан тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэхүү журмын 20 дугаар бүлэг /илгээлтийн хаяг солих/-т заасны дагуу гүйцэтгэнэ;

9.8.4. Түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх хурдыг ачаа илгээгч тодорхойлно;

9.8.5. Ачаа илгээгч нь дулааны улиралд тээвэрлэлтийн замд ачааны агааржуулалтыг хангах зорилгоор хажуугийн нээлхийнүүдийг онгойлгож, сараалжин төмрийг вагоны дотор талаас онгойхооргүй бэхэлсэн байна.

9.9. Түргэн гэмтэж, муудах ачааг олгох:

9.9.1. Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу түргэн муудах ачаатай вагон ирэх тухай ачаа хүлээн авагчид урьдчилан мэдэгдэж, вагон өртөөнд ирснээс хойш 2 цагийн дотор ачаа хүлээн авагчийн хүлээн авч буулгах зам дээр тавьж өгсөн байна;

9.9.2. Шилэн сав болон лаазалсан савлагаатай бүтээгдэхүүний сав, баглааны битүүмжлэл бүрэн бүтэн ирсэн нөхцөлд задалж шалгахгүйгээр тоо ширхэгийн дагуу хүлээлгэн өгнө;

9.9.3. Түргэн гэмтэж, муудах ачааг ачаа хүлээн авагчийн агуулах, талбайд хадгална. Зайлшгүй шаардлагатай бол зөвхөн ачаа илгээгч болон хүлээн авагчийн хүсэлтээр тээвэрлэгчийн агуулахад хадгалахыг зөвшөөрнө. Ачаа илгээгч, хүлээн авагч нь тогтоосон хугацаанд ирж агуулахаас ачаагаа аваагүйн улмаас ачаа гэмтэж муудсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй;

9.9.4. Вагонд хийгдсэн нэмэлт тоноглол бэхэлгээг вагон, чингэлгээс салгах, буулгах, мөн түүнчлэн суларсан вагоныг цэвэрлэх, ариутгах ажиллагааг ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр гүйцэтгэнэ.

9.10. Түргэн гэмтэж, муудах ачааг хүйтний улиралд тээвэрлэх:

9.10.1. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хүч хэрэгслээр дулаалга хийж бэлдсэн битүү вагонд тээвэрлэхийг зөвшөөрнө. Хүйтний улиралд дулаалгатай болон ердийн вагон, чингэлэгт тээвэрлэсний улмаас ачаа гэмтэж муудсан тохиолдолд, хохирлын нэхэмжлэлийг гаргахгүй тухай ачаа илгээгчийн ирүүлсэн бичгэн мэдэгдлийг /баталгааг/ үндэслэн тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан нь ачилтын талаар шийдвэр өгнө;

9.10.2. Хүйтний улиралд түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх зорилгоор зуух тавьсан галлагаатай вагоныг явуулах бол, уг вагоны тээвэрлэлтэд тэнцэх эсэхийг тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагууд, /тээвэрлэлт, хамгаалалт, засвар үйлчилгээ/ оролцсон комисс тогтоож акт үйлдэнэ. Галлагаатай вагоныг зөвхөн тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага /тээвэрлэлт, ачих буулгах ажил хариуцсан/ тусгай байдлаар тоноглож, тээврийг зохион байгуулж, галын аюулгүй байдалд хяналт тавина;

9.10.3. Галлагаатай вагоны ачаа хүргэгч нь өөрийн хариуцаж яваа вагоны ачааны бүрэн бүтэн байдал, галын аюулгүй байдлыг хариуцна;

9.10.4. Төмөр замын тээврийн байгууллагын хамгаалалт хариуцсан эрх бүхий байгууллага нь улиралд нэг удаа галлагаатай вагоны галын аюулгүй байдалд хяналтын үзлэг хийнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ

ХОРИО ЦЭЭРТЭЙ АЧААГ ТЭЭВЭРЛЭХ

10.1. Энэхүү журмыг төмөр замын тээврээр ургамлын тэдгээрийн гаралтай түүхий эд, бараа, бүтээгдэхүүнийг /цаашид хорио цээртэй гэнэ/ тээвэрлэхэд дагаж мөрдөнө.

10.2. Хорио цээрийн халдвар дамжуулах өвчин үүсгэгч байж болох хорио цээртэй ачааг төмөр замаар тээвэрлэхдээ монгол улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн хяналтан дор тээвэрлэнэ.

10.3. Тогтоосон журмын дагуу нэрс нь бүртгэлд орсон хорио цээрийн үндсэн ачаануудыг монгол улсын нутаг импортлох болон экспортлох, дамжин өнгөрүүлэхдээ мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авч гүйцэтгэх.

10.4. Хорио цээртэй ачааг буулгасны дараа ачаа хүлээн авагч нь вагон чингэлгүүдийг цэвэрлэх бөгөөд ачааны үлдэгдэл хогийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн зааврын дагуу тусгайлан заасан газар устгана.

10.5. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд хорио цээртэй ачаа буусны дараа мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн улсын байцаагчийн заавраар вагон чингэлгүүдэд халдваргүйжүүлэх ажил хийнэ.

10.6. Ачаа болон тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Зардлыг бараа, бүтээгдэхүүн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хариуцна. Хорио цээртэй ачааг буулгасны дараа вагон, чингэлгийг халдваргүйжүүлсэн тухай тээвэрлэгч байгууллагад үзүүлэх эрүүл ахуй ариун цэврийн акт баримтыг бүрдүүлнэ.

10.7. Хорио цээрийн ариутгалын бүсээс хорио цээртэй ачааг тээвэрлэх:

10.7.1 монгол улсын хил хязгаар дотор хорио цээрийн ариутгалын бүсээс гаралтай хорио цээртэй ачааг төмөр замаар тээвэрлэхээр хүлээн авах ажил нь ачаа илгээгч, ургамал хорио цээрийн улсын байцаагчийн олгосон гэрчилгээг үзүүлсэн тохиолдолд зөвшөөрөгдөнө;

Зөвлөмж: хорио цээр ариутгалын бүс нь хорио цээрийн объектууд илэрснээс үүдэн хорио цээр, ариутгалын дэглэм тогтоосон газар нутаг байна. Хорио цээр ариутгалын дэглэм нь хорио цээр ариутгалын бүсэд тогтоосон хорио цээр ариутгалын арга хэмжээнүүд байна.

10.7.2. Төмөр замын тээврийн байгууллага нь монгол улсын холбогдох эрх бүхий байгууллагаас хорио цээр, ариутгалын бүсүүд, мөн түүнчлэн тээвэрлэлтэд нь хязгаарлалт тавигдсан хорио цээртэй ачаануудын нэрс бүхий албан ёсны мэдэгдлийг хүлээн авсан үед энэ тухай бусад тээвэрлэгчид яаралтай мэдэгдэнэ. Үүний сацуу ачааг тээвэрлэлтэд хүлээн авах бүх газруудад хорио цээрийн гэрчилгээгүй бол ямар төрлийн хорио цээртэй ачаануудыг тээвэрлэлтэд хүлээн авахгүй тухай заасан зарлалыг нүдэнд үзэгдэх газруудад байрлуулна;

10.7.3. Вагон, чингэлэг бүр дэх ачаа нь хорио цээрийн гэрчилгээтэй байх эсвэл нэг вагон, чингэлэгт хэд хэдэн илгээлтийн ачаатай үед хорио цээртэй ачаатай илгээлт бүрд уг гэрчилгээг авсан байна. Ачаа илгээгч нь олгосон сар, өдөр ба дугаарыг нь заасан хорио цээрийн гэрчилгээний хавсралтын тухай тэмдэглэл падаанд оруулна. Хорио цээрийн гэрчилгээ нь гарын үсэг болон тэмдэггүй, баллаж засвар хийсэн, мөн түүнчлэн хорио цээрийн гэрчилгээн дээр бичсэн ачааны нэр бодит байдал дээрх ачаатай тохирохгүй байвал тээвэрлэлтэд хүлээн авахгүй. Хорио цээрийн гэрчилгээнд заасан хугацаа нь ачаа хүргэх хугацаанд багтах шаардлагатай;

10.7.4. Хорио цээртэй ачааг илгээгч нь зөвхөн хорио цээрийн гэрчилгээнд заасан өртөө, хүлээн авагчид илгээхээр тээвэрлэлтэд өгнө;

10.7.5. Хорио цээр ариутгалын бүсээс ирсэн хорио цээртэй ачааг хүлээн авагч зөвхөн монгол улсын ургамал хорио цээрийн улсын байцаагчийн зөвшөөрлөөр буулгана;

10.8. Импорт, экспортын ба транзит хорио цээртэй ачааг тээвэрлэх

10.8.1. Экспортлох бараа, бүтээгдэхүүн мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон баталгаажуулалтын гэрчилгээтэй, импортлох бараа импортын мэдэгдэлтэй байна;

10.8.2. Улсын хилийн нэвтрэх цэг бүрт холбогдох эрх бүхий байгууллага монгол улс руу хорио цээртэй бараа, бүтээгдэхүүн нэвтрэх, шууд нэвтрүүлэхийг зөвшөөрсөн тэмдгийг падаанд дарна;

10.8.3. Импортын хорио цээртэй ачаа, хилийн өртөөнд /дамжуулах/ ирэх бүрт тээвэрлэгч энэ тухай мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж хяналт, шалгалтад хамруулна;

10.8.4. Хорио цээртэй ачаанд монгол улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр шилжүүлэн ачилт хийгдэнэ. Хорио цээр ариутгалын хяналт шалгалтын үйл ажиллагаа нь өртөөний ажлын технологийн горимд заасан хугацаанаас хэтрэхгүй байна;

10.8.5. Хилийн дамжуулах өртөөнд тээвэрлэгч болон гаалийн байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан ургамал хорио цээрийн улсын байцаагч хорио цээр ариутгалын хяналт шалгалтыг хийнэ;

10.8.6. Хорио цээрийн объектуудаар халдварласан эсвэл хорио цээрийн улсын байцаагчийн зааврыг зөрчиж тээвэрлэсэн /хорио цээр, ариутгалын нөхцөл шаардлагыг зөрчсөн/ хорио цээртэй ачааг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн зардлаар халдваргүйжүүлж хураан авч, устгаж эсвэл ачаа илгээгчид буцаана. Ургамал, хорио цээрийн улсын байцаагч, импортын хорио цээртэй ачааг буцаасан, хураасан, устгасан,

халдваргүйжүүлсэн тухай улсын хорио цээрийн хяналт шалгалтын акт үйлдэж гаалийн байгууллага болон тээвэрлэгчид олгоно;

10.8.7. Улсын хилээр нэвтрэн өнгөрөх цэгүүд болон хилийн өртөөдөд шилжүүлэн ачилт хийгдэхгүй экспортод гарч байгаа хорио цээртэй ачааг илгээгч, ариун цэвэр эрүүл ахуйн гэрчилгээг шалгуулсан тохиолдолд тээвэрлэлтэд хүлээн авна. Уг гэрчилгээг монгол улсын мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн улсын хяналтын газраас ачилт хийж байгаа вагон чингэлэг бүрт эсвэл нэг вагон чингэлэгт хэд хэдэн илгээлт байвал хорио цээртэй ачаатай илгээлт бүрт олгоно;

10.8.8. Илгээгч нь хорио цээртэй ачааг экспортод тээвэрлэхэд эрүүл ахуй, ариун цэврийн гэрчилгээг нь бараатай дагадлах бичиг баритад хавсаргаж зохих тэмдэглэл хийнэ;

10.8.9. Хорио цээртэй ачаатай вагон ба чингэлэгт эвдрэл гэмтэл, ачаа алдагдсан ул мөр илэрсэн бүх тохиолдолд энэ тухай тээвэрлэгч нь мэргэжлийн хяналтын байгууллагад шуурхай мэдэгдэх үүрэгтэй.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨМӨР ЗАМААР МАЛ, АМЬТАН ТЭЭВЭРЛЭХ

11.1. Төмөр замаар мал, амьтныг мах комбинат, боловсруулах үйлдвэрт хүргэх, бордох, цирк, худалдаа, үзэсгэлэн, үржил, экспорт болон импортын зориулалтаар тээвэрлэх үед мөрдөгдөнө.

11.2. Мал, амьтныг вагон илгээлтээр тээвэрлэх, ачих, буулгах ажиллагааг ачаа тээвэрлэлтэд нээлттэй өртөөдийн хооронд тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

11.3. Мал, амьтныг ердийн битүү вагонд тээвэрлэж болно. Ачаа илгээгч ердийн битүү вагоныг мал, амьтан ачих зориулалтаар тоноглох үүрэгтэй.

11.4. Мал, амьтан тээвэрлэх вагон нь техникийн хувьд бүрэн бүтэн, салхивчтай, хаалга нь битүүмжлэгдэж, ломбо тавих боломжтой, вагоны дотор хана, шаланд гэмтээж болзошгүй гагнаас, нөхөөс, хадаасгүй байхаас гадна цэвэрлэгдэж, угаагдаж ариутгагдсан байна.

11.5. Ачаа илгээгч нь мал, амьтан тээвэрлэхийн өмнө тухайн орон нутгийн засаг захиргаа, мал эмнэлгийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авсан байна. Энэхүү баримтуудыг падаанд хавсаргана. Мал эмнэлгийн гэрчилгээ нь олгогдсон хугацаанд хүчинтэй байна.

11.6. Вагон илгээлтээр мал, амьтан ачихад нийтийн болон дагнасан хэрэглээний өндөрлөсөн тавцантай замд өдрийн цагт гүйцэтгэнэ. Хэрвээ ачилт, буулгалтын зам нь шаардлага хангагдсан гэрэлтүүлэгтэй бол шөнийн цагаар гүйцэтгэж болно.

11.7. Ачаа илгээгч нь тээвэрлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр ачилт, буулгалтыг нийтийн хэрэглээний замд гүйцэтгэж болно.

11.8. Ачаа илгээгч нь ачилт хийхээс 24 цагаас доошгүй хугацааны өмнө мал эмнэлгийн байгууллагад мэдэгдэж мал эмнэлгийн эрх бүхий ажилтныг ачилт, буулгалтын үед заавал оролцуулна. Мал эмнэлгийн гэрчилгээнд тээвэрлэхийг зөвшөөрсөн тухай тэмдэглэл хийж, ачаа илгээгч болон тээвэрлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

11.9. Тээвэрлэх нөхцөл:

11.9. Тээвэрлэх нөхцөл:

11.9.1. мал, амьтныг төмөр замаар тээвэрлэхэд тэдгээрийн төрөл, нас, биеийн жин, өвөрмөц онцлогийг харгалзан нэг вагонд дараах тоо толгойгоор ачна;

Хоёрдугаар хүснэгт
Мал, амьтныг төмөр замаар тээвэрлэх

Мал, амьтны нэр	Толгой
• Нас гүйцсэн үхэр	16-24
• Идэр насны үхэр /бяруу, шүдлэн/	24-28
• Тугал	36-50
• Хонь, ямаа	80-100
• Тэмээ	8-аас илүүгүй
• Гахай 80 кг хүртэл жинтэй	50-60
• Гахай 80-100кг жинтэй	44-50
• Гахай 100-150 кг жинтэй	28-44
• Гахай 150 кг-с дээш жинтэй	20-28
• Адуу	18-24
• Адуу /хурдны, сайн үйлдвэрийн, экспортлох, импортлох, циркийн сургуультай гэх мэт/	төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, тээвэрлэгч, мал эмнэлгийн байгууллагатай зөвшилцөн тоо толгойг тогтоож болно.

11.9.2. Бод ба бог малыг нэг вагонд хамт ачихгүй. Зайлшгүй ачих шаардлага гарвал хооронд нь хайсаар тусгаарлаж тээвэрлэнэ;

11.9.3. Мал, амьтан ачсан вагоныг эхний галт тэргээр явуулна. Вагонд ачилт хийхэд нэг мал, амьтан багтах хэмжээний зай үлдээнэ;

11.9.4. Өвлийн улиралд агаарын температур -25°C -ээс доош хүйтэн, зуны улиралд $+25^{\circ}\text{C}$ -ээс дээш халуун үед 100 кг-аас дээш жинтэй гахайг тээвэрлэхгүй байхыг хатуу анхаарч ажиллана. Өвлийн улиралд мал, амьтныг тээвэрлэхэд вагоны дулаалгыг илгээгч хийж гүйцэтгэнэ;

11.9.5. Жижиг амьтдыг тээвэрлэхэд үл нэвчих ёроолтой салхивч бүхий битүү хайрцаг, сараалж болон торонд хийж хэд хэдэн давхар эгнээгээр байрлуулан тээвэрлэнэ. Хайрцаг, торыг вагоны хананаас 20 см-ийн зайтайгаар хананы дагуу байрлуулж хөдөлгөөнгүй бэхэлнэ;

11.9.6. Үслэг ан амьтныг тэдгээрийн төрлөөс шалтгаалан төмөр буюу бат бэх модон хайрцагт хийж, түгжээ, цоожтойгоор тээвэрлэнэ;

11.9.7. Ачаа илгээгч нь тээвэрлэгдэж байгаа мал, амьтныг ачихын өмнө вагоны шаланд шивтэр бага шингээх зорилгоор 10-15 см-ээс багагүй зузаантай үртэс, сүрэл дэвсэж замын турш хэрэглэгдэх сайн чанарын өвс тэжээл, усаар хангах үүрэгтэй;

11.9.8. Вагонд тээвэрлэх мал, амьтны нөөц тэжээл, ус, дэвсгэр материалыг вагоны хаалга хоорондох зайд буюу тэжээлийн тавиур дээр байрлуулна;

11.9.9. Хоногт нэг толгой мал, амьтан услахад зарцуулах усны дундаж хэмжээг дараах байдлаар тогтооно;

Гуравдугаар хүснэгт

Хоногт нэг толгой мал, амьтан услахад зарцуулах усны хэмжээ

• Адуу, Үхэр	10-12 л
• Тэмээ	20-25 л
• Хонь, ямаа, Гахай	1,5-2 л

11.9.10. Мал, амьтан ачсан вагонд сэлгээ хийхэд түрэгдэж шахагдахаас сэргийлэн огцом түлхэх, хэвгий газар зогсоох зэргээс онцгой болгоомжлох шаардлагатай. Сэлгээ хийхэд сэлгээний бригад нь ачаа хүргэгчдэд заавал урьдчилан мэдэгдэнэ;

11.9.11. Мал, амьтан хүргэгч нь маллагааны аргыг эзэмшиж, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангагдсан байна. Ачаа хүргэгч нь мал амьтан хордох, өвчлөх, тэжээл усандаа дургүйцэх тохиолдолд илчит тэрэгний бригадаар дамжуулан тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад мэдэгдэж, мал эмнэлгийн байгууллагаар холбогдох арга хэмжээг авахуулна;

11.9.12. Төмөр замаар мал, амьтан тээвэрлэх үед малын халдварт өвчин гарсан тохиолдолд тээвэрлэгчийн мэдэгдлээр холбогдох мал эмнэлгийн байгууллага нь улсын мал эмнэлгийн хууль, дүрэм, журам, зааврын дагуу тээвэрлэнэ;

11.9.13. Мал, амьтан ачсан вагонд техникийн гэмтэл тохиолдох үед өртөөний техник үзлэгийн газар уул вагоныг яаралтай засварлах, засварлах боломжгүй тохиолдолд шилжүүлэн ачих арга хэмжээг авна. Мал, амьтан ачсан вагон ачаа хүлээн авах өртөөнд ирсэн тухай өртөөний холбогдох ажилтан ачаа хүлээн авагчид мэдэгдэнэ;

11.9.14. Мал, амьтан тээвэрлэж ирсэн вагоныг суларсны дараа 12 цагийн дотор ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр вагоныг угааж ариутгана;

11.9.15. Хорио цээрийн дэглэм тогтоогдсон нөхцөлд тээвэрлэгч нь тухайн өртөөнөөс мал амьтан ачих буулгахыг даруй зогсоох арга хэмжээ авна. Хорио цээр тогтоогдсон өртөөн дээр мал, амьтан ачигдан ирэх тохиолдолд мал эмнэлэг ариун цэврийн асуудал хариуцсан улсын байцаагч, эмчийн шийдвэрээр өөр өртөөнд шилжүүлэн буулгах арга хэмжээ авна;

11.9.16. Мал, амьтан экспортлох, импортлох үйл ажиллагааг хүнс, хөдөө аж, ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр улсын мал эмнэлгийн эрх бүхий байгууллагын хяналтын дор, хилийн боомтын мал эмнэлгийн салбар бүхий төмөр замын өртөөгөөр дамжуулан гүйцэтгэнэ. Гадаад улсаас худалдан авч буй мал, амьтан нь илгээсэн орны мал эмнэлгийн байгууллагын гэрчилгээтэй байна;

11.9.17. Төмөр замаар ачигдаж яваа мал, амьтанд хийгдэх мал эмнэлгийн үзлэг шалгалт нь тогтоогдсон цаг хугацаанд багтаж хийгдэнэ. Харин малд эмчилгээ хийх, хорио цээр тогтоосноос болж тээвэрт гарсан саатлын талаар тухайн хилийн боомтын мал эмнэлгийн байгууллагаас акт үйлдэж ачааны падаанд хавсаргана;

11.9.18. Төмөр замаар мал, амьтан тээвэрлэхэд олон улсын ба хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу мал эмнэлгийн үзлэг шинжилгээг хийлгэж илгээлт тус бүрт 2 хувь гэрчилгээ авсан байна. Гэрчилгээнд төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн нэр, хаяг, мал амьтны тоо, гэрчилгээ олгосон мал эмнэлгийн байгууллагын хаяг, эмчийн гарын үсэг зэргийг засваргүйгээр тодорхой бичиж, тэмдэг дарсан байна;

11.9.19. Мал, амьтан ачсан вагоныг өртөөнд ирмэгц хүлээн авагчийн буулгах замд тавьж өгөх бөгөөд хүлээн авагч нь вагон тавьж өгснөөс хойш нэн даруй буулгана.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ **ЖИЖИГ ИЛГЭЭЛТИЙН АЧАА ТЭЭВЭРЛЭХ**

Жижиг илгээлт гэдэг нь хэмжээгээрээ вагоны эзлэхүүний 1/3-ээс хэтрэхгүй, жингээрээ 5000 кг-аас ихгүй ачааг хэлнэ.

12.1. Жижиг илгээлтийн 1 байр /ачмагтай болон боодолтой ачаа/-ын жин нь:

- битүү вагоноор тээвэрлэхэд 20 кг-аас багагүй, 1500 кг-аас ихгүй;
- задгай вагонд тээвэрлэхэд 1500 кг-аас багагүй 5000 кг-аас ихгүй.

12.2. Чингэлэг тээвэрлэхэд:

- их даацын чингэлгээр 20 кг-аас багагүй, 1500 кг-аас ихгүй;
- дунд даацын чингэлгээр 20 кг-аас багагүй, 120 кг-аас ихгүй байна.

12.3. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааны урт нь:

- битүү вагонд 2м -ээс ихгүй;
- задгай вагонд ачилтын техникийн нөхцөлд тохирсон;
- энэхүү журмын 8 дугаар бүлэг /Чингэлэгт ачаа тээвэрлэх/-т заасан шаардлагад нийцсэн байна.

12.4. Жижиг илгээлтийн тээврийг энэ төрлийн тээвэрт нээлттэй өртөөдийн хооронд тарифын бодлоготой нийцүүлэн гүйцэтгэнэ.

12.5. Вагон болон чингэлгээр тээвэрлэх жижиг илгээлтийн ачаа нь жижиг илгээлтийн ачаа тээвэрлэх гэрээний дагуу гүйцэтгэгдэнэ.

12.6. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг нийтийн хэрэглээний болон дагнасан хэрэглээний салбар замуудаас тээвэрлэгчид өгсөн захиалгыг үндэслэн хүлээн авна. Жижиг илгээлтээр тээвэрлэх захиалгын хуудсыг энэхүү журмын 2 дугаар бүлэг /ачааны захиалга хүлээн авах, зөвшилцөх/-т заасны дагуу ачаа илгээгчид олгоно.

12.7. Ачаа илгээгч нь энэхүү журмын 4 дүгээр бүлэг /орон нутгийн харилцааны тээврийн бичиг баримт бүрдүүлэх/-т заасны дагуу жижиг илгээлт бүрт падаан үйлдэнэ.

12.8. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг ачаа илгээгч нь тээвэрлэлтийн нөхцөл, зохих үндэсний стандартын шаардлагыг хангасан сав, баглаа, боодолтой байлгах үүрэг хүлээнэ.

12.9. Жижиг илгээлтийн ачааны байр бүр дээр ачаа илгээгчийн болон төмөр замын марклалыг ачаа хүлээн авах журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

12.10. Жижиг илгээлтээр тээвэрлэх аюултай ачааг төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмын дагуу хүлээн авна.

12.11. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг хүлээн авах агуулах, талбай нь тусгай зориулалтын байж болно:

- хүнд болон урт хэмжээний ачааг зориулалтын газарт гадна талд нь хураана;
- ачмагтай болон боодолтой ачааг жингээс нь хамааран хэд хэдэн давхар хураана;
- ачааны хураалт нь байрын тоог тодорхойлох, төмөр замын марклалыг шалгаж болохуйцаар хураагдсан байна.

12.12. Жижиг илгээлтээр тээвэрлэх ачааг хэсэгчлэн тээвэрлэгчид хүлээлгэн өгч болно. Тээвэрлэгч нь ачаа хүлээн авах актад болон падааны зохих хүснэгтэд хүлээн авсан ачааны тухай тэмдэглэл хийнэ. Ачаа хүлээн авах актын маягыг тээвэрлэгч тогтооно.

12.13. Вагон, чингэлэг нь жижиг илгээлтээр ачаа тээвэрлэхэд тэнцэх эсэхийг илгээгчийн захиалгыг үндэслэн тээвэрлэгч тогтооно.

12.14. Жижиг илгээлтийн ачааг вагон, чингэлэгт ачих буулгах ажлыг нийтийн хэрэглээний салбар замд төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, эсвэл тээвэрлэгч болон гэрээт тал гүйцэтгэж болно.

12.15. Задгай хөдлөх бүрэлдэхүүнд тээвэрлэгдэх жижиг илгээлтийн ачааны байрлал нь зам зуурын өртөөдөд буух ачааг буулгахад бусад ачааг хөдлөхгүйгээр байрлуулсан байна.

12.16. Жижиг илгээлттэй ачаатай вагон, чингэлэгт ломбо тавих нь энэхүү журмын 18 дугаар бүлэг /вагон, чингэлэг ломбодох/-т заасны дагуу хийгдэнэ.

12.17. Жижиг илгээлтээр тээвэрлэсэн ачааг энэхүү журмын 25 дугаар бүлэг /ачааг хүлээн авагчид олгох/-т заасны дагуу хүлээн авагчид олгоно.

12.18. Түргэн муудах жижиг илгээлтийн ачааг төмөр замаар энэхүү журмын 9 дүгээр бүлэг /түргэн гэмтэж, муудах ачааг тээвэрлэх/-т заасны дагуу гүйцэтгэнэ.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ
АЧАА ХҮРГЭХ ХУГАЦААГ ТООЦОХ

13.1 тээвэрлэгч ачааг хүрэх өртөөнд тогтоосон хугацаанд нь хүргэх үүрэгтэй.

Ачааг хүргэх хугацааг түүнийг тээвэрт хүлээн авч бичиг баримт үйлдэж, замын хүснэгтэд /илгээх өртөөний хуанлийн дардас/ огноо дарсан өдрийн дараах хоногийн 00 цагаас эхлэн тооцно.

13.2. Ачаа болон тээвэрлэгчийн эзэмшлийн бус хоосон вагон ба чингэлгийн хүргэх хугацааны нормыг тооцохдоо /цаашид хүргэх хугацаа гэх/ илгээх өртөөнөөс тарифын мөрдлөгөөр тогтоосон зай, чиглэл, тээврийн хөлс төлөлт, илгээлтийн төрөл зэргээс хамааруулан тогтооно. Нэг хоног хүрэхгүй хугацааг бүтэн хоногт тооцно.

13.3. Вагон, чингэлэг, жижиг илгээлтийг ачааны хурдаар тээвэрлэх тарифын зайн хэмжээгээр /их, бага хурдаар/ тогтооно. Ачаа тээвэрлүүлэх хурдыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч сонгож, падаанд тэмдэглэл хийнэ.

13.4. Ачаа хүргэх хугацааг дараах байдлаар тодорхойлно.

13.4.1. Бага хурдаар тээвэрлэх ачаа:

Дөрөвдүгээр хүснэгт
Бага хурдаар тээвэрлэх ачаа

Ачаа илгээх хугацаа	1 хоног;
Бусад илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 200 км тутамд	1 хоног;
Чингэлэг илгээлтээр ачаа тээвэрлэх хугацааг тээвэрлэлтэд оролцох төмөр замын хязгаарт эхэлсэн тарифын 150 км тутамд	1 хоног;

13.6. Дараах тохиолдолд ачаа хүргэх хугацаа нэмэгдэнэ:

Тавдугаар хүснэгт
Ачаа хүргэх хугацаа нэмэх нөхцөл

Ачааг тээвэрт хүлээн авч, явуулах ажиллагаа	2 хоног;
Хэд хэдэн суурь бүтэц дамжих ажиллагаанд	1 хоног;
Өөр төрлийн тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачилт хийхэд	1 хоног;
Ачааг өөр царигийн вагонд шилжүүлэн ачилт хийхэд	2 хоног;
Илгээлтийн хаяг солилт	1 хоног;
Ачааг тээвэрлэх 1000 км тутамд /техникийн ажиллагаанд/	1 хоног;
Вагоны явах ангийг өөр царигийн явах ангиар солих ажиллагаа	1 хоног;
Хилийн өртөөнд хийгдэх гааль, хорио цээр болон хилийн хяналт шалгалт	1 хоног;
Ачааны жинг тодорхойлох	1 хоног;
Аюултай ачаа тээвэрлэх	1 хоног;

13.7. Ачаа хүргэх хугацааг доорх тохиолдолд саатсан хугацаагаар нэмэгдүүлнэ:

13.7.1. Хяналт шалгалт хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шаардлагаар шалгалт хийсэн;

13.7.2. Ачаа илгээгчийн буруугаас ачилтыг буруу гүйцэтгэсэн, шилжүүлэн ачсан буюу зам зуурт зассан;

13.7.3. Төмөр замын тээврийн байгууллагаас хамааралгүйгээр техникийн гэмтэл болон ачаа тээврийн дутагдалаар саатсан;

13.7.4. Байгалийн давагдашгүй хүчин зүйл (онц байдал, Ковид 19 г.м)- ээс саатсан;

13.7.5. Мал, амьтан, өртөөн дээр услахаар болон вагоноос гаргаж мал эмнэлгийн үзлэг хийхэд саатсан.

13.8. Энэхүү журмын 13.4-т заасан тохиолдлуудаар ачаа болон вагон чингэлэг саатсан бол тээвэрлэгч ерөнхий маягтын акт тогтооно. Энэ тохиолдолд тээврийн бичиг баримтын зохих хүснэгтэд тэмдэглэл хийнэ.

13.9. Тээврийн бичиг баримтын "тээвэрлэгчийн тэмдэглэл" гэсэн хүснэгтэд ачааны нэрийн доод талд ерөнхий маягтын акт тавьсан шалтгаанаа бичнэ. Хэрвээ хэт хэтрүү овортой ачаа ачсан тохиолдолд хүргэх огноог бичихгүй.

13.10. Хэтрүү овортой ачааны хүргэх хугацааг дараах нормыг баримтлан тодорхойлно.

Зургаадугаар хүснэгт

Хэтрүү овортой ачааны хүргэх хугацаа

▪ I-IV зэргийн овортой ачааг 100 км	1 хоног;
▪ V зэргийн овортой ачааг 80 км	1 хоног;
▪ VI болон хэт хэтрүү овортой ачаанд	тогтоохгүй

13.11. I-V зэргийн хэтрүү овортой ачаанд хүргэх хугацааг доорх хугацаагаар нэмэгдүүлэн тогтооно.

Долоодугаар хүснэгт

I-V зэргийн хэтрүү овортой ачаанд хүргэх хугацаа

▪ Өртөө нь ачааг илгээхээр төмөр замын тээврийн байгууллагаас зөвшөөрөл авахад	1 хоног;
▪ Нэг төмөр замын тээврийн байгууллагаас нөгөө төмөр замын тээврийн байгууллагад ачаа шилжүүлэн өгөх бүрт	1 хоног;

13.12. Доорх тохиолдолд ачааг хүрсэнд тооцно:

13.12.1. Падаанд заасан хугацаанаас өмнө тээвэрлэгч ачааг хүлээн авагчид хүлээлгэн өгсөн тохиолдолд;

13.12.2. Ачаа нь тээврийн бичиг баримтад заасан хугацаанд ирсэн боловч хүлээн авагчийн буруугаас /өөрийн гэсэн салбар замгүй, фронт эзэлгээтэй, төлбөр тооцоо хийгээгүй г.м/ буухгүй удсан тохиолдолд ачааг ирсэнд тооцно. Энэ тохиолдолд ерөнхий маягтын акт тогтооно;

13.12.3. Хүлээн авагчид ачаа ирсэн тухай мэдэгдсэн бол мэдэгдсэн хугацаа нь ачаа ирсэн хугацаа болно.

13.13. Төмөр замын тээврийн байгууллага нь ачаа гаалийн хяналтанд байх хугацаанд хариуцлага хүлээхгүй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙГ БАРИМТЛАН ТЭЭВЭРЛЭХ АЧАА

14.1. Ачаа илгээгчийн тээвэрлүүлэх ачааны шинж чанарын байдлаас шалтгаалж, ачилтын нөхцөл нь энэхүү журамд заагдаагүй байвал тээвэрлэгч нь ачаа илгээгчтэй хамтран тээвэрлэлт, бүрэн бүтэн байдлыг хангах талаар гэрээ байгуулж болно.

14.2. Ачаа илгээгч тээвэрлэгчтэй онцгой нөхцөлөөр ачаа тээвэрлэх гэрээ байгуулахаас өмнө нөхцөлийг тохиролцсон байна.

14.3. Төмөр замын тээврийн байгууллага нь дараах онцгой нөхцөлийг баримтлан тээвэрлэлт хийнэ.

14.3.1. холимог тээврээр дамжин төмөр замын өртөөнд ирэх импортын түргэн муудах ачаа;

14.3.2. шинэ баглаа, боодол, техникийн болон ачааны үндэсний стандартанд тохирохгүй ачааг тээвэрлэх;

14.3.3. Төмөр замаар энэхүү журмын 9 дүгээр бүлэг /түргэн гэмтэж, муудах ачаа тээвэрлэх/-т заагдсан ачаа хүргэх хугацаанаас илүү хугацаатай түргэн муудах ачаа тээвэрлэх;

14.3.4. Төмөр замаар хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг ашиглаж тээвэрлэхэд заагдаагүй зарим төрлийн ачааг тээвэрлэх.

14.4. Онцгой нөхцөлийг баримтлан тээвэрлэгдэх ачааны тухай илгээгчийн хүсэлтийг хүлээн авах, хянан шийдвэрлэх, гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалтыг тээвэрлэгч тогтооно.

14.5. Онцгой нөхцөл баримтлан тээвэрлэх ачааны бичиг баримт:

14.5.1. Төмөр замын тээврийн падааны 1 дэх хүснэгтэд ачаа илгээгч "онцгой нөхцөлийг баримтлах тээвэрлэлт. Ачаа хүлээн авагчтай зөвшилцсөн ...оны... Сарын ... Өдрийн № тоот гэрээ" гэсэн тэмдэглэл хийнэ;

14.5.2. Онцгой нөхцөл баримтлан ачаа тээвэрлэх үед ачаа илгээгч төмөр замын тээврийн байгууллагад бичгэн хүсэлтийг ачааг тээвэрлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Энэ хугацааны дотор тээвэрлэгч онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх боломжийг судалж, тухайн тээвэрлэлт хийх боломжтой бол гарын үсэг зурж, 2 хувь гэрээг ачаа илгээгчид өгнө. Онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх тээвэрлэлтийг хийх боломжгүй тохиолдолд тээвэрлэгч нь шалтгааныг дурдан татгалзсан хариуг ачаа илгээгчид өгнө. Ачаа илгээгч нь төмөр замын тээврийн байгууллагын гарын үсэг зурсан 2 хувь гэрээг хүлээж аваад гарын үсгээ зурж, баталгаажуулан 1 хувийг төмөр замын тээврийн байгууллагад буцааж өгнө;

14.5.3. Төмөр замын тээврийн байгууллага нь онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх үед батлагдсан гэрээний дагуу цахилгаанаар өөрийн мэдлийн хэсэглэлд энэ тээвэрлэлтийн үндсэн нөхцөлийг мэдэгдэнэ. /илгээх өртөө, хүрэх өртөө, ачааны төрөл, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний төрөл, талуудын харилцан хүлээх хариуцлага, онцгой нөхцөлийн үйлчлэх хугацаа болон бусад зүйлийг зааж өгнө/;

14.5.4. Төмөр замын тээврийн байгууллага нь онцгой нөхцөлийг үндэслэн ачаа тээвэрлэх гэрээний нөхцөл, энэхүү журмыг баримтлан ачааг тээвэрлэсэн тохиолдолд ачаатай холбогдож гарсан маргааныг хариуцахгүй;

14.5.5. Онцгой нөхцөл баримтлан ачаа тээвэрлэх гэрээнд заагдаагүй асуудлаар тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хооронд гарсан маргааныг монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ;

14.5.6. Шууд холимог тээвэрлэлтэд онцгой нөхцөлийг баримтлан ачаа тээвэрлэх, түргэн гэмтэж, муудах ачаа тээвэрлэх нөхцөлийг тухайн тээврийн төрлийн ачаа тээвэрлэхтэй холбогдсон дүрэм, журмаар зохицуулна.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

ҮНЭ ЗАРЛАСАН АЧААГ ТЭЭВЭРЛЭХ

15.1. Үнэ зарлах ачаа

15.1.1. ачаа илгээгч ачааг тээвэрт хүлээлгэн өгөхөд дараах төрлийн ачаанд заавал үнэ зарлуулж тээвэрлүүлнэ:

- алт, мөнгө, цагаан алт болон эдгээрээр хийсэн эдлэл;
- үнэт чулуу;
- үнэт үс /минж, цэнхэр, цагаан үнэг, үен, суусар, усны булга, халиу, каракуль, далайн нохой, эвшгээс, хар хүрэн үнэг, булга зэрэг/ болон эдгээрээр хийсэн эдлэл;
- авсан кино зураг;
- уран зураг;
- баримал;
- урлагийн эдлэл;
- хуучин ховор юмс
- гэрийн эд хогшил.

15.1.2. Гэрийн эд хогшлыг тээвэрт хүлээлгэн өгөхдөө ачаа илгээгч үнэ зарлаж болно. Үнэ зарлаагүй тохиолдолд падааны зохих хүснэгтэд "үнэ зарлаагүй" гэсэн тэмдэглэл хийж, гарын үсгээрээ нотолсон байна.

15.1.3. Энэхүү жумын 15.1.1-т дурдсанаас бусад ачааг тээвэрлэлтэд хүлээн авахад илгээгчийн хүсэлтээр үнэ зарлана;

15.1.4. Ачааны үнийг түүний өртгийн дүнгээс хамааруулж зарлана;

15.1.5. Ачааны өртгийг худалдагчийн нэхэмжлэл буюу гэрээнд заасан, үнийг, эдгээр үнэ байхгүй бол ижил төрлийн барааны үнийг харьцуулж тодорхойлно;

15.1.6. Үнэ зарласан ачааг тээвэрлэх хөлс, хураамжийг тарифын мөрдлөгийн дагуу авна.

15.2. Үнэ зарласан ачааг тээвэрт хүлээн авах:

15.2.1. Ачаа илгээгч үнэ зарлах ачааг тээвэрт хүлээлгэн өгөхдөө тээврийн бичиг баримтын падаан дахь зохих хүснэгтэд үнэ зарласан тухай тэмдэглэнэ;

15.2.2. Үнэ зарласан ачааны жагсаалтыг падаанд хавсаргана;

15.2.3. Бүлэг вагоныг тээврийн нэг бичиг баримтаар тээвэрт өгөхөд ачаа нь өөр өөр үнэ зарласан бол тэдгээрийн ялгагдах шинж тэмдэг, байрын тоо, зарласан үнэ зэргийг ачааны жагсаалтад тусад нь мөрөнд зааж өгнө;

15.2.4. Үнэ зарласан ачааны жагсаалтыг 3 хувь үйлдэж, 1 хувийг ачаа илгээгчид, 1 хувийг төмөр замын тээврийн байгууллагад, 1 хувийг вагон буюу чингэлэг дотор хананд харагдахаар газарт наана. Ачааг жижиг илгээлтээр тээвэрлэхэд тухайн илгээлтийн аль нэг ачаанд наана. Шингэн болон нурмаг ачаанд наадас наах боломжгүй тул 2 хувь бичнэ; (Хуулийн нэр томьёо өөрчлөгдсөн)

15.2.5. Төмөр замын тээврийн байгууллага тухайн ачааны жагсаалтад заасан ачааны байрын тоо тохирч байгаа эсэхийг шалгана; (Хуулийн нэр томьёо өөрчлөгдсөн)

15.2.6. Иргэний, гэр бүлийн хэрэгцээний, ахуйн болон арилжааны бус шинжтэй ачааг тээвэрт хүлээн авах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна;

15.2.7. Тээврийн бичиг баримтыг бүрдүүлэх үед тээвэрлэгч нь ачаа илгээгчийн бичсэн үнэ зарласан ачааны жагсаалтыг зөв эсэхийг шалгаж түүнд падааны дугаарыг бичиж гарын үсгээ

зураад хуанлийн дардас дарна. Үнэ зарласан ачааны жагсаалт хэд хэдэн хуудастай бол хуудас бүрт ачаа илгээгч-төмөр замын тээврийн байгууллагын гарын үсэг болон хуанлийн дардсыг дарна;

15.2.8. Үнэ зарласан ачааг тээвэрлэх вагон болон чингэлгийг ломбодож битүүмжлэхийг энэхүү журмын 18 дугаар бүлэг /вагон, чингэлэг ломбодох/-т зааснаар зохицуулна;

15.2.9. Ачааны зарласан үнийн дүнг илгээгч падааны зохих хүснэгтэд "төгрөг"-өөр бичих бөгөөд энэ нь нийлүүлэгчийн нэхэмжлэхэд зааснаас эсвэл жинхэнэ үнээс хэтрэх ёсгүй;

15.2.10. Ачааг тээвэрлэлтэд хүлээн авахад зарласан үнийн хэмжээ нь түүний өртөгтэй зохицох эсэхийг шалгана. Тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хооронд зарласан үнийн талаар маргаан гарвал түүний илгээх өртөөнд тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

15.3. Үнэ зарласантай холбогдон гарах хариуцлага:

15.3.1. Ачаа илгээгчийн ачааны зарласан үнэ тухайн ачааны жинхэнэ өртгөөс хэтрэх ёсгүй;

15.3.2. Зарласан үнэтэй ачааны тээвэрлэлтийн үед төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид учирсан хохирлыг зарласан үнийн хэмжээнд төмөр замын тээврийн байгууллага нь нөхөн төлнө;

15.4. Гомдол гаргах

15.4.1 үнэ зарласан ачаа алдагдах, гэмтэх, тоо ширхэг, жин дутах үед төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, нь төмөр замын тээврийн байгууллагад гомдол гаргана;

15.4.2. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, нь бодит хохирлын нотлох баримтуудыг гомдол гаргах үедээ төмөр замын тээврийн байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй;

15.4.3. Гомдол хүлээн авсан тээвэрлэгч нь гомдлыг олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, түүний албан заавар, энэхүү журмын дагуу шийдвэрлэн хохирлыг барагдуулах буюу зохих хариу өгнө.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХЭТРҮҮ ОВОРТОЙ, УРТ ХЭМЖЭЭТЭЙ, ХҮНД ЖИНТЭЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ

16.1. Төмөр замаар хэтрүү овортой, хүнд жинтэй ачааг тээвэрлэхэд задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачаа ачиж бэхлэх техникийн нөхцөл, төмөр замын техник ашиглалтын дүрэм, галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

16.2. Ачилтын овор, хэтрүү овортой ачааны ангилал:

16.2.1. Төмөр замаар тээвэрлэх ачаа нь "задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачаа ачиж бэхлэх техникийн нөхцөл" /цаашид "техникийн нөхцөл" гэх/-д тусгагдсан ачилтын оврын хэмжээнээс хэтрэхгүй байна;

16.2.2. Урт ачаа гэдэгт вагоны 2 талын төгсгөлийн ялуунаас 400 мм ба түүнээс илүү гарсан ачааг тооцно;

16.2.3. Тэгш шулуун зам дээр зогсож байгаа задгай хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэг нь замын тууш тэнхлэгтэй нэг босоо хавтгайд давхцаж байхад түүн дээр ачсан ачаа нь баглаа, боодол, бэхлэгээнийхээ хамтаар ачилтын оврын хязгаар хүрээндээс хэтрээгүй байвал түүнийг оворгүй ачаа гэнэ. Урт хэмжээтэй ачаанд зөвшөөрөгдөх, ачилтын оврын хөндлөнгийн хэмжээг техникийн нөхцөлийн дагуу тогтооно;

16.2.4. Зам төмрийн толгойн түвшингөөс задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачсан ачааны доод цэг хүртэлх хамгийн бага зөвшөөрөгдөх зай нь 150 мм-ээс багагүй байна;

16.2.5. Тэгш шулуун зам дээр зогсож байгаа задгай хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэг замын тууш тэнхлэгтэй давхцаж байхад түүн дээр ачсан ачаа нь баглаа, боодол, бэхэлгээнийхээ хамтаар ачилтын оврын хэмжээнээс илүү гарч байвал түүнийг хэтрүү овортой ачаанд тооцно. Мөн түүнчлэн замын тахир хэсэг дээр 17 м баазтай, 24 м урттай вагонд ачигдсан ачаа нь тооцоот вагоны геометр хэтрэлтээс илүү гарч байвал хэтрүү овортой ачаанд тооцно. Ачаа ба хөдлөх бүрэлдэхүүний геометр хэтрэлт гэж замын тахир хэсэг дээр хөдлөх бүрэлдэхүүний ба ачааны тууш тэнхлэг нь замын тэнхлэгээс хажуу тийш шилжих шилжилтийг хэлнэ;

16.2.6. Ачаа нь зам төмрийн толгойн түвшингөөс дээш ямар өндөрт ачилтын оврын хязгаарын хүрээнээс хэтэрч байгаагаас хамааруулан ачааны хэтрүү оврыг гурван төрлийн бүсэд хуваана.

Наймдугаар хүснэгт
Ачилтын оврын хязгаарын төрөл

Д/д	Хэтрүү овор тодорхойлогдох бүс	Зэрэг	Зам төмрийн толгойн түвшингөөс дээш хэтрүү оврын тодорхойлогдох өндөр, мм	Замын тэнхлэгээс, мм
1	Доод	1	480-1400	1626-1700
		2	480-1400	1701-1760
		3	1230-1400	1761-1850
		4	1230-1400	1851-2000
		5	1230-1400	2001-2080
		6	1230-1400	2081-2240
2	Хажуу	1	1401-4000	1626-1700
		2	1401-4000	1701-1800
		3	1401-4000	1801-1850
		4	1401-3700	1851-2000
		5	1401-3400	2001-2080
		6	1401-2800	2081-2240
3	Дээд	1	4001-5300	621-880
		2	4001-5300	881-1080
		3	4001-5300	1081-1120

16.2.7. ачилтын оврын хязгаарын хүрээнээс илүү гарах ачааны хэтрэлт, түүнийг төмөр замын төхөөрөмж, байгууламжаар нэвтрүүлэн өнгөрүүлэх боломж нөхцөлөөс хамааруулан бүс тус бүрийг зэрэгт хуваана. Ачааны хэтрүү оврын зэргийг тогтоохдоо түүнийг зөвхөн тэгш шулуун зам дээр байна гэж үзэх төдийгүй замын тахир дээгүүр өнгөрөх нөхцөлийг давхар тооцно. Тооцоот хэтрүү оврыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч дор дурдсан тохиолдолд тодорхойлно:


- ачааны уртыг хөдлөх бүрэлдэхүүний баазад харьцуулсан харьцаа нь 1.41-ээс их байх урт хэмжээтэй ачаа;
- ▪ ачааг угсраа тавцан вагонуудад тээвэрлэх үед;
- ▪ ачааг 17 м ба түүнээс урт баазтай транспортерт тээвэрлэх үед тус тус тодорхойлно

16.2.8. Ачаа нь хөндлөнгөөрөө дээд iii зэрэг, хажуугийн iv зэрэг /зам төмрийн толгойн түвшингөөс 3700-4000 мм өндөрт/, v зэрэг /зам төмрийн толгойн түвшингөөс 3400-3700мм өндөрт/, vi зэрэг, доод ii зэрэг /зам төмрийн толгойн түвшингөөс 380-1400 мм өндөрт/, vi зэргийн хэтрүү овруудын хязгаарын хүрээнээс илүү гарах болон iii-vi зэргийн доод хязгаараас /зам төмрийн толгойн түвшингөөс 1230 мм-ээс доош/ илүү

гарсан ачаа, мөн 5300 мм-ээс дээш өндөрт ачилтын оврын хүрээнээс тус тус гадагш илүү гарч байвал түүнийг хэт хэтрүү овортой ачаа гэнэ. 5300 мм-ээс дээш өндөртэй хэт хэтрүү овортой ачааг босоо хэт хэтрүү овортой ачаа гэнэ;

16.2.9. Хэт хэтрүү овортой, доод болон хажуугийн vi зэргийн хэтрүү овортой ачааг хяналтын жаазтайгаар тээвэрлэнэ. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд галт тэрэгний аяллын замд овор хэмжээнд үл нийцэх төхөөрөмж байгууламж байгаа болон тэдгээрийн бодит хэмжээнээс хамааран тээвэрлэгчийн шийдвэр дээр зааснаас бага зэрэгтэй хэтрүү овортой ачааг хяналтын жаазтайгаар тээвэрлэнэ.

2 дугаар зураг. Хэтрүү оврын бүс ба зэрэг



1-ээр ачилтын овор, зураг 2-оор хэтрүү оврын бүс ба зэргүүдийг, зураг 3-аар доод хэтрүү оврын 6 зэргийг тус тус үзүүлэв.

16.3. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг ачих, хүлээн авах, тээвэрлэлтэд бэлтгэх:

16.3.1. Илгээгч нь хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг төмөр замаар тээвэрлэхийн өмнө төмөр замын тээврийн байгууллагатай тохиролцоно үүнд:

- тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтантай ачаа тээвэрлэх боломж аргыг урьдчилан тохиролцох;

- ачаа ачилтын зураг, тооцооны баримт бичгүүдийг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтантай тохиролцох;

- тусгай хөдлөх бүрэлдэхүүн транспортер дээр ачих ачаа болон хэтрүү овортой ачааг ачих ачааны зураг, тооцооны баримт бичгийг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулах.

Төмөр замын тээврийн байгууллагуудын хооронд тээвэрлэлтэнд нэвтрээгүй бэхэлгээний хэрэгсэл ашиглан ачаа тээвэрлэх тохиолдолд ОАХХ-ын 3-р хавсралтыг мөрдлөг болгоно.

16.3.2. Илгээгч нь төмөр замын тээврийн байгууллагатай урьдчилан зөвшилцөхдөө тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад илгээх ачааныхаа 3 хавтгай дээрх /хажуу, дээр, урдаас харсан/ 4 хувь зургийг захиалгын хамт ирүүлнэ;

16.3.3. Ачааны жин, урт, вагоны шаланд өгөх ачаалал нь 4 голт вагонд техникийн нөхцөлийн дагуу тогтоосон хэмжээ, вагоны нэг гол дээрх даралтыг тогтоосон нормоос хэтэрч байвал түүнийг хүнд жинтэй ачаанд тооцох бөгөөд транспортер вагонд тээвэрлэнэ;

16.3.4. Илгээгч нь—төмөр замын тээврийн байгууллагаас ачаа тээвэрлэх зөвшөөрлийг авсны дараа ачилтын бичиг баримтыг бүрдүүлнэ. Тооцооны бичиг баримт нь ачилтын зураг, хэтрүү оврын тооцоо, ачааны байрлал, бэхэлгээ, тогтворжилт, шаардлагатай бол хяналтын жаазны зургаас бүрдэнэ.

16.3.5. Ачилтын зураг нь 1:20, 1:25, 1:50 масштабээр үйлдэгдэх ба хөдлөх бүрэлдэхүүн дээрх ачааны байрлал, бэхэлгээний 3 хавтгай дээрх зургийг агуулсан байна. Нарийн төвөгтэй хэлбэр дүрс бүхий тооцоот хэтрүү овортой, урт хэмжээтэй ачааны хөндлөн огтлолын нэмэлт зургууд байх ба хэт хэтрүү овортой ачааны зургийг 1:20, 1:10 масштабээр үйлдэнэ. Хяналтын жаазны зургийг 1:20 эсвэл 1:10 масштабээр үйлдэнэ.

- хөдлөх бүрэлдэхүүний тууш тэнхлэгээс эхтэй хөндлөн хэмжээ /x/;
- зам төмрийн толгойн түвшингөөс эхтэй босоо хэмжээ /y/;
- тавцан ба хагас вагоны хамгийн ойрын чиглүүлэгч огтлол хүртэлх хэмжээ;
- ачилтын зурагт ачааны хүндийн төвийн байрлал, түүний бэхэлгээтэй болон бэхэлгээгүй үеийн жин, хөдлөх бүрэлдэхүүний төрөл, загвар, замын шулуун хэсэг дэх хэтрүү оврын болон тооцоот хэтрүү оврын бүс, зэрэг, вагоны нэг голоос зам төмөрт ирэх ачаалал, ялгах довоор хэрхэн өнгөрүүлэх нөхцөл зэргийг заасан байна;
- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь тээвэрлэгчид төмөр замын тээврийн байгууллагад хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны жин, хэмжээг үнэн зөв өгөх бөгөөд буруу өгснөөс гарах хариуцлагыг хүлээж учирсан хохирлыг барагдуулна;
- байгууллагууд ирүүлэх тооцоонд ачаатай транспортерийн тогтворжилтыг шалгаж хэтрүү оврыг тодорхойлно;

- транспортер дээр ачааг ачаанд гагнасан сэнжнээс тогтоож бэхлэх; /жишээлбэл: трансформаторт/;
- ачааг түүнд бэхэлсэн тусгай төхөөрөмжийг ашиглан транспортер дээр байрлуулах; /жишээлбэл: уурын генератор/;
- транспортер дээр бэхлэгдсэн нэвт хөндлөвч дамнуур дээр ачааг суурилуулж байрлуулах.

16.3.6. Ачааг тээвэрлэхэд хэрэглэгдэх тусгай жааз, сэнж, тусгай төхөөрөмж, бат бэхийн тооцоог ачаа илгээгч тогтоосон нормоор гүйцэтгэх ба шалгаж үзнэ;

16.3.7. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны байрлал, бэхэлгээний тооцоо бүдүүвч зурагтайгаа тохирч байгаа эсэхийг төмөр замын тээврийн байгууллага тогтооно;

16.3.8. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг тээвэрлэх задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачиж бэхлэх техникийн нөхцөлийн зураг схем, түүний тооцоог батлуулж ачаа илгээгч ачилтын сар эхлэхээс 20 хоногийн өмнө захиалгаа төмөр замын тээврийн байгууллагад ирүүлнэ;

16.3.9. Хэтрүү болон хэт хэтрүү овортой ачааг төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ачна.

16.4. Ачаа илгээгчийн хүлээх үүрэг:

16.4.1. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг техникийн нөхцөлийн шаардлагад бүрэн нийцүүлж тээвэрлэлтэд бэлтгэнэ;

16.4.2. Батлагдсан зурагт нийцүүлж ачилтыг хийх ба ачилт дууссаны дараа арилахгүй тод өнгийн будгаар вагоны шал, ачаан дээр хяналтын зураас тавих ба мөн ачаан дээр түүний хэтрүү оврын индекс, довоос буулгахыг хориглох зэргийг заасан тэмдэглэл хийнэ;

16.4.3. Шаардлагатай тохиолдолд хяналтын жаазыг үйлдэж вагонд байрлуулах ба онцгой үед ачааны явах замналыг урьдчилан түүний биет загвараар шалгах бол ачааны биет загварыг хийнэ;

16.4.4. Ачигдсан вагоныг комиссын үзлэгт оруулахад бэлэн болсон тухай өртөөний эрх бүхий ажилтанд мэдэгдэнэ.

16.5. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааны байрлал бэхэлгээг шалгах

16.5.1. Хүнд жинтэй ба хэтрүү овортой ачааг байрлуулж бэхэлсэн бодит байдал төмөр замын байгууллагын баталсан зураг, тооцоотой тохирч байгаа эсэхийг дараах бүрэлдэхүүнтэй комисс шалгана. Төмөр замын тээврийн байгууллагын (өртөө) дарга буюу орлогч дарга, ДТХ-ийн ажилтан, замын засвар үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгжийн замын мастер, бригадын дарга болон вагоны техник үйлчилгээний нэгжийн дарга буюу ахлах вагон үзэгч байхаас гадна тээврийн бусад мэргэжлийн хүнийг оролцуулж болно.

16.5.2. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг хэрхэн байрлуулж бэхэлснийг комисс шалгаж дор дурдсан зүйлийг тодорхойлно;

- хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдал;
- транспортерын ачилтын талбайн болон вагоны шалны ачаатай байдал дахь өндрийн хэмжээ;
- ачааны байрлал, бэхэлгээ, хүндийн төв ачилтын зурагт заасантай тохирч байгаа эсэх;
- ачааны хэтрүү оврыг тодорхойлж буй цэгүүдийн жинхэнэ координат /X,У/;
- ачаан дээр түүний хэтрүү оврыг заасан хяналтын зураас түүнчлэн довоос буулгахыг хориглосон ба довоор нэвтрүүлэхийг заасан бичиглэл байгаа эсэх;
- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хяналтын жаазыг зөв хийж, зөв байрлуулсан эсэх.

16.5.3. Ачааг шалгасны дараа хэтрүү овортой, хүнд жинтэй ачааны байрлал бэхэлгээг шалгасан тухай актыг хоёр хувь үйлдэх бөгөөд 1 хувь нь тээврийн бичиг баримтад хавсаргах ба хоёр дахь хувь нь төмөр замын тээврийн байгууллага (өртөө)-д хадгалагдана.

16.5.4. Төмөр замын тээврийн байгууллага ачаа дамжин өнгөрөх бүх өртөө зөрлөгүүдэд түүнийг хэрхэн нэвтрүүлэх тухай бүртгэлт тушаалыг өгнө;

16.5.5. Ачаа нь галт тэрэгний хөдөлгөөнд аюул учруулахаар шилжиж хөдөлсөн ба бэхэлгээ нь зөрчилтэй үед арилгах арга хэмжээг авч шаардлагтай тохиолдолд энэхүү журмын 16.5.1-д заасан комисс ажиллана.

16.6. Хүнд жинтэй, хэтрүү овортой ачааг хоорондын зам болон өртөөгөөр нэвтрүүлэх:

16.6.1. I-II зэргийн доод, хажуугийн I-III, дээд I-II зэргийн хэтрүү овортой ачааг ердийн нөхцөлөөр явуулна;

16.6.2. III-VI зэргийн доод, хажуугийн IV-VI зэрэг III зэргийн дээд хэтрүү овортой болон хэт хэтрүү овортой ачааг нэвтрүүлэн өнгөрүүлэх үед хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна;

16.6.3. Өртөөний замаар IV-VI зэргийн хажуугийн ба III-VI зэргийн доод хэтрүү овортой болон хэт хэтрүү овортой ачаатай галт тэргийг өнгөрүүлэх үед өртөөний зам дээр ажиллаж байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг хангахад зайлшгүй мөрдөгдөх арга хэмжээг тээвэрлэгчийн шийдвэрээр тогтооно;

16.6.4. Хэтрүү оврын индекс нь хэтрүү овруудын индексийг заасан 4 оронтой тооноос бүрдэх бөгөөд эхний цифр нь доод хэтрүү овор, хоёр дахь цифр нь хажуугийн хэтрүү овор, гурав дахь цифр нь дээд хэтрүү овор, дөрөв дэх цифр нь босоо хэтрүү оврын зэргүүдийг тус тус заана. Жишээ нь: Н-2030-ын Н-хэтрүү овортой /негабаритный/, 2-доод II зэргийн хэтрүү овор, 0 -хажуугийн хэтрүү оворгүй, 3-дээд III зэргийн хэтрүү овортой, 0 -босоо хэтрүү оворгүйг зааж байна;

16.6.5. Хэтрүү оворгүй бол 0 гэсэн цифрээр илэрхийлнэ. Хэрэв галт тэргэнд хэтрүү овортой хэд хэдэн ачаа байгаа бол хэтрүү оврын индексийг овор тус бүрийн хамгийн дээд зэргүүдийг заасан тоогоор илэрхийлж бичнэ;

16.6.6. Галт тэргэнд хэт хэтрүү овортой ачаатай вагон байгаа бол хэтрүү оврын индексэд 8 гэсэн тоогоор тэмдэглэнэ. Жишээлбэл: Н-8538 гэсэн индексийн 8 нь доод хэт хэтрүү овор, 5 нь хажуугийн V зэрэг, 3 нь дээд III зэрэг, 8 нь босоо хэт хэтрүү овортой ачаа байгааг заана;

16.6.7. Галт тэрэгний биечилсэн хуудас үйлдэж буй өртөөний ажилтан галт тэргэнд хэтрүү овортой ачаа байгаа бол хэтрүү оврын индексийг биечилсэн хуудсанд бичнэ;

16.6.8. Галт тэрэгний диспетчер хүнд жинтэй хэтрүү овортой ачаатай галт тэргийг явуулахын өмнө дараах үүргийг хүлээнэ.

16.7. Хяналтын жаазтайгаар тусгай галт тэргээр тусдаа зүтгүүртэй хэтрүү болон хэт хэтрүү овортой ачааг тээвэрлэхэд хяналтын жаазнаас 5 вагоноос ойргүй зайд байна. Тухайн ачааг галт тэрэгний төгсгөлөөс хоосон ба овор хэмжээнд багтсан нэгээс доошгүй вагоноор халхалсан байна;

16.7.1. Доод III-V ба хажуугийн IV-V зэргийн хэтрүү овортой ачааг галт тэрэгний толгой ба сүүлээс нэгээс доошгүй хоосон тавцант буюу оворот багтсан вагоноор халхална.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

ЦИСТЕРН БОЛОН БУНКЕРТ ВАГОНД ШИНГЭН АЧАА ТЭЭВЭРЛЭХ

17.1. Ачаа илгээгч хөдлөх бүрэлдэхүүнийг өөрөө сонгох эрхтэй

17.2. Тээвэрлэлтэд ирүүлэх ачаа нь тухайн бүтээгдэхүүний үндэсний стандарт ба техникийн нөхцөлийг хангасан байна.

17.3. Төмөр замын тээврийн падаанд ачааны нэр, онцгой тэмдэглэл, ачааны шинж чанарын тухай мэдээллийг буруу бичсэнээс ачаа тээвэрлэх хөлс буурсан, төмөр замын тээврийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд аюул үүсгэх нөхцөл бүрдсэн болон төмөр замын тээврээр тээвэрлэхийг хориглосон ачааг явуулснаас учирсан хохирлыг төлсөн эсэхийг үл харгалзан ачааг гэрээнд заасан торгуулийг Төмөр замын тээврийн байгууллага ачаа илгээгч төлнө.

17.4. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, тээвэрлэгч, суурь бүтэц эзэмшигчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хор хохирлын хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.

17.5. Цистерн ба бункерт вагонд тавигдах шаардлага:

17.5.1. Шингэн ачааг тээвэрлэхэд техникийн гэмтэлгүй цистерн, тусгай цистерн бункерт хагас вагоныг ашиглана;

17.5.2. Бункерт вагонд зөвхөн өтгөн /унжрамтгай/ нефть бүтээгдэхүүн ба нефтийн коксыг тээвэрлэнэ. Ийм вагонд хатуу маркийн нефть, битум тээвэрлэхийг зөвшөөрөхгүй;

17.5.3. Даац нь 120 ба 125 тонн, торхны багтаамж нь 140 ба 161 куб.м /калибрын хэв 61 ба 71/ "бензин", "тунгалаг нефть бүтээгдэхүүн" хэв бичээстэй найман голтой цистерн, түүнчлэн даац нь 68 тонн, торхны багтаамж нь 85.6 куб.м /калибрын хэв 53/ "бензин" хэв бичээстэй цистернийг зөвхөн бензин, керосин, дизелийн түлш болон бусад тунгалаг нефть бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд хэрэглэнэ;

17.5.4. Аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээгүй цистерн вагон, бусад хөдлөх бүрэлдэхүүнийг нийтийн хэрэглээний төмөр замын тээвэрт хүлээж авахгүй.

17.5.5. Цистерн, бункерт вагонд дараах тохиолдолд ачаа тээвэрлэхгүй байхыг хатуу анхаарна:

- Төлөвлөгөөт засвар буюу торх болон торхны суурь магадлагаа хийхэд 1 сараас бага хугацаа үлдсэн байвал;
- Үйлдвэрлэсэн үйлдвэрийн хэв бичээс болон вагоны дугаар нь тод бус байвал;
- Вагоны гадна шат /вагоны хийцэд дурдсан байвал/, дамжих тавцан, ажлын талбай, хамгаалах хайс байхгүй буюу гэмтэлтэй байвал;
- Цистерны торх, бункерт хагас вагонд гоожилт, сэргийлэх оньс, цутгах юүлэх торхны суурийн гэмтэл, цистерн, бункерт хагас вагоны уурын цамц цоорхой байвал;
- Цутгах болон юүлэх нээлхийний таг дээр цууралт байвал;

- Цистерны ачаалах нээлхийн тагны 2 болон түүнээс дээш боолт гэмтэлтэй эсвэл байхгүй, нээлхийн тагийг ломбодоход зориулсан сүвэгч байхгүй байвал;
- Цистерны ачааны нээлхийн тагны нягтруулах чигжээс байхгүй бол;
- Аюулын бичээс, тэмдэг, хэв бичээс, ялгах будалт байхгүй тохиолдод.

17.5.6. Цистернийг үйлдвэрлэсэн үйлдвэрийн хүснэгтийн зэрэгцээгээр торх нь онцлох аюулын тэмдэг, бичээс болон будалттай байна.

17.5.7. Эзэмшлийнхээ цистерны ёроол, жаазыг ногоон өнгөөр, торхыг тойруулж 300 мм өргөн цагаанаар будна.

Эзэмшлийн болон түрээсийн цистерны ёроолд:

“ _____ -нд даруй буцаана”,

/өртөө болон бүртгэлтэй суурь бүтцийн нэрийг заана/

Харин доор нь “ _____ түрээслэн авсан

/түрээслэгч эсхүл эзэмшигчийн нэрийг заана/

Буюу эзэмшлийн _____ оны” гэсэн хэв бичээс тавина.

17.5.8. Энэхүү журамд дурдсан шаардлагатай бичээс, хэв бичээс, түүнчлэн будалт, цистерны торхны онцолсон будалтыг эзэмшлийн болон түрээслэн авсан цистерныг эзэмшигч, түрээслэгч, тээвэрлэгчийн цистерныг тээвэрлэгч тус тус хийнэ;

17.5.9. Энэхүү журмын дагуу цистерн вагонд шингэн ачааг тээвэрлэхэд аюултай ачаа тээвэрлэх нийтлэг нөхцөлийг дагаж мөрдөнө.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ **ВАГОН, ЧИНГЭЛЭГ ЛОМБОДОХ**

18.1. Энэхүү бүлгээр төмөр замаар тээвэрлэхээр ачигдсан вагон болон чингэлгүүдийг битүүмжлэх ажиллагааг зохицуулна.

18.2. Ломбо нь ачааг битүүмжлэх баталгаа болно. Вагон, чингэлэгт зүүсэн ломбо нь вагон, чингэлгээс түүний битүүмжлэлийг эвдэлгүйгээр авч болохооргүй байна.

18.3. Ломбодох нөхцөл:

18.3.1. Вагоныг ломбодохын өмнө 2 талын хаалганы цүүг 250-260 мм-ээс багагүй урттай 6 мм-ийн голчтой зөөлрүүлсэн төмөр утсыг зориулалтын багажаар эрчилж, төмөр утсыг хаалганы цүүнд тавина. Эрчлээсийн тоо 9-өөс доошгүй байна. Чингэлгийг ломбодохын өмнө хаалганы бариулыг үүрэнд нь оруулан бүтэн оньсолж түгжээд 240-250 мм-ийн урттай 4мм-ийн голчтой зөөлрүүлсэн төмөр утсаар эрчилсний дараа ломбоны үзүүрийг хаалганы цүү цуурга хоёрын нүхээр нэвт сүвлэж ломбоны хоногонд шахаж оруулна. Түгжигдсэн эсэхийг утаснаас татаж шалгана. Ломбыг зүүхээс өмнө бүрэн бүтэн байдлыг шалгаж үзэх ба гэмтэлтэй ломбоор вагон, чингэлгийг ломбодохгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

18.3.2. Вагон, чингэлгийн ломбо бүртгэлийн цаасан болон цахим дэвтэрт энэ тухай тэмдэглэл хийнэ:

- ачааг тээвэрлэгчийн хүч хэрэгслээр ачсан бол тээвэрлэгчийн ломбоор;
- ачааг илгээгчийн хүч хэрэгслээр ачсан бол илгээгчийн ломбоор тус тус ломбодно.

18.3.3. Зайлшгүй тохиолдолд илгээгчийн хүсэлтийн дагуу ачилтын дараа вагон, чингэлгийг төмөр замын байгууллагын ломбоор ломбодож болох ба ачаа ачих захиалгын хүсэлтэд энэ тухай заавал дурьдсан байна. Ийм тохиолдолд төмөр замын байгууллагын ломбыг илгээгчийн ломбо гэж тооцно;

18.3.4. Ачаа нь суларсан вагон, чингэлгийг ачааны үлдэгдлээс бүрэн цэвэрлэж, хоосон вагон, чингэлэгт /битүү вагоны цүүг нэгдүгээр шүдэнд нь түгжиж/ эрээс тавина;

- тээвэрлэгчийн хүч хэрэгслээр буулгалтыг хийсэн бол тээвэрлэгч;
- ачаа хүлээн авагч буулгалтыг хийсэн бол ачаа хүлээн авагч тавина.

18.3.5. Вагон, чингэлэгт ломбыг:

- битүү вагоны хоёр талын хаалга тус бүрт;
- цистерний ачаа юүлэх таганд;
- тогтмол дулаант вагоны ломбодох төхөөрөмж бүрт;
- хопперийг дээд нээлхий болон буулгах төхөөрөмж бүрт;
- чингэлгийн хаалганы босоо 2 /хоёр/ штангийг хооронд холбож;
- чингэлгийг, дардаг хаалганы түгжээний бариул тус бүрт тавина.

1.Цистерн вагоны ачаа ачих бүх таганд

2.Тусгай зориулалтын чингэлэгийн ломбодох түгжих бүх хэсэгт

18.3.6. Ачаа алдагдаж болзошгүй гэж үзвэл битүү вагоны дээд, хажуугийн болон хаалганы нээлхийд, цистерний агааржуулагч, ачааг юүлэх тагны нугас, доод хүйсэнд нэмж ломбо тавьж болно.

18.3.7. Вагон, чингэлгийг дэс дараалсан дугаартай ломбоор ломбодно.

18.3.8. Илгээх өртөөнд вагон, чингэлгийг задлан шалгах шаардлага гарсан тохиолдолд ачаа илгээгчийг заавал оролцуулах бөгөөд шалгаж дууссаны дараа дахин ломбодоход энэхүү журмын 18.3.1-т заасныг баримтална.

18.3.9. Илгээх өртөөнөөс гэмтэлтэй ломботой болон буруу ломбодсон вагон, чингэлгийг явуулахгүй байх ба Төмөр замын тээврийн байгууллага тээвэрт хүлээн авахаас татгалзах эрхтэй.

18.3.10. Зам зуурын өртөө болон хүрэх өртөөнд ломбоны зөрчил гэмтэлтэй вагон, чингэлэг ирсэн тохиолдолд ломбыг сольж ломбодон ерөнхий маягтын акт тогтоох ба энэ тухай вагоны хуудсанд тэмдэглэл хийж, Төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий холбогдох байгууллагуудад цахилгаанаар мэдэгдэнэ.

18.3.11. Хүрэх өртөөнд вагон чингэлгийн тээврийн бичиг баримтан дахь ломбоны тэмдэглэл биет байдалтай зөрөх, түүнчлэн зам зуурын өртөөнд сольсон ломботой ачааг хүлээн авагчид олгохдоо Төмөр замын тээврийн байгууллага төлөөлөгчийг оролцуулна.

18.3.12. Илгээгчийн ломботой вагон, чингэлэгтэй ачаанд тээвэрлэлтийн явцад хууль хяналт, гааль, мал эмнэлэг, хорио цээрийн байгууллагаас шалгалт хийж ломбо сольсон бол зохих актыг тогтоож, тээврийн бичиг баримтны зохих хүснэгтэд тэмдэглэл хийнэ. Хүрэх өртөөнд уг ачааг хүлээн авагчид ломбоор нь хүлээлгэн өгнө.

18.3.13. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан машин техник, тоног төхөөрөмжийн битүүмжлэгдсэн хэсгүүд болон амархан авагдах эд ангиудийг хийж битүүмжилсэн хайрцаг, савыг илгээгчийн ломбоор ломбодно.

18.3.14. Хилийн өртөөдөд экспорт, импортоор болон транзитаар тээвэрлэгдэж байгаа вагон, чингэлгийн ломбыг олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрт заасны дагуу хүлээлцэнэ.

18.3.15 Явуулах болон зам зуурын өртөөдөд зориулалтын бус вагонд ачсан чингэлгийн ломбоны дугаар тоо, бүрэн бүтэн байдалд илгээгчийн тэмдэглэсэнээр, зориулалтын вагонд ачигдсан тохиолдолд ломбоны тоо, бүрэн бүтэн байдлыг өртөөний ачаа тээврийн ажилтан хяналт тавина.

18.4. Ломбыг дараах тохиолдолд зөрчил, гэмтэлтэй гэж үзнэ:

18.4.1. Ломбоны утас тасархай байх;

18.4.2. Ломбо хоногондоо дутуу орсон эсхүл огт ороогүй байх;

18.4.3. Ломбоны дугаар, хяналтын тэмдэг, код балархай, тод бус байх;

18.4.4. Ломбо хагарч цуурсан, бүрэн бүтэн байдал нь алдагдсан байх;

18.4.5. Өөр өөр ломботой байх;

18.4.6. Гадны нөлөөтэй байж болзошгүй зөрчил зэрэг болно.

18.5. Вагон, чингэлгээс ломбо эрчлээс төмрийг авах:

18.5.1. Вагон, чингэлгээс троссон ломбыг авахдаа ломбоны утасны үзүүр орсны эсрэг талын угаар зориулалтын хайчаар тасалж авна. Ломбыг гэмтээж болзошгүй зүйлээр цохиж тасалж авахгүй байхыг хатуу анхаарч ажиллана.

18.5.2. Вагон, чингэлгээс тугалган ломбыг авахад утсыг ломбоноос 3-4 см-ийн зайд тайрч авна;

18.5.3. Вагон, чингэлгээс эрчлээс төмрийг авахад зориулалтын хайчаар эрчлээсийн угаар тасалж авна.

18.6. Ломбон дээр дараах тэмдэглэгээ байна:

- тээвэрлэгчийн эсвэл илгээгчийн товчилсон нэр, код;
- хяналтын тэмдэг ба дугаар;
- ломбоны төрөл;
- үйлдвэрлэгч, тээвэрлэгч, илгээгчийн, ломбоны дугаар нь тус тусын хатуу хяналтад байна

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АЧАА ХАМГААЛАХ

19.1. Төмөр замаар заавал харуул хамгаалалтад авах шаардлагатай ачааны тээвэрлэлтийг энэхүү бүлгээр зохицуулна.

19.2. Байнгын болон төлбөртэй хамгаалалттайгаар тээвэрлэгдэх ачааны хамгаалалтын хөлсийг тогтоож мөрдөх асуудлыг энэхүү журам, төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журамтай уялдуулна.

19.3. "паркийн харуул" гэж өртөөний зам, паркад ачаа, вагоныг хянаж, хамгаалах үүрэгтэй тээвэрлэгчийн эрх бүхий хамгаалалтын байгууллагын ажилтныг хэлнэ.

19.4. "ачаа хамгаалагч" гэж хоорондын замд ачаа, вагоныг хянаж, хамгаалах үүрэгтэй тээвэрлэгчийн эрх бүхий хамгаалалтын байгууллагын ажилтныг хэлнэ.

19.5. "ерөнхий маягтын акт" гэж ачаа тээвэрлэлтэд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүй шалтгааныг тогтоосон тээвэрлэгчийн баримт бичгийг ойлгоно.

19.6. Төмөр замаар илгээх болон хилийн өртөөнөөс хүлээн авснаас эхлэн хүрэх болон хилийн өртөөнд хүлээлгэн өгөх хүртэл тээвэрлэгчийн баталсан шийдвэр, жагсаалтад байгаа ачааны бүрэн бүтэн байдлыг хамгаалалтын эрх бүхий байгууллага хариуцна.

19.7. Ачааны бүрэн бүтэн байдлыг паркийн харуултай өртөөнд паркийн харуулаас ачааг хүлээн авч салбар замд хүлээлгэн өгөх хүртэл, салбар замаас ачааг хүлээн авч паркийн харуулд хүлээлгэн өгөх хүртэл өртөө хариуцна. Паркийн харуулгүй өртөөнд ачаа ирснээс эсвэл ачааг хамгаалагчаас хүлээн авч салбар замд хүлээлгэн өгөх хүртэл, салбар замаас хүлээн авснаас ачаа хамгаалагчид хүлээлгэн өгөх хүртэл өртөө хариуцна. Хамгаалалттай ачааг хүлээлцэх дэвтэрт бичсэн замналын хуудас, актаар хариуцлагыг тодорхойлно.

19.8. Ачаа, вагон хүлээлцэгч санамжид гарын үсэг зуралцсан агшнаас тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хооронд ачааг хүлээлцсэнд тооцно. Ачаа хүлээлцэхэд ачааны бүрэн байдал алдагдсан /ломбо гэмтэлтэй, сав боодол задарсан, вагоны хана, шал нээлхий, хаалга гэмтэлтэй онгорхой гэх мэт/ байдал илэрвэл энэ тухай санамжид тэмдэглэл хийж хүлээлцэнэ.

19.9. Харуул хамгаалалттай ирсэн ачаа хүлээлцэхэд түүний бүрэн бүтэн байдал алдагдсан зөрчил илэрвэл энэ тухай ерөнхий маягтын актыг 3 хувь бичнэ. Ерөнхий маягтын актыг хувиудыг өртөө, эрх бүхий хамгаалалтын байгууллага тээврийн бичиг баримтад хавсаргана. Шаардлагатай тохиолдолд ерөнхий маягтын актыг гурав /3/-аас дээш хувь үйлдэж болно.

19.10. Хамгаалалттай ирсэн ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан шинж, тэмдэг бүхий гэмтлүүд /ломбо тасарсан, гэмтсэн, сав баглаа задарсан, вагоны хана, хаалга, шал, нээлхий, цүү цуурга гэмтсэн гэх мэт/ илэрвэл тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын болон цагдаагийн ажилтанг заавал байлцуулан акт тавина.

19.11. Хилийн өртөөгөөр дамжих тэсэрч дэлбэрэх "вв", хортой "яв" ачааг тээвэрлэгчийн хамгаалалтын байгууллагад хүлээлгэн өгөх ачааг хамгаалагч бүх л замын турш дагалдан хамгаалж, ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

19.12. Хамгаалалттай ачаатай зөрчилгүй чингэлгүүдийг вагонд ам дарж ачигдсан үед хамгаалалтад авах шаардлагагүй. Хамгаалалттай тээвэрлэх ачааны жагсаалтад ороогүй ачааг ачсан цистерн, их дунд даацны чингэлгүүдийг нэг удаагийн троссон ломбоор ломбодно. Хамгаалалтгүй ачаанд ачаа тээврийн ямар нэгэн зөрчил илэрсэн тохиолдолд тухайн галт тэргэнд явсан ачаа хамгаалагч, машинч нар холбогдох мэдээллийг тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Вагон болон чингэлгүүдийг тавьж 4-6 мм төмөр утсаар эрчлэн зөвхөн нэг удаагийн ломбоор ломбодож вагон хуудас болон тээврийн бичиг баримтад хяналтын дугаарыг тэмдэглэнэ. Ломбоны дугаар, хяналтын тэмдэг нь ижил байх шаардлагагүй.

19.13. Бензин, дизелийн түлшийг өртөөний зам дээр 1 цагаас дээш хугацаагаар зогссон тохиолдолд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан паркийн харуулын хамгаалалтад өгч, явахад нь паркийн харуулаас хүлээж авна.

19.14. Паркийн харуул нь паркад байгаа бүх ачаа, вагоныг хамгаалах үүрэгтэй.

19.15. Паркийн харуулын ажлыг тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулна.

19.16. Өртөө нь "яв", "вв" болон хамгаалалттай ачааг салбар замд эн тэргүүнд буюу технологит хугацаа дууссанаас хойш хоёр цагийн дотор тавьж өгнө.

19.17. Тээвэрлэгч нь хамгаалалттай ачаатай вагоныг нэг галт тэрэгний бүрэлдэхүүнд 5-аас доошгүй байхаар зохицуулна.

19.18. Ашиглагдсан буюу хуучин автомашин, трактор, бусад техникийг хамгаалалтад авахгүй байж болно.

19.19. Тоолох боломжгүй байрлуулсан ачааг өртөө буюу илгээгчээс хүлээн авахдаа ерөнхий маягтын актаар хамгаалалтад авна.

19.20. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагууд нь задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачигдсан хайрцагтай тоног төхөөрөмжийн хайрцаг савны бүрэн бүтэн байдал, тоо ширхэгийг зааж хамгаалалттай ачаа хүлээлцэх дэвтэрт бичиж хүлээлцэнэ.

19.21. Ачааг тээвэрт хүлээн авч салбар замаас татсанаас эхлэн түүнийг хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл тээвэрлэгч /төмөр зам/, салбар замаас татах хүртэл салбар зам эзэмшигч ачааны бүрэн бүтэн байдлыг хариуцна.

19.22. Тээвэрлэх ачааны бүрэн бүтэн байдлыг хангахад тээвэрлэгч дараах үүргийг хүлээнэ:

19.22.1. Нийтийн болон дагнасан хэрэглээний салбар замд ачигдсан ачаатай вагоныг тээвэрт хүлээн авсан буюу ачаатай вагоныг татаж авсан үеэс эхлэн ачааны бүрэн бүтэн байдлыг тээвэрлэгч хамгаалах үүрэгтэй;

19.22.2. Ачаатай вагоныг өртөөний замд татаж ирмэгц тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан "хамгаалалттай ачааг хүлээлцэх дэвтэр"-т гарын үсэг зуралцаж паркийн харуулд хүлээлгэн өгнө;

19.22.3. Паркийн харуулгүй өртөөнд ачаатай вагоныг өртөөний жижүүрийн байрны ойролцоо замд тавьж тээвэрлэгчийн эрх бүхий ажилтанд хүлээлгэн өгөх хүртэл өртөөний жижүүр болон аль нэг ажилтны хамгаалалтад байлгана;

19.22.4. Хамгаалалттай ачааг галт тэргэнд холбож илгээх үед галт тэрэгний биечилсэн хуудсанд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан "хамгаалалттай" гэсэн тэмдэглэл хийж ачаа хамгаалагчаар гарын үсэг зуруулж, галт тэрэгний диспетчерт мэдэгдэн хамгаалалттай вагоны дугаар, хамгаалагчийн нэрийг бичнэ;

19.22.5. Хамгаалалттай тээвэрлэгдэх ачаа бүхий галт тэргэнд харуул хамгаалалттай холбогдон гарсан зөрчлийг арилгаагүй, эсвэл ачаа хамгаалагчийг оройтуулан дуудаж, хүрэлцэн ирээгүй байхад галт тэргийг өртөөнөөс явуулахгүй байхыг хатуу анхаарч ажиллана;

19.22.6. Өртөөний жижүүр нь хамгаалалттай ачаа явуулах тухай галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчид мэдэгдэж, галт тэрэгний диспетчерээс шийдвэр авмагц 1 цаг 30 минутын өмнө хамгаалагч дуудах шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагын жижүүрт утсаар мэдэгдэж, шийдвэрийн дэвтэрт мэдээлэл хүлээн авсан, өгсөн хүний нэр, албан тушаал, огноог тэмдэглэнэ;

19.22.7. Ачаа хамгаалагч нь хамгаалах ачааг паркийн харуултай өртөөнд паркийн харуулаас, паркийн харуулгүй өртөөнд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтнаас хүлээн авна;

19.22.8. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны сав, баглаа, боодол нь бүрэн бүтэн байдалтайгаар байрын тоо ширхэг, ломбоны тоо, хяналтын дугаарыг зааж паркийн харуул болон ачаа хамгаалагчид хүлээлгэн өгнө;

19.22.9. Өртөөнд ачаа тээврийн болон техникийн зөрчилтэй шалтгаанаар удаан зогсож байгаа ачаатай вагонуудыг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй зам дээр тавьж зөрчлийг арилган паркийн харуулд хүлээлгэж өгнө. Зөрчлийг арилгах боломжгүй тохиолдолд ачаа, вагоны зөрчлийн байдлыг зааж ерөнхий маягтын актаар тодорхойлж паркийн харуулд хүлээлгэж өгнө;

19.22.10. Паркийн харуул байхгүй өртөөнд ямар нэгэн шалтгаанаар вагон удаан хугацаагаар зогсоход хүрвэл өртөөний дарга галт тэрэгний диспетчерт мэдэгдэж харуул буюу ачаа хамгаалагч дуудуулж хамгаалалтад өгнө;

19.22.11. Хамгаалалттай тээвэрлэгдэж буй ачааны бүрэн бүтэн байдал алдагдвал энэ тухай ачаа хамгаалагч нь өртөөний удирдлагад мэдэгдэх бөгөөд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтнууд хамтран ачаа, вагоны байдлыг тодорхой тусгасан тээврийн буюу ерөнхий маягтын акт тогтоож, энэ тухай тээврийн бичиг баримтад тэмдэглэл хийж, актын нэг хувийг хавсаргана;

19.22.12. Хүрэх өртөө паркийн харуултай байвал ачаа хамгаалагч ачааг шууд паркийн харуулд өртөөний ажилтны оролцоогүйгээр хүлээлгэн өгнө. Харин ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан болон ачаа тээврийн зөрчил илэрсэн тохиолдолд өртөөний ажилтны оролцоотойгоор хүлээлцэнэ;

19.22.13. Хүрэх өртөөнд паркийн харуулгүй бол хамгаалалттай ирсэн ачааг тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан ачаа хамгаалагчаас хүлээн авч түүний замналын хүснэгтэд ачаа хүлээн авсан тухай тэмдэглэл хийж гарын үсэг зурна. Хамгаалагчаас ачаа хүлээн авахад ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан, эвдэрсэн, гэмтсэн ул мөр илэрвэл өртөөний ажилтан, ачаа хамгаалагч нар энэ тухай ерөнхий маягтын акт тогтоож гарын үсэг зурах бөгөөд ачааг хүлээн авагчид олгоход эрх бүхий ажилтныг заавал оролцуулна;

19.22.14. Хамгаалалттай тээвэрлэгдэх ачааны нэрсийн жагсаалтад заасан ачааны тээврийн падааны дээд талд болон вагон хуудсанд "хамгаалалттай" гэсэн тэмдгийг тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан тавина;

19.22.15. Өртөө бүр өөрийн нэр кодтой, "хамгаалалттай" гэсэн нэг загварын дардастай байна. Өөр төрлийн "хамгаалалттай" гэсэн тэмдэглэлийг хүчингүйд тооцно.

19.23. Тээвэрлэгдэх ачааны бүрэн бүтэн байдлыг хангахад галт тэрэгний диспетчер дараах үүргийг гүйцэтгэнэ:

19.23.1. Галт тэрэгний диспетчер нь өртөөнөөс хамгаалалттай ачаа явуулахаас 1 цаг 30 минутын өмнө тухайн өртөөний жижүүрт галт тэрэг явах цаг, минутыг тодорхой зааж хамгаалагч дуудаж явуулах шийдвэр өгнө;

19.23.2. Галт тэрэгний диспетчер нь хамгаалалттай ачааны тухай галт тэрэгний хөдөлгөөний зурмагт вагоны дугаар, хамгаалагчийн нэр, "хамгаалалт" гэсэн тэмдэглэл хийж аялалын явцад хяналт тавина.

19.24. Тээвэрлэгдэх ачааны бүрэн бүтэн байдлыг хангахад хамгаалалтын эрх бүхий байгууллага дараах үүргийг хүлээнэ:

19.24.1. Эрх бүхий байгууллага нь ачаа хамгаалагч болон паркийн харуулын ажил үүргийн хуваарийг зохион байгуулж зэвсэгт харуулаар хангана;

19.24.2. Ачаа хамгаалагч болон паркийн харуулууд нь хоорондын замд болон өртөө зөрлөгүүд дээр хамгаалж буй ачаанд зөрчил гарвал эрх бүхий ажилтанд мэдэгдэж, үзлэг шалгалт хийлгэн ерөнхий маягтын акт тогтоолгон, боломжтой бол уг зөрчлийг арилгуулна;

19.24.3. Ачаатай, чингэлэг вагоныг хүлээн авахад вагоны тэвш, дээвэр, шал, духны хана цоорхой эсэх, дотор талаас нь нөхсөн эсэх, хажуугийн болон дээд нээлхий бүрэн бүтэн, хаалга, цуурга зөв түгжигдсэн эсэх, эрээс утас, ломбоны утас шаардлага хангасан эсэх, хяналтын тэмдгүүд тодорхой зэргийг нарийвчлан шалгана;

19.24.4. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан машин тоног төхөөрөмж, бусад техникүүдийн ломбоны жагсаалтуудыг үндэслэн хүлээж авна. Машин бусад техникийн амархан авагдах эд ангийн байдал, түүний дагалдах хэрэгсэл, тоо, хаана байрласныг тодорхой шалгаж авна;

19.24.5. Вагоныг хамгаалалтад хүлээн авахдаа ямар нэг зүйлээр ханыг цохиж болохгүй. Машин болон ломбонд үзлэг хийхдээ машины бүхээг, тэвш, бусад эд ангийг зурагдахаас болгоомжилбол зохино;

19.24.6. Эрх бүхий байгууллагын хамгаалах ачаа нь гэмтэлгүй бүтэн ломботой байх шаардлагатай;

19.24.7. Эрх бүхий байгууллагын ажилтан өртөөний "хамгаалалтад ачаа хүлээлцэх дэвтэр"-т гарын үсэг зурсан агшнаас ачааг хамгаалалтад хүлээн авсанд тооцно;

19.24.8. Энэхүү журмын хамгаалалттай тээвэрлэгдэх ачааны жагсаалтад заагдаагүй боловч тээвэрлэгчийн шийдвэр болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хүсэлтээр төлбөртэйгээр ямар ч төрлийн ачааг хамгаалж болно.

19.25. Хоорондын замд хамгаалалттай тээвэрлэх ачааны жагсаалт:

• бүх төрлийн ашиглагдаагүй шинэ автомашин, трактор, машин механизм тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, бүх төрлийн чиргүүл;

- тэсэрч дэлбэрэх "вв", хортой "яв", шингэрүүлсэн хий;
- ноос, ноолуур, савхи, торго түүгээр хийсэн өргөн хэрэглээний бараа;
- ноос, ноолуур, ангийн үс, савхи, торго түүгээр хийсэн өргөн хэрэглээний бараа;

- бүх төрлийн архи, дарс, спирт;
- галт зэвсэг, төрөл бүрийн ангийн буу, түүний сум хэрэгсэл;
- гадаад улсын төлөөлөгч болон дипломат байгууллагын ачаа;
- машины болон цахилгаан хөдөлгүүр, цахилгаан хэрэгсэл;
- хүнсний ачаа /гурил, үр тарианаас бусад/;
- тусгай тоноглол бүхий вагон, чингэлэг;
- молибдены болон зэсийн баяжмал.

19.26. Паркийн зам дээр хамгаалах ачааны жагсаалт:

- бүх төрлийн ашиглагдаагүй шинэ автомашин, трактор, машин механизм тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, бүх төрлийн чиргүүл;
- тэсэрч дэлбэрэх "вв", хортой "яв", шингэрүүлсэн хий;
- ноос, ноолуур, савхи, торго, түүгээр хийсэн өргөн хэрэглээний бараа;
- ноос, ноолуур, ангийн үс, савхи, торго түүгээр хийсэн өргөн хэрэглээний бараа;
- бүх төрлийн архи, дарс, спирт;
- галт зэвсэг, төрөл бүрийн ангийн буу, түүний сум хэрэгсэл;
- гадаад улсын төлөөлөгч болон дипломат байгууллагын ачаа;
- машины болон цахилгаан хөдөлгүүр, цахилгаан хэрэгсэл;
- хүнсний ачаа /гурил, үр тарианаас бусад/ ;
- тусгай тоноглол бүхий вагон, чингэлэг;
- бензин, дизелийн түлш;
- молибдены болон зэсийн баяжмал.

ХОРЬДУГААР БҮЛЭГ **ИЛГЭЭЛТИЙН ХАЯГ СОЛИХ**

20.1. Илгээлтийн хаяг солиулах тухай хүсэлтэд дараах өгөгдлүүдийг тодорхой тусгасан байна:

- ачааны нэр, жин /нэрийн код/;
- вагон болон илгээлтийн /падааны/ дугаар;
- илгээх өртөөний нэр /код/;
- анхны хүрэх өртөө, хүлээн авагчийн нэр /код/;
- ачаа илгээгчийн нэр, хаяг /код/;
- хүрэх зам, өртөөний нэр /код/;
- шинээр хүрэх зам, өртөөний нэр /код/;
- шинэ хүлээн авагчийн нэр хаяг /код/;
- тээвэрлэгчийн нэр /код/;
- хэтрүү овортой ачаа бол оврын зэрэг.

“Хаяг солилт” гэж илгээгч, хүлээн авагчийн бичгэн хүсэлтээр зохих зөвшөөрлийн дагуу хүрэх өртөө, хүлээн авагчийн хаягийг солихыг хэлнэ.

20.2. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч нь хаяг солих болсон шалтгааныгзаана.

20.3. Хаяг солих өртөөн дээр ямар байгууллага болон албан тушаалтан хаяг солих ачааны бичиг баримтыг бүрдүүлэх, тээврийн тооцоог хэрхэн хийх тухай заалтыг бичнэ.

20.4. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийн илгээлтийн хаяг солих хүсэлтэд улсын бүртгэлийн гэрчилгээ, албан бичгийн маягт /бланк/ дээр бичигдсэн байхаас гадна байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан байна.

20.5. Илгээлтийн хаяг солилт хийхдээ төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн иргэн, хуулийн этгээдийн бичиг баримт, регистрын дугаар, шуудангийн хаяг, харилцах утасны дугаар, орлох падаан зэргийг бүрдүүлнэ.

20.6. Хаяг солих:

20.6.1. Тээвэрлэгч нь илгээлтийн хаяг солих үйл ажиллагааг хаяг солих эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, хүсэлтийн үндсэн дээр зохион байгуулна;

20.6.2. Хаяг солих, тээврийн бичиг баримт дахин үйлдэх ажиллагааг хүрэх өртөө, зам зуур болон орох хилийн өртөөдийн тооцооны газарт гүйцэтгэнэ;

20.6.3. Илгээлтийн хаяг солилтыг шинэ буюу хуучин бичиг баримтаар солино. Хуучин бичиг баримтаар хаяг солиход зөвхөн чиглэлийн дагуу солино;

20.6.4. Аюултай болон хэтрүү овортой ачааны хаяг солилтыг зөвхөн төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий ажилтан судлаж шийдвэрлэнэ. (ЗТХЯ ба ТЕГ-ийн журмаар)

20.6.5. Илгээлтийн хаяг солихыг дараах тохиолдолд зөвшөөрөхгүй:

- давтан буюу буцах чиглэлд /гэр ахуйн хэрэглэлээс бусад/;
- хөргүүрт галт тэргэнд тээвэрлэгдэж буй ачааны агааржуулалтын болон температурын дэглэм алдагдсан, ачаа гэмтсэн, муудсан, ломбоны зөрчилтэйн улмаас зам зуурын өртөөнд акт тавигдсан.

20.6.6. Илгээлтийн хаяг солих хүсэлтийг биечлэн, эсвэл цахим хэлбэрээр тээвэрлэгчид ирүүлж болно. Хүсэлт гаргахад энэ журмын 20.1-д заасан өгөгдлийг заавал хамт өгнө;

20.6.7. Хувийн эзэмшлийн болон түрээсийн хоосон вагон, хөргүүрт чингэлэгт ачаа тээвэрлэх, хаяг солилтыг төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

20.6.8. Нэг падаан /илгээлт/-тай бөгөөд вагонд бүлгээр ачигдсан болон замналаар тээвэрлэх ачааг нийтэд нь хаяг солиход ердийн журмаар гүйцэтгэнэ. Нэг падаантай бөгөөд тээш, ахуйн хэрэглээний бараанаас бусад ачаа ачсан чингэлэг, вагон болон замналаар тээвэрлэж байгаа ачаанаас ганц нэгээр нь салгаж хаяг солихгүй байхыг хатуу анхаарч ажиллана. Энэ тохиолдолд ачаа хүрэх өртөөнд очсоны дараа хаяг солихыг зөвшөөрнө; Уг заалтад нэг падаанаар тээвэрлэж байгаа тээвэрлэгчид үл харъяалагдах ачаатай болон хоосноор тээвэрлэгдэх хөдлөх бүрэлдэхүүнүүд хамаарна.

20.6.9. Шинээр хаяг сольсон хүрэх өртөөнд очиход сертификат буюу чанарын гэрчилгээнд заасан хугацаа нь хэтрээгүй тохиолдолд түргэн муудах, хялбар гэмтэх ачааны хаяг солихыг төмөр замын тээврийн байгууллага зөвшөөрч болно;.

20.6.10. Илгээлтийн хаяг солиход ачаа хүргэх хугацааг тооцохдоо төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журам, олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийн зохих заалтыг харгалзан үзнэ.

20.6.11. Хүрэх өртөөнд ирсэн вагонтой ачааг өөр хүлээн авагчид хаяг солих бол ачаа хүлээн авахыг зөвшөөрсөн бичгэн хүсэлтийг анхны ачаа хүлээн авагч нь Төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий албан тушаалтанд өгснөөр гүйцэтгэнэ.

20.6.12. Илгээлтийн хаяг солих тохиолдолд Төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий албан тушаалтны албан тоотын дугаар, гарын үсэг бүхий бичгэн зөвшөөрлийг хаяг солих өртөөнд хаяглан шуурхай шийдвэрийг өгнө. Орох хилийн өртөөнд болон зам зуурт илгээлтийн хаяг сольсон бол тээврийн бичиг баримтын зохих хүснэгтэд тэмдэглэл хийж явуулна.

20.7. Тээврийн бичиг баримт бүрдүүлэх, төлбөр тооцоо хийх:

20.7.1. Ачааны хүрэх өртөө, хүлээн авагчийн хаяг өөрчилснөөс үүсэх төлбөр /үйлчилгээний хөлс, хураамж/ тооцоог батлагдсан тарифын дагуу хийнэ;

20.7.2. Ачааны хүрэх өртөө, хүлээн авагчийн хаяг өөрчлөн олгох үед ачаа хүлээн авагч бүх тооцоог хийж тээврийн бичиг баримтыг зарлагадсаны дараа шинэ хүлээн авагчид ачаатай вагоныг тавьж өгнө. Вагоны тавилт, таталтын тооцоог шинэ хүлээн авагчийн нэр дээр нээж вагоны тавилт, таталт болон ачааны ажиллагаанд зогсоосон вагоны төлбөр /үйлчилгээний хөлс, хураамж/-ийг хурааж авна. Өртөөн доторх салбар замын сонголтын хөлсийг мөрдөгдөж буй тарифыг үндэслэн тооцно. Төлбөрийг авах үндэс нь өртөөний эрх бүхий албан тушаалтны цохолттой бичгэн хүсэлт болно. Хүсэлтийг өртөөний бичиг хэрэгт хадгална;

20.7.3. Падаанд заасан хүлээн авагч нь ачаа хүрэх өртөөнд байхгүй бол илгээгчийн заалтаар ачааны хаягийг хуучин бичиг баримтаар солих бөгөөд тээврийн хөлс, хураамжийг шинээр хүрэх өртөөнд хүлээн авагчаас хурааж авна;

20.7.4. Орох хилийн өртөө буюу зам зуурт яваа ачааны хаяг солиход хаяг солилтын хураамж болон бусад ажил үйлчилгээний хөлсийг ачаа хүлээн авагчаас авна;

20.7.5. Вагоныг буулгалтад тавьсны дараа хаяг солих шийдвэрийг авбал буулгалтад вагон тавьсан агшнаас хаяг солих шийдвэр авч бичиг баримт бүрдүүлэх хүртэл вагон ашиглалтын хөлс болон бусад хураамжийн хөлсийг тарифын дагуу тооцож хураана. Ачаа хүрэх өртөөнд ирсэн вагоныг хаяг солиулах тухай хүлээн авагч хүсэлт гарган өгсөн агшнаас хаяг солих шийдвэр хүлээн авч, илгээгч шинээр бичиг баримт бүрдүүлэх хүртэл хугацааны вагон ашиглалтын хөлсийг авна;

20.7.6. Шинэ бичиг баримтаар хаяг солилт хийхэд хүсэлт гаргасан этгээд хуучин бичиг баримтаар төлбөр тооцоог хийж дуусгасны дараа шинэ бичиг баримт үйлдэх ба тооцоог хийнэ.

20.8. Импортын ачааны хаяг солих нэмэлт нөхцөл:

20.8.1. Импортын ачааны хаяг солиход олон улсын ачааны харилцааны хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ. Улсын хилээр орж ирэх импортын ачааны хаягийг солихдоо энэ журмын 20.8.3-д зааснаар ачааны хаяг солих шийдвэрийг өртөөнд урьдчилан өгөх ба хаяг солилтыг гаальд мэдүүлэхээс өмнө гүйцэтгэнэ;

20.8.2. Ачааг гаальд мэдүүлж ачааны манифест бичигдэж гаалийн хяналт хийгдсэний дараа хаяг солилт хийгдэх бол хүлээн авагчийн хүсэлтээр манифестэнд хийсэн гаалийн байгууллагын тэмдэглэл зөвшөөрлийг үндэслэн гүйцэтгэнэ. Энэ тухай төмөр замын байгууллага тээврийн бичиг баримтад тэмдэглэл хийнэ;

20.8.3. Импортын ачааны хаягийг орох хилийн өртөөнд солиход гаалийн хяналтын тэмдгээр хуучин бичиг баримтаар, хүрэх өртөөнд ачааг олгох гаалийн байгууллагын зөвшөөрсөн тухай зохих тэмдэг тээврийн бичиг баримтад дарагдсаны дараа шинэ бичиг баримтаар тус тус солино;

20.8.4. Тээвэрлэх ачаа нь хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчин, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулах болон төмөр замын тээврийн тасралтгүй үйл ажиллагааг саатуулахаар бол аливаа учирч болзошгүй аюул, хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн хяналтын болон гаалийн байгууллагууд, ачаа илгээгч, хүлээн авагчтай урьдчилан тохирохгүйгээр тээвэрлэгчийн шийдвэрээр хаяг сольж буулгуулна. Ачааны хаягийг сольж буулгуулах болсон талаар тээвэрлэгч нь мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гаалийн байгууллага, хүлээн авагч, илгээгчид болон илгээсэн өртөөнд яаралтай мэдэгдэнэ;

20.8.5. Шаардлагатай тохиолдолд экспортын ачааны хаяг солиход тухайн ачаа явж буй төмөр замын хилийн болон холбогдох өртөө, эрх бүхий газарт нь цахилгаан явуулж асуудлыг шийдвэрлүүлнэ;

20.8.6. Шинэ бичиг баримтаар хаяг солиход вагоны ломбо хөндөгдөөгүй тохиолдолд илгээгчийн ломбыг авах шаардлагагүй. Энэ тохиолдолд тээврийн падааны “ачааны нэр” гэсэн хүснэгтэд ачааны хаяг солиулж буй этгээдээр илгээгчийн ломбо өөрчлөөгүй гэсэн тэмдэглэл хийлгүүлнэ. Гэхдээ хаяг солиулах этгээд болон гааль, хяналтын байгууллага ачааг шалгах шаардлагаар вагоныг онгойлгосон тохиолдолд өртөө болон салбар зам эзэмшигч нь шинэ ломбо тавина.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **САЛБАР ЗАМ**

21.1. Салбар зам, агуулах, талбайд ачааг тээвэрлэлтэд хүлээн авах, буулгах, олгох задгай болон битүү агуулахад хадгалах ажиллагааг тээвэрлэгч буюу суурь бүтэц эзэмшигч үйлчлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна. Гэрээний үлгэрчилсэн загварыг Төмөр замын тээврийн байгууллага буюу суурь бүтэц эзэмшигч тогтооно.

21.2. Салбар зам, талбайн задгай агуулахад хадгалагдах ачааны жагсаалтыг тээвэрлэгч Төмөр замын тээврийн байгууллага буюу суурь бүтэц эзэмшигч тогтооно.

21.3. Салбар зам, агуулах, талбайд аюултай ачаа ачих, буулгах, хадгалах ажиллагааг төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмаар зохицуулна. (Хуулийн нэр томъёо өөрчлөгдсөн)

21.4. Салбар замд ачилт буулгалтын ажиллагааг Төмөр замын тээврийн байгууллага, суурь бүтэц эзэмшигчийн болон ачилт буулгалтын машин механизмтай иргэн, хуулийн этгээдийн хүчээр ачаа илгээгч, хүлээн авагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэнэ.

21.5. Төмөр замын тээврийн байгууллага, ачаа болон чингэлгийг нийтийн хэрэглээний замд тавьж буулгаснаас 24 цагаас дээш хугацаанд тарифт заасны дагуу ачаа хүлээн авагчаас хадгаламжийн хураамж авна.

21.6. Салбар замд тусгай зориулалтын хөргүүрт вагон болон чингэлгээр ирсэн түргэн гэмтэх, муудах ачааг ачаа хүлээн авагчид шууд олгоно. (Хуулийн нэр томъёо өөрчлөгдсөн)

21.7. Салбар зам Салбар зам, агуулах, талбайд ачаа хадгалуулагч нь гэрээнд заасан хугацаанд ачаагаа татаж авахгүй хүндрэл учруулбал гэрээнд заасан хэмжээгээр торгуулийн хариуцлага хүлээлгэж, төмөр замын тээврийн байгууллага тогтоосон тарифын дагуу хураамжийг нөхөн төлүүлнэ.

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ **САЛБАР ЗАМ**

22.1. Салбар зам бүхий байгууллага аж ахуй нэгж, иргэд болон Төмөр замын тээврийн байгууллага ийн хоорондын харилцаа /салбар зам ашиглах, вагон тавих, татах, ачаа вагон хүлээлцэх, сэлгээ хийх гэх мэт/ гэрээгээр зохицуулагдана.

22.2. Салбар зам ашиглах гэрээ ба вагон тавих татах гэрээний үлгэрчилсэн загварыг төмөр замын тээврийн байгууллага тогтооно.

22.3. Салбар зам ашиглах гэрээ болон вагон тавих татах гэрээг 1 жилээс илүүгүй хугацаагаар байгуулна. (Хуулийн нэр томъёо өөрчлөгдсөн)

22.4. Салбар зам ашиглах, вагон тавих, татах гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас нэг сараас доошгүй хугацааны өмнө эзэмшигч буюу дайвар үйлчлүүлэгчтэй хамтран төмөр замын тээврийн байгууллага шинэ гэрээний төсөл боловсруулж эхэлнэ.

22.5. Дагнасан хэрэглээний Салбар зам дээр байрласан төхөөрөмж, байгууламж, цогцолборууд нь тээвэрлэлтийн хэмжээнд тохирох сэлгээний болон ялгах, ачаа ачих, буулгах ажиллагааг жигд явуулах, түүнчлэн хөдлөх бүрэлдэхүүн болон ачааны бүрэн бүтэн байдлыг хангахуйц байна. Эдгээр төхөөрөмж, байгууламж, цогцолборууд нь барилга ойртолтын оврын шаардлагад нийцсэн байна.

22.6. Салбар зам эзэмшигчийн ачих, буулгах талбай нь шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй байна.

22.7. Салбар замд вагон тавьж өгөх, татаж авах ажиллагаа:

22.7.1. Салбар замд вагон тавих, татах ажиллагааг төмөр замын тээврийн байгууллага, зам эзэмшигчийн эсхүл түрээсийн зүтгүүрээр гүйцэтгэнэ;

22.7.2. Төмөр замын тээврийн байгууллага зүтгүүрээр үйлчилж байгаа үед вагон тавих, татах ажиллагааг гэрээнд заасны дагуу гүйцэтгэнэ; өөрчлөгдсөн)

22.7.3. Салбар замд вагон тавих, татах ажиллагааг-төмөр замын тээврийн байгууллага зам эзэмшигчтэй тохиролцсон хүлээлцэх замд гүйцэтгэх ба уг зам нь нийтийн болон дагнасан хэрэглээний байж болно;

22.7.4. Салбар замд вагон тавьж өгсөн, татаж авсаны хөлсийг тухайн өртөөний тэнхлэгээс эхлэн үйлчилсэн зайгаар бодож ачаа тээвэрлэх тарифын дагуу авна.

22.8. Салбар замын ажлын технологийг өөрчлөхөд гэрээнд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулна. Салбар зам эзэмшигч өөрчлөгдөхөд гэрээг шинэчлэн хийнэ.

22.9. Салбар замд ажиллах төмөр замын ажилтан төмөр замын тээврийн хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журмын мэдлэгийг эзэмшиж, шалгалтад хамрагдсан байна.

22.10. Салбар зам болгон техникийн паспорт, хавтгай, дагуу огтлол, цогцолборын зурагтай байна. Техникийн паспортонд гэрчилгээнд замын дээд бүтэц, төхөөрөмж, пүү, вагон ачаалах, буулгах, цэвэрлэх, угаахад зориулсан болон түүнчлэн үйлдвэрийн төмөр замын өртөө, дов, довцог, татах зам, галт тэрэг, сэлгээний ажилд хэрэглэж буй дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын байгууламж бусад туслах байгууламж, механизмын техникийн шинж төрхийг заасан байна.

22.11. Шинэ объект, тоног төхөөрөмж ашиглалтад оруулах, татан буулгахад Салбар зам эзэмшигч тухайн замын техникийн паспортонд зохих өөрчлөлтийг оруулна. Техникийн паспортын нэг хувийг Төмөр замын тээврийн байгууллага болон суурь бүтэц эзэмшигчид өгнө. Тухайн өртөөний техник захирамжийн актын хавсралт, Салбар замын хүснэгтэд суурь бүтэц эзэмшигч өөрчлөлт оруулна.

22.12. Төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагч салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдал, төмөр замын тээврийн ашиглалтын

үйл ажиллагаа, вагон, чингэлэгт ачаа ачих, буулгах ажлыг гүйцэтгэлд хяналт шалгах хийх эрхтэй. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулахаар тавьсан шаардлагыг суурь бүтэц эзэмшигчийн зохих албан тушаалтан заавал биелүүлнэ.

22.13. Салбар зам дээр хөдөлгөөний аюулгүй байдал, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн техникийн болон ачааны бүрэн бүтэн байдалд нөлөөлөхүйц гэмтэл, зөрчлийг илрүүлбэл улсын байцаагч акт тавина.

22.14. Улсын байцаагчийн тавьсан актын үндсэн дээр суурь бүтэц эзэмшигчийн зохих албан тушаалтан гэмтлийг арилгаж дуустал тухайн салбар зам дээр эсвэл уг актанд заасан хэсэгт хөдлөх бүрэлдэхүүн тавьж өгөхгүй.

22.15. Өртөө, зөрлөгийн замд өөр салбар замаар дамжин холбогдож буй салбар болон зам бүхий иргэн, хуулийн этгээдийн замд вагон тавьж өгөх, татаж авахад үндсэн буюу эхний хэрэглэгч нь дайвар буюу дараагийн хэрэглэгчдийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр ажлыг гүйцэтгүүлнэ.

22.16. Эзэмшигчийн буюу бусдын эзэмшлийн салбар замд өөрийн эзэмшлийн агуулах талбайтай иргэн, хуулийн этгээдийн вагон, чингэлгийг тавьж, татах ажиллагааг үндсэн эзэмшигч хоорондын хэлцлийг үндэслэн зохицуулна.

22.17. Вагон, чингэлгийн эргэлтийн технологийн хугацаа, вагонд ачаа ачих, буулгах үлгэрчилсэн технологийн нормыг боловсруулах, тодорхойлох зааврыг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

22.18. Салбар зам эзэмшигч нь нэг өртөөнд хэд хэдэн салбар замтай байвал зам тус бүрт болон нэгдсэн гэрээ байгуулж болно.

22.19. Гэрээг дахин байгуулахад маргаантай асуудал гарсан тохиолдолд түүнийг шийдтэл урьд нь байгуулсан гэрээний хүчинтэй хугацааг сунгах тухай талуудын хэлэлцээр байвал урьд байгуулсан гэрээгээр бүх асуудлыг зохицуулна.

22.20. Төмөр замын тээврийн байгууллага нь салбар зам ашиглах гэрээ, вагон тавих, татах гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг болон гэрээ байгуулах эрхийг нийтлэг гэрээний үндсэн дээр суурь бүтэц эзэмшигчид шилжүүлж болно. Энэ тохиолдолд суурь бүтэц эзэмшигч нь Салбар зам ашиглах гэрээ, вагон тавих, татах гэрээний үүргийн дагуу төмөр замын тээврийн байгууллага -ийг төлөөлөн ачаа илгээгч, хүлээн авагч, салбар зам эзэмшигчтэй харилцана.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ САНАМЖ ХӨТЛӨХ

23.1. Үйлчлүүлэгч иргэд, байгууллага, хуулийн этгээдийн ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зориулж вагоныг салбар замд ачилт, буулгалтад тавьж өгөх, татаж авах үед монгол улсын үндэсний стандартыг хэрэгжүүлэн ажиллах, санамжийг үнэн зөв цаасан ба цахим хэлбэрээр төмөр замын тээврийн байгууллагын хүрээнд хөтөлнө.

23.2. Санамж нь вагон чингэлгийн ачилт, буулгалт /хүлээлгэх/-д байсан болон сэлгээний ажиллагаанд зарцуулсан хугацааг зөв тодорхойлох төлбөр тооцооны анхан шатны баримт болно. /дөрөвдүгээр хавсралт/.

23.3. Салбар замд вагоныг ачилт, буулгалтад тавьж өгөх, санамж нээх:

23.3.1. Санамжийг төмөр замын тээврийн байгууллага байгууллагын эрх бүхий ажилтан үйлдэнэ. Санамжийг 3 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг вагон таталт тавилтын хүснэгтэд хавсаргаж, хоёр дахь хувийг ачаа хүлээн авагч, илгээгчид өгч, үлдэх хувь өртөөний тооцооны газарт үлдэнэ;

23.3.2. Санамжид вагон, чингэлгийн дугаар, вагоныг тавьж өгсөн, татаж авсан зүтгүүрийн эзэмшигч, салбар замын нэр, ачаа илгээгч, хүлээн авагчийн нэр, вагоныг ачилт, буулгалтад тавьж өгсөн, ачиж буулгаж дууссан болон сэлгээ хийсэн хугацааг заана;

23.3.3. Салбар замтай /дайвар үйлчлүүлэгчийг нотолсон/ ачаа хүлээн авагчийн хаягаар ирсэн вагоныг ачилт, буулгалтад тавьсан цагаар, ачаатай болон хоосон тухайн төмөр замын тээврийн байгууллагын эзэмшлийн бус вагоныг өртөөнд ирсэн цагаас технологит цагийг хасаж санамж нээж тээвэрлэгч болон төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн эрх бүхий ажилтан нар харилцан гарын үсэг зурж баталгаажуулна;

23.3.4. Салбар замд вагон, чингэлгийг тавих үед техникийн болон ломбо, задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны байдал, зөрчил гэмтэлтэй эсэхийг тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч талууд хамтран шалгаж, гэмтэлтэй бол зөрчлийн талаар заасан тэмдэглэлийг санамжид эрх бүхий ажилтнууд хийнэ. Зөрчилгүй бол тэмдэглэл хийхгүй;

23.3.5. Салбар замд бүлгээр ачилт буулгалтад тавигдсан вагоны ачаа хүлээн авагч, илгээгч нь өөр байвал тус бүр дээр санамж нээнэ;

23.3.6 Төмөр замын тээврийн байгууллагын өөрийн эзэмшлийн салбар замд ачилт буулгалтад тавьж өгөх вагоныг тавьсан жинхэнэ цагаар санамжийг нээнэ.

23.4. Вагон ашиглалтын хөлс тооцох, санамж хаах:

23.4.1. Салбар замд тавьсан вагон, чингэлгийг ачиж, буулгаж дууссан цагийг санамжид тэмдэглэж хоёр талын эрх бүхий ажилтнууд гарын үсэг зурж баталгаажуулна;

23.4.2. Салбар замд тавьж өгсөн вагон, чингэлгийг ачиж, буулгаж тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан шалгах үед ачааг бүрэн буулгаж вагон, чингэлгийг цэвэрлээгүй, бэхэлгээний материалыг бүрэн аваагүй, хаалга нээлхийг хааж түгжээгүй, хуучин ломбо, эрчлээс төмөр утас, ачааны наадсыг аваагүй байх, ломбоны гэмтэлтэй, задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр ачсан ачааны бэхэлгээ шаардлага хангахгүй, ачааны сав, баглаа, боодол нь тээвэрлэлтийн бүрэн бүтэн байдлыг хангаж чадахааргүй байвал ачааг тээвэрт хүлээн авалгүй санамжийг хаалгүйгээр үлдээнэ;

23.4.3. Салбар замд ачилт, буулгалтад тавьсан вагон, чингэлгийг ачаа илгээгч, хүлээн авагч эвдэж гэмтээсэн, эд анги нь алга болсон байвал тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан нь энэ тухай техникийн гэмтлийн акт тогтоож ачаа хүлээн авагч, илгээгчийн ажилтнаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Хүлээн авагч, илгээгчийн ажилтан гарын үсэг зурахаас татгалзвал санамж хаахгүйгээр үлдээн, энэ тухай холбогдох хүмүүст мэдэгдэж арга хэмжээ авна;

23.4.4. Тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан нь ачсан, буусан вагоны санамжийг хаахдаа "ачиж, буулгаж дууссан" гэсэн хүснэгтэд буулгаж дууссан цагийг бичиж гарын үсэг зурж баталгаажуулан, тооцооны газарт өгнө. Ачаа илгээгч, хүлээн авагч нь санамж хаагдсан даруйд тооцооны газарт холбогдох төлбөр, тооцоог хийнэ;

23.4.5. Ачаа илгээгч, хүлээн авагч түрүүчийн ачсан, буулгасан вагоныг хэсэгчлэн татаж авах тухай "салбар замд вагон тавих, татах гэрээ"-нд заасан бол санамжийг хэсэгчлэн хааж,

хэсэгчлэн авсан вагон тус бүр дээр тавилт, таталтын хөлсийг тооцон авна. Энэ тухай салбар замд вагон тавих, татах гэрээнд тусгана.

23.5. Хүлээлгийн санамж хөтлөх:

23.5.1. Вагон, чингэлгийг хүлээн авагчийн замд доорх шалтгаанаар тавьж өгөөгүй тохиолдолд өртөөн дээр хүлээлгийн санамжийг галт тэрэг ирсэн цагаас технологит ажиллагааны цаг дууссаны дараа нээнэ:

А. Ачаа хүлээн авагч нь өөрийн мэдлийн салбар замгүйгээс вагоныг буулгалтад тавьж өгөх боломжгүй;

Б. Салбар зам нь эвдрэлтэй, техникийн гэмтэлтэй, арчилгаа, үйлчилгээ хийгээгүйгээс, техникийн шаардлага хангахгүй байгаагаас сэлгээний хөдөлгөөнд хаасан;

В. Ачаа илгээгч, хүлээн авагчийн салбар замтай агуулахад ачилт буулгалтын фронтын хэмжээгээр вагоныг тавиад цаана нь хүлээгдэж байгаа үлдэгдэл вагонд;

Г. Гааль, худалдаа, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн байгууллагаас улсын хилээр оруулахыг хориглосон ачаа хилээр орж ирэх, импортоор ирсэн ачааны гааль, худалдааны татвар, тээвэрлэлтийн хөлс төлөгдөөгүй болон бусад шалтгаанаар хилийн болон бусад өртөөдөд саатуулагдан зогсож байгаа вагонуудад;

Д. Ачаа ирэх үед хүлээн авагч нь олдохгүй хаяг тодорхойгүй эсвэл ачаа нь хүлээн авагчийн ажлын бус цагаар /нийтээр амрах баяр, амралтын өдөр/ ирснээс ачаа ирсэн тухай мэдэгдэх боломжгүй болсон тохиолдолд ачаа ирсэн тухай падааны зохих хүснэгтэд тэмдэглэл хийж 12 цагийн дараа санамж нээнэ.

23.5.2. Тээвэрлэгч нь ачилт, буулгалтад ирсэн вагонуудыг цаг тухайд нь тавьж өгч чадаагүй, өртөөн дээр зогсоох тохиолдолд хүлээлгийн санамж нээнэ. Санамжийн “тайлбар” гэсэн хүснэгтэд ерөнхий маягтын актны дугаарыг бичнэ.

23.6. Төлбөр тооцоо хийх:

23.6.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн буюу тээвэрлэгчийн эзэмшлийн салбар зам, өртөө хоорондын зам, ачааны ажиллагаа хийгддэггүй өртөө, зөрлөгт ачилт буулгалтад вагоныг тавьж өгөх, татаж авахад санамжийг үйлдэж тарифын мөрдлөгийн дагуу холбогдох төлбөр, тооцоог бодож авна;

23.6.2. Санамжны он сар, өдөр, цаг, сэлгээний хугацааг засваргүй, үнэн зөв хөтлөх бөгөөд гарын үсгүүд нь бүрэн зурагдаж зөв бичигдсэн эсэхийг тооцооны ажилтан шалган хүлээн авч тээврийн төлбөр тооцоог хийнэ;

23.6.3. Төмөр замын тээврийн байгууллага нь вагонуудыг ачилт, буулгалтад тавьж өгч чадаагүй хүлээлгэн саатуулсан тохиолдолд ерөнхий маягтын актыг үйлдэн санамжийн цагаас хасаж тооцно. Ерөнхий маягтын актад өртөөний удирдах албан тушаалтан хяналт тавина /энэ заалтад илгээлтийн хаяг солилтод хамаарахгүй/;

23.6.4. Бүлэг вагонд нэг санамж нээсэн тохиолдолд санамжийг хамгийн сүүлчийн ачиж, буулгаж дууссан эцсийн цагаар, хэрвээ "салбар замд вагон тавих, татах гэрээ"-нд вагоныг хэсэгчлэн татаж авах тухай заасан бол санамжийг хэсэгчлэн хаасан тохиолдол бүрээр тавилт, таталтын хөлсийг тооцон авна

23.6.5. Энэхүү журмын 23.5.1-ийн “а, б, в, г, д”-д заасан үндэслэлээр хүлээлгийн санамж нээсэн тохиолдолд тарифын мөрдлөгийн дагуу холбогдох төлбөр, тооцоог илгээгч буюу хүлээн авагч хариуцан төлнө;

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЧАА ИРЭЛТИЙН МЭДЭГДЭЛ

24.1. Төмөр зам нь хүрэх өртөөнд ачаа ирсэн тухай 12 цагийн дотор ачааны нэр, вагоны болон чингэлгийн тоог дурьдаж ачаа хүлээн авагчид мэдэгдэнэ.

24.2. Ачаа ирсэн тухай мэдээллийг утас, факс, электрон шуудангаар тус тус дамжуулж болно.

24.3. Ачаа ирэлтийн тухай мэдээллийг ачаа хүлээн авагчид салбар зам ашиглалтын болон салбар замд вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээнд заасны дагуу мэдэгдэнэ. Мэдэгдэлд вагоны дугаар, илгээлтийн дугаар, ачааны нэр, ирсэн огноо, цагийг зааж бичнэ.

24.4. Ачааны мэдэгдлийг цахим болон цаасан дэвтэрт тэмдэглэнэ.

24.5. Мэдэгдлийн цахим болон цаасан дэвтэрт мэдэгдэл хүлээн авсан огноо, цаг минут, албан тушаалтны нэр, утасны дугаарыг бичиж тэмдэглэнэ.

24.6. Ачаа ирсэн тухай мэдэгдэж тээврийн бичиг баримтад тэмдэглэл хийж тоон гарын үсэг болон хуанлийн дардас дарна.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ АЧААГ ХҮЛЭЭН АВАГЧИД ОЛГОХ

25.1. Тээврийн хөлсийг ачаа хүлээн авагч бүрэн барагдуулсаны дараа тухайн байгууллагын баталгаажсан итгэмжлэлтэй төлөөлөгчид итгэмжлэл болон орлох падааныг үндэслэн ачааг олгоно. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хаягаар ирсэн ачааг авах эрхийг нотолсон нэг удаагийн буюу байнгын итгэмжлэхийг өөрийн төлөөлөгчид өгч төмөр замын тээврийн байгууллагад ирүүлнэ. Итгэмжлэлд хуулийн этгээд гарын үсэг зурж тэмдэг дарж баталгаажуулсан байна. Нэг удаагийн итгэмжлэлийг хуулийн этгээд тодорхой илгээлтийн ачаа авахад олгох бөгөөд тодорхой хугацаагаар олгогдсон итгэмжлэл нь итгэмжлэгдсэн хүний фото зурагтай, хугацаа заасан байх бөгөөд төмөр замын байгууллагад ирүүлж өртөөний хэрэгт хадгална. Төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий ажилтан итгэмжлэлийг иргэний үнэмлэхтэй нь тулган шалгаж хүлээн авагчид ачааг олгоно.

25.2. Ачаа хүлээн авагч тээвэрлэлтийн тооцоог хийж дууссаны дараа падаан, замын хүснэгтэд гарын үсэг зуруулж, падааныг түүнд олгох бөгөөд замын хүснэгтэд ачаа олгосон огноо, итгэмжлэхийн дугаар, түүнчлэн тооцооны дансны дугаар, банкны нэрийг бичнэ. Замын хүснэгтийн зохих хүснэгтэд "ачааг тээвэрлэлтийн бичиг баримтаар бүрэн олгов" тэмдэглэл хийж ачаа хүлээн авагчаар гарын үсэг зуруулж хүрэх өртөөний хуанлийн тэмдэг дарна. Зам зуурын тээврийн актанд бичсэн мэдээлэл үнэн зөв бол "ачаагөртөөнд-ны өдөр тогтоосон Дугаарын актаар олгов" тэмдэглэл хийнэ.

25.3. Ачаатай вагоныг нийтийн хэрэглээний ба дагнасан хэрэглээний зам, талбайд тээвэрлэгчийн ба дагнасан хэрэглээний зам эзэмшигчийн зүтгүүрээр тавьж өгөх, татаж авах, ачааг хүлээлцэх, бичиг баримт үйлдэх, ачаа хамгаалах талаар салбар зам ашиглах болон вагон тавьж өгөх, татаж авах гэрээнд тусгасан байна.

25.4. Импортын ачааг олгохдоо гаалийн байгууллагын олгох зөвшөөрлийг заавал авсан байна. Импортоор орж ирэх ачааг гаалийн хяналтын талбайгаар буулгуулах ажлыг тээвэрлэгч зохион байгуулна. Гаалийн хяналтын бус талбайд ачааг буулгах тохиолдолд ачаа хүлээн

авагчийн гаалийн байгууллагад гаргасан хүсэлтийг гаалийн байгууллагын дарга зөвшөөрч, байцаагч томилсон тухай тэмдэглэгээ хийгдсэн байна. Энэхүү бичгийг үндэслэн ачааг олгох ба энэ талаар тооцооны ажилтан нь тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга, ачааны диспетчер, жижүүрт мэдэгдэнэ. Тооцооны ажилтан тээврийн бичиг баримтад дарагдсан “гаалийн байгууллага зөвшөөрсөн” тэмдгийг үндэслэж тээврийн тооцоо хийнэ.

25.5. Ачааг олгоход падаан, замын хүснэгтэд өртөөний хуанлийн тэмдэг дарах ба энэ нь ачаа олгосон хугацааг илэрхийлнэ. Ачааг тээвэрлэгчийн хүчээр буулгасан үед агуулахаас ачаа татаж авч дууссан, эсвэл нийтийн ба дагнасан хэрэглээний замд вагоныг ачаа хүлээн авагчийн хүчээр буулгуулахаар тавьж өгсөн өдрийг ачааг жинхэнэ олгосон өдөр гэж үзнэ.

25.6. Иргэний хаягаар ирсэн ачааг хүлээн авагчийн иргэний үнэмлэхийг шалгаж олгох ба замын хүснэгтэд ачаа олгосон огноо бичиж хүлээн авагчаар гарын үсэг зуруулна. Ачааг цахим тээврийн бичиг баримтаар олгох үед тоон гарын үсэг зуруулна.

25.7. Ачаа хүлээн авагчийн итгэмжлэхийн үндсэн дээр ачааг өөр байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд шилжүүлэн олгож болно. Ийм тохиолдолд итгэмжлэхэд ачааг шилжүүлэн олгох байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, хаяг, регистрийн дугаарыг тодорхой заасан байна.

25.8. Ачаа хүлээн авагчийн хэрэгслээр ачааг буулгах үед түүний хүсэлтээр дагнасан хэрэглээний замд тавьж хүлээлцэх ажлыг /шилжүүлэлт/ шууд буулгасан газарт нь гүйцэтгэх бөгөөд санамжид хүлээлцсэн огноо, цагийг бичиж хүлээн авагч хүлээлгэн өгөгч талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулна.

25.9. Ачаатай вагон ба чингэлэг ачсан вагонуудыг хүлээлцэх болон олгоход ачаа хүлээн авагч ба төмөр замын тээврийн байгууллага нь гадна талын үзлэг хийж вагон болон чингэлгийн техникийн бүрэн бүтэн байдал, ломбоны байдал, тоо, хяналтын тэмдэг, тэмдэглэгээ нь холбогдох баримт бичигтэй тохирч байгаа эсэхийг шалган магадлах үүрэгтэй. Ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэсэн үед ачаа алдагдсан, гэмтсэн, сав баглаа боодол, хяналтын тууз нь бүрэн бүтэн байгаа эсэхийг шалган магадлана. Ачаа хүлээлцэх явцад ачаа тээврийн зөрчил илэрвэл ерөнхий маягтын акт, техникийн зөрчил илэрвэл техникийн гэмтлийн актаар тодорхойлж энэ тухай санамжид хүлээн авч байгаа тал тэмдэглэл хийнэ. Ачаа, вагон, чингэлэг хүлээлцэх үед илэрсэн зөрчлийн тухай санамжид тэмдэглэл хийгээгүй бол ачааг бүрэн бүтэн хүлээлцсэн гэж үзнэ.

25.10. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад ирсэн вагон ба чингэлэг нь тээвэрлэгчийн ломботой байх эсхүл ачаатай ирсэн вагон ба чингэлэгт техникийн гэмтэл болон ачаа тээврийн зөрчил илэрсэн тохиолдолд тээвэрлэгчийн ажилтан вагон, чингэлэг нээх, ачаа олгох үйл ажиллагаанд оролцож, ачааны жин байдлыг шалгаж олгоно.

25.11. Ачааны сав, баглаа, боодлын гэмтэл болон ачааны байдалд нөлөөлж болох бусад нөхцөл байдлыг илрүүлсэн үед тээвэрлэгч нь падаанд заасны дагуу зөвхөн гэмтсэн байрыг задалж ачааг шалгана. Хэрэв шаардлагатай бол бүгдийг шалгаж болно.

25.12. Ачаа илгээсэн өртөөнд тодорхойлогдсон жин, ачаа хүлээн авсан өртөөнд ачаа олгох үед гарсан жингийн зөрүү нь стандартчилал хэмжил зүйн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас тогтоосон жинлүүрийн заалтын зөрүүгийн норм, олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрийн дагуу тухайн ачааны жингийн хэвийн хорогдлын нормоос хэтрэхгүй байвал ачааны жин тохирсонд тооцно. Ачааг олгоход ачаанд хавсаргаж ирсэн ачааны чанарын тодорхойлолт, баглаа боодлын сертификат зэргийг заавал үзэж актад тусгана.

25.13. Хүрэх өртөөнд ачааны жин байдлыг шалгахад ачаа дутсан, гэмтсэн энэ нь зам зуурт тогтоосон тээврийн актаар баталгаажиг байвал тээвэрлэгч ачааны дутсан гэмтсэний

жинхэнэ хэмжээг тодорхойлох, хүлээн авагчид тээврийн акт өгөх үүрэгтэй. Ачааг олгох үед шаардлагатай бол тээвэрлэгчийн төлөөлөгчөөс гадна хүлээн авагчийн төлөөлөгч оролцсон комисс ачааны жин, байдал, байрын тоог шалгана. Комисс нь шалгалтын дүнгийн талаар акт бичиж тэр дор нь тухай нэгжийн удирдлагад мэдэгдэх үүрэгтэй. Ачааны дутагдал, гэмтэл илэрсэн нэгж нь шаардлагатай гэж үзвэл дутагдсан, гэмтсэн ачааг газар дээр нь очиж дахин нягтлан судалж үзэж, энэ тухай 4 цагийн дотор тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

25.14. Ачааг хүлээн авагчид олгох үед ачааны бүрэн бүтэн байдал алдагдсан нь илэрсэн тохиолдолд комисс томилж, ачаа дутсан, гэмтсэн хэмжээг тодорхойлох, тээврийн акт тогтоох зэрэг үйл ажиллагааг тээвэрлэгч нь олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр болон энэхүү журмын 27 дугаар бүлэг /төмөр замаар тээвэрлэгдсэн ачаанд акт тогтоох, бүртгэх/-т заасныг баримтлан зохион байгуулна.

25.15. Ачаа гаалийн хяналтад байгаа бол гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

25.16. Шаардлагатай гэж үзвэл тээвэрлэгч өөрийн санаачилгаар болон хүлээн авагчийн захиалгаар зохих салбарын магадлан шинжлэгч, мэргэжилтэн урьж акт тогтоолгоно. Магадлан шинжилгээний /экспертийн/ акт гаргахад тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга буюу түүний орлогч, тээвэрлэгчийн ажилтан заавал оролцоно. Олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр болон энэхүү журмын 27 дугаар бүлэг /төмөр замаар тээвэрлэгдсэн ачаанд акт тогтоох, бүртгэх/-т заасныг баримтлан тээвэрлэгчээс тогтоосон "тээвэрлэгч ачаа тээвэрлэлтийн ажиллагаанд мөрдөх акт гомдлын ажлын заавар" /цаашид "акт гомдлын ажлын заавар"/-ыг удирдлага болгон шаардлага хангахуйц акт тавьсан байна. Магадлан шинжилгээ хийсэн, магадлан шинжилгээний акт хавсаргасан тухай тээврийн актын зохих хүснэгтэд тэмдэглэл заавал хийнэ.

25.17. Техникийн гэмтэлгүй ба ачаа тээврийн зөрчилгүй вагонд ачааг илгээгчийн хүчээр ачсан бөгөөд ачаа илгээгчийн тавьсан ломбо нь гэмтэлгүй, мөн түүнчлэн ачаа илгээгч нь ачааг задгай хөдлөх бүрэлдэхүүнд ломбогүй тээвэрлэхийг зөвшөөрсөн тохиолдолд дутагдсан, гэмтсэн эвдэрсэн шинж тэмдэггүй ирсэн ачааг шалгахгүйгээр хүлээн авагчид олгоно.

25.18. Ачаа хүлээн авагч нь ачааны жин, байдал, тоо хэмжээг шалгуулах хүсэлтээ албан бичгээр ирүүлэх бөгөөд тээвэрлэгчийн төлөөлөгчийг ачааг шалгахад ажиллуулсаны хөлсийг тээвэрлэгчийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тарифт заасан хэмжээгээр төлнө.

25.19. Хүрэх өртөөнд нийтийн ба дагнасан хэрэглээний зам, талбайд ачаа буулгах үед тээврийн баримт бичигт заасан ачааны байрын тооноос илүү ачааны байр илэрсэн болон тээвэрлэгчийн ачиж, жинг тодорхойлсон ачаанаас жингээр илүү гарсан тохиолдолд ачааг доорх байдлаар олгоно:

- нийтийн хэрэглээний замд савтай ба ширхэгийн илүү гарсан ачааг тэдгээрийн эзнийг тогтоох хүртэл саатуулна. Хэрэв импортын ачаа бол тээвэрлэгч гаальд мэдэгдэнэ;
- задгай /овоолмог, нурмаг/ буюу шингэн байдлаар тээвэрлэсэн илүү гарсан ачаанд акт тогтоож хүлээн авагчид олгоно;
- илүү гарсан ачаанд тээврийн акт тогтоож, ачааг олгосон тухай тэмдэглэл хийнэ.

25.20. Ачаа илүү гарсан болох нь нотлогдсон тохиолдолд тээвэрлэгч нь акт гомдлын ажлын зааварт зааснаар тээврийн акт бүрдүүлнэ. Мөн тээвэрлэгч энэ тухай ачаа хүлээн авагчид, ачаа илгээсэн орон, шаардлагатай бол гааль болон бусад мэргэжлийн байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

25.21. Аюултай, хортой ачаа гэмтэлтэй вагонд буюу ломбогүй, эсвэл гэмтэлтэй ломботой ирсэн тохиолдолд ачааны байдал, байрны тоо, жинг ачаа хүлээн авагч нь өөрийн агуулахад тээвэрлэгчийн төлөөлөгчийг байлцуулан шалгана.

25.22. Хайрцаг, чемодан, сагс, чингэлэг бусад савтай болон жижиг илгээлтээр тээвэрлэсэн гэрийн эд хогшлыг олгоход өртөө нь ачааны байр, жинг данстай нь тулгаж шалгана. Энэ тохиолдолд хүлээн авагч нь илгээсэн өртөөний хуанлийн дардас дарж баталгаажуулсан гэрийн эд хогшлын жагсаалтыг ирүүлэх /үзүүлэх/ үүрэгтэй.

25.23. Өртөөнд вагон чингэлгээр ирсэн ачаа нь төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хүргэгчтэй ирсэн бол ачааг тээвэрлэгч шалгахгүйгээр олгоно.

25.24. Ачааг дагнасан хэрэглээний замд буулгаж, олгох үед тээвэрлэгчийн эрх бүхий ажилтны оролцоотойгоор өртөөний вагон пүүн дээр буюу өөрийн эзэмшлийн пүүн дээр ачааны жинг шалгах хүсэлтийг ачаа хүлээн авагч вагоныг салбар замд тавихаас өмнө ирүүлнэ. Хүрэх өртөөн дээр ачааны жинг илгээх өртөөнд пүүлсэн пүүтэй ижил маягийн пүүн дээр шалгана.

25.25. Дагнасан хэрэглээний замд ачаа буулгах үед ачааны жин байдлыг шалгахад тээвэрлэгч оролцсон тохиолдолд ачаа хүлээн авагч нь буулгах ачааг дахин шалгах боломжтой байхаар хураах үүрэгтэй. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан нь ачааг шалгах ачаа татгалзаж энэ тухай өөрийн удирдлагад мэдэгдэх үүрэгтэй.

25.26. Ачаа олгогч нь ачааг үнэ төлбөргүй хадгалах хугацаа дууссаны дараа олгохоор бол ачаа хадгаламжийн хөлс төлсөн эсэхийг шалгах үүрэгтэй. Ачааг үнэ төлбөргүй хадгалах хугацаа нь 24 цаг бөгөөд үүнийг ачаа буулгасны дараах хоногийн 00.00 цагаас эхлэн тоолно.

25.27. Нөхөн илгээлтээр ирсэн ачааг дараах байдлаар олгоно:

- тээврийн үндсэн баримт /падаан/-тай ирсэн ачааны хэсгийг олгоходоо үндсэн бичиг баримтаар тээврийн тооцоо хийж тээврийн акт тогтооно. Тээврийн актыг үндсэн падааны хамт ачаа хүлээн авагчид олгоно.

- нөхөн илгээлтээр ирсэн хэсгийг хүлээн авагчид байгаа үндсэн падаан, тээврийн акт, эцсийн тооцоог үндэслэн олгоно. Тээврийн актыг ачаа хүлээн авагчаас хураан авч тээвэрлэгчид үлдээнэ.

25.28. Ачааны бичиг баримт үрэгдсэн тохиолдолд эрэл хийнэ. Эрэл үр дүнгүй байвал ачаа олгох хуудас /орлох падаан/ болон бусад холбогдох баримтыг үндэслэн олгоно.

25.29. Ямар ч тохиолдолд буулгаж олгосон ачаа /вагон ба чингэлэг/-ны тугалган ломбыг 20 см, бусад ломбыг 2 см-ын үзүүр гарган гэмтээлгүйгээр таслан авч, хатуу цаасанд бэхлэн /нэг удаагийн ломбыг хатуу уутанд хийж/ вагоны хуудсанд хавсарган өртөөний архивт хоёр жилийн хугацаатай хадгална. Тээврийн акт тогтоосон тохиолдолд ломбо, вагоны хуудсыг тээврийн актанд хавсаргана.

25.30. Тээвэрлэгч хүрэх өртөөн дээр ачааны жин байдал, байрын тоог шалгахад ачаа нь падаанд заасан мэдүүлэгтэй тохирч байвал падааны зохих хүснэгтэд ачааг олгоход шалгасан падаанд заасантай тохирсон, хэвийн хорогдлын хэмжээнд г.м тэмдэглэл хийж гарын үсэг зурж хуанлийн тэмдэглэл дарна. Замын хүснэгтэд мөн адил дардас хийнэ.

25.31. Ачааг олгохын өмнө тооцооны газарт тээврийн үнэлгээг шалгаж нэмэгдэл төлбөрийг барагдуулна.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

АЧААГ БУУЛГАСНЫ ДАРАА ВАГОН, ЧИНГЭЛГИЙГ ЦЭВЭРЛЭХ, УГААХ

26.1. Вагон ба чингэлэгтэй ачааг буулгасны дараа гадна, дотор талаас нь цэвэрлэх бөгөөд бэхэлгээний үл авагдах хэрэгслээс бусад ачааны бэхэлгээг авч ачаа хүлээн авагч тээвэрлэгчид бэхэлгээнд зориулсан үл авагдах хэрэгслийг бүрэн бүтэн техникийн байдалд нь оруулж тээвэрлэгчид өгнө.

26.2. Ачааг буулгасны дараа вагоны кузов /тэвш/ ба чингэлгийн дотор, гадна талд үлдсэн буюу дагтаршсан бүх үлдэгдлийг арилгаж мөн түүнчлэн вагоны явах ангиуд дээрх /дам нуруу, тэргэнцэр, нээлхийн тагууд гэх мэт/ болон ачаатай хамт олгодоггүй вагоны үл авагдах тоноглолоос бусад вагон хоорондын холбоосуудыг цэвэрлэсэн нөхцөлд вагон ба чингэлгүүдийг /цистерн-вагон, бункерт, хагас вагонуудаас бусад/ цэвэрлэгдсэнд тооцно.

26.3. Хэрвээ цистерний торх буюу бункерийн дотор ба гаднах гадаргуу дээр ачааны үлдэгдэл байхгүй нөхцөлд цистерн вагон ба бункерт хагас вагоныг цэвэрлэгдсэн гэж үзнэ. Цистернээс ачааг дээгүүр нь /дээд юүлэх хэрэгсэлтэй/ юүлэх үед буугдаагүй ачааны үлдэгдэл 1 /нэг/ см-ээс илүүгүй байж болно.

26.4. Замналаар мөн түүнчлэн өөрийн ба түрээсийн вагонуудад нунтаг болон овоолмог ачааг тээвэрлэх үед буулгасны дараа вагонд байж болох ачааны үлдэгдлийг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, тээвэрлэгчийн зөвхөн бичгээр зөвшилцсон ёсоор хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шаардлагыг үндэслэн тогтооно. Вагон ба чингэлгийн гадна гадаргуу, явах ангийн цэвэрлэгээг бүх тохиолдолд тэдгээр нь хэнд харьяалагдахаас үл хамааран хийнэ.

26.5. Цэвэрлэсэн вагонд бага зэргийн цас байхыг бохирдсон гэж үзэхгүй.

26.6. Вагон, чингэлэг ба вагоны арал дээрх таних тэмдэг, дугаар ба бусад бичиглэл нь уншигдахаар тод байна.

26.7. Вагон ба чингэлгийн гадна, дотно гадаргуу нь хамгаалалтын хальс, үл уусагч шингэн бодис /эмульст/ мөн түүнчлэн наалт, хаяг, зүүлт, шохойн тэмдэглэл зэрэг вагоныг бохирдуулагчаас цэвэрлэгдсэн байна. Харин тухайн вагон болон чингэлэгт олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр болон энэхүү журмаар өөр ачааг тээвэрлэх үед зөвшөөрөгдсөн хоосон вагон дээрх хаяг, зүүлтийг цэвэрлэхгүй байж болно.

26.8. Вагон ба чингэлгийг цэвэрлэх бүх арга нь тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хангаж орчин тойрныг бохирдуулахгүй байна.

26.9. Буулгалтын дараа вагон, чингэлэгт өмнө нь тээвэрлэж байсан ачааны үлдэгдэл илрүүлбэл хэний хүч, хэрэгслээр буулгалт гүйцэтгэснээс үл хамааран ачаа хүлээн авагч буюу тээвэрлэгч вагон, чингэлгийг бүх ачааны үлдэгдлээс бүрэн цэвэрлэх үүрэгтэй.

26.10. Ачаа хүлээн авагч нь цэвэрлэгдээгүй вагон, чингэлэгт түүний хаягаар ачаа ачсан ачаа илгээгчид гомдол гаргах эрхтэй. Тухайн тохиолдолд ачаа хүлээн авагчийн хүсэлтээр ерөнхий маягтын акт тогтооно.

26.11. Ачаа хүлээн авагч нь ачаа илгээгчид тээвэрлэсэн ачааны үлдэгдэл байсан талаар гомдол гаргаж акт тавьж болох бөгөөд ачаа хүлээн авагчийн хүсэлтээр тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан актанд гарын үсэг зурж болно.

26.12. Салбар зам зам, талбайд ачаа хүлээн авагчийн хүч, хэрэгслээр ачааг буулгах үед вагон, чингэлгийн цэвэрлэгээнээс үлдсэн хог, ачаа, бэхэлгээ, баглаа боодол ба бусад материалын үлдэгдлийг тухайн газраас /өртөө/ ачааныхаа хамт ачаа хүлээн авагч зөөж зайлуулна.

26.13. Ачаа хүлээн авагч нь буулгалт хийсний дараа тээвэрлэсэн ачаанаас вагоныг бохирдуулсан ба эвгүй үнэртэй болгосон тохиолдолд ачаа хүлээн авагч уг вагонд угаалга хийж арилгана.

26.14. Буулгалтын дараа битүү вагоныг заавал угаах ачааны жагсаалтыг гаргасан байна. Үр тариа тээвэрлэх зориулалттай вагонд өөр төрлийн /үр тарианаас бусад/ ачаа тээвэрлэснийг буулгасны дараа ачаа хүлээн авагч нь уг вагоныг угаалгаж авна. Арвайн соёолж буулгасны дараа ачаа хүлээн авагч нь онцгой үнэрийг нь арилгах зорилгоор үр тарианы вагоныг агааржуулна.

26.15. Тээвэрлэсний дараа төмөр замын тээврийн байгууллага зүгээс ачаа хүлээн авагчийн хүч хэрэгслээр тусгай зориулалтын тогтмол дулаант, хөргүүрт, битүү вагоныг угаалгаж, мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн боловсруулалт хийлгэнэ. Түргэн муудах ачааны жагсаалтыг олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээрээр тодорхойлно.

26.16. Буулгалтын дараа вагон, чингэлгийг цэвэрлэх, угаах, уураар утах ба халдваргүйжүүлэх шаардлагатай аюултай, түүний дотор юүлэх ачааны жагсаалтыг төмөр замаар тээвэрлэх аюултай ачааны ба цистерн вагонд тээвэрлэх юүлэх /шингэн/ ачаа, бункерт хагас вагонд тээвэрлэх, нефтийн хар тосны тээвэрлэлтийг энэхүү журмаар тодорхойлно.

26.17. Тээвэрлэлтийн дараа вагоныг угааж мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгал хийх шаардлагатай бөгөөд улсын мал эмнэлгийн хяналтын байгууллагын хяналтад байх ачааны жагсаалтыг улсын мал эмнэлгийн хяналтын дор энэхүү журмын 11 дүгээр бүлэг /төмөр замаар мал, амьтан тээвэрлэх/-т зааснаар тогтооно.

26.18. Ачаа хүлээн авагч нь вагоныг угаах боломжгүй бол төмөр замын тээврийн байгууллага вагон угаах, ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

26.19. Ачаа ба тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг ачаа хүлээн авагч буюу мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагууд гүйцэтгэнэ.

26.20. Төмөр замын тээврийн байгууллага нь угаагдсан вагоныг шалгасан тухай вагон дугаарыг заасан акт үйлдэнэ.

26.21. Амьтан, шувуу, тэдгээрийн түүхий эдийг буулгасны дараа битүү ба тогтмол дулаант вагоны угаалга, мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалыг ачаа хүлээн авагчийн хүч хэрэгсэл, зардлаар гүйцэтгэнэ.

26.22. Тусгай хэрэгцээний вагон, чингэлгийн угаалга, мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалыг тохиролцсон талууд байхгүй бол ачаа хүлээн авагч гүйцэтгэнэ.

26.23. Вагон, чингэлгийн цэвэрлэгээний хөлс:

26.23.1. Ачаа хүлээн авагч нь вагоныг цэвэрлэж, угааж ариутгах шаардлагыг зөрчсөн үед тээвэрлэгч нь ачаа хүлээн авагчаас дээрх шаардлагыг биелүүлэх хүртэл вагон, чингэлгийн ачааг буулгасан буюу юүлэн авсны дараа вагоныг тавьж өгөх, татаж авах гэрээнд зааснаар вагон чингэлгийг хүлээн авахгүй байх эрхтэй. Энэ тохиолдолд нэр заагдсан этгээдээс вагон ба

чингэлэг ашигласны төлбөрийг вагоныг буулгалтын зам дээр тавьж өгсөн цагаас эхлэн тэдгээрийг зогсоосон бүх хугацаанд тооцож нэхэмжилнэ;

26.23.2. Ачаа илгээгчийн зөвшөөрснөөр тээвэрлэгч хаалга, нээлхий нь онгорхой, ачааны бэхлэлгээнд зориулсан хэрэгсэл нь авагдаагүй, цэвэрлэгдээгүй, хоосон вагоныг ачилтад тавьж өгсөн тохиолдолд вагон цэвэрлэх хугацааны ашиглалтын хөлсийг санамжийн нээх хугацаанаас хасч тооцно;

26.23.3. Хоосон вагоныг мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалыг хоёр ба гуравдугаар зэрэглэлээр хийхээр явуулахад тээврийн бичиг баримт үйлдэнэ;

26.23.4. Хоосон битүү вагоныг угаалга ба мал эмнэлэг-эрүүл ахуй, ариун цэврийн ариутгалд нэгдүгээр зэрэглэлээр /ангилал/ хийхээр явуулахад буцааж илгээх падаанаар, харин тогтмол дулаант вагонуудыг тээврийн бичиг баримтаар явуулна.

26.24. Дараах ачаанаас суларсан вагоныг цэвэрлэнэ:

- жижиглэсэн ба нунтагласан шохойн зуурмаг алебастр /гипс/;
- аргилит;
- асбест /галд тэсвэртэй огсорхог материал/;
- хүнд шпат /барит/;
- эрдэст хөвөн;
- ногоо /выжики овощные/;
- шохойн зуурмаг /гипс/;
- төрөл бүрийн шавар;
- шаварлаг хөрс /глинозём/;
- кальц агуулсан минерал бодис /доломит/;
- хар бал /графит/;
- ваннанд зориулсан хар шавар /грязи/;
- тэжээлийн хөрөнгө /дрожжи кормовые/;
- төмсний ба манжингийн хальс шахдас /жам картофельный и свекловичный/;
- төрөл бүрийн үнс;
- бүх төрлийн шатсан хаягдал /изгарь/;
- цагаан шавар /каолин/;
- галд тэсвэртэй хатуу цаас /асбестон картон/;
- төрөл бүрийн дэгдэмхий бодис;
- багсармал тэжээл
- идэвхжүүлсэн хүнсний бэлдмэл /концентрат апативовый/;
- нурмаг барилгын материал, /концентрат нефелиновый/;
- будаг ба хуурай будагч;
- будаа /хэрэглэгчийн баглаа боодол гэмтсэн үед/;
- төрөл бүрийн шохой;
- зуурмаг /мертели/;
- модны ногоон навчаар хийсэн витаминлаг гурил;
- кальцит гурил;
- төрөл бүрийн тэжээлийн гурил
- төрөл бүрийн хүнсний гурил;
- шилмүүст витаминлаг гурил;
- өнгөт металлын үртэс;
- төрөл бүрийн хаягдал;
- /пегматий/;
- хар тосны нунтаг /порошок асфальтовый/;
- шохойн нунтаг /порошок известковый/;

- төмөрлөг магнезийн нунтаг;
- галд тэсвэртэй шаврын нунтаг /порошок шамотный/;
- төрөл бүрийн тоос;
- янжуур тамхи /баглаа, сав нь гэмтсэн үед/;
- хүнсний ба техникийн боловсруулсан давс;
- угаалгын нунтаг;
- техникийн барилгын шил /хагарсан үед/;
- өнгөт металл ба тэдгээрийн хайлшны зоргодос;
- төрөл бүрийн сульфат /аюултайгаас бусад/;
- түүхий тамхи ба макорн;
- төрөл бүрийн тамхи /навчит ба үндэстэй, хамрын, боловсруулсан/;
- нунтагласан ба хэсэглэсэн цагаан нунтаг /тальк/;
- төрөл бүрийн шилэн уут, сав /хагарсан үед/;
- хүлэр ба хүлрийн бүтээгдэхүүн /торф/;
- органик ба иж бүрдлийн бордоо;
- химийн ба минералийн бордоо;
- хатаасан махан таташ /ууттай/ ;
- төмрийн хайлш /ферросплавы/;
- төрөл бүрийн цемент;
- хэсэглэсэн галд тэсвэртэй шавар /шамот/;
- амьтны хоол, тэжээл;
- мал амьтан;
- ноос, арьс, шир, малын түүхий эд.

Хорин долдугаар бүлэг

Төмөр замаар тээвэрлэгдсэн ачаанд акт тогтоох, бүртгэх

27.1. Тээвэрлэлтийн үед тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчид эд материалын хариуцлага хүлээлгэх үндэс нь төмөр замын тээврийн байгууллага тогтоосон тээврийн акт байна.

27.2. Тээврийн актыг доорх нөхцөл, байдлыг нотлох зорилгоор тогтооно:

- тээврийн бичиг баримтанд дурдсан ачаа буюу тээшийн нэр, жин, байрын тоо, хүрэх өртөө, хүлээн авагчийн хаяг ачааны марклал, дугаар жинхэнэ байгаа байдалтай тохироогүй;
- ачаа гэмтсэн, муудсан;
- тухайн ачааны падаан ирээгүй эсхүл тухай падааны ачаа ирээгүй, тээврийн бичиг баримтны хуудас дутуу;
- алдагдсан ачааг төмөр замын тээврийн байгууллага бүрэн эсхүл дутуу тушаах.

27.3. Тээврийн актыг ачааг шалгаж буулгасан төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий ажилтны бичсэн илтгэх хуудасны дагуу тогтооно. Илтгэх хуудсанд тээврийн акт тогтооход шаардагдах бүх мэдээллийг оруулсан байна. Илтгэх хуудасны агуулгыг өртөөний төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий байгууллагын дарга шалгаж тээврийн акт тогтоох эсэх тухай эцсийн шийдвэрийг гаргана.

27.3.1. Тээврийн актны мэдээг тээвэрлэгчийн төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий дээд шатны байгууллагад 24 цагийн дотор өгнө;

27.3.2. Төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий байгууллага тээврийн актыг 3 хувь үйлдэж, нэгдүгээр хувийг төмөр замын тээврийн байгууллагын эрх бүхий дээд шатны байгууллагад хавсралт баримтуудын хамт, хоёрдугаар хувийг ачаа хүлээн авагчид, гуравдугаар хувийг тухайн тээврийн актыг тогтоосон төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий байгууллагын хэрэгт тус тус хадгална. Шилжүүлэн ачилттай дамжуулах өртөөнд ачааг

шалган хүлээлцэх үед тээврийн актыг 5 хувь үйлдэнэ. Тээврийн актыг хоёр хувийг хавсралтын хамт акт үйлдсэн тээвэрлэгчид төмөр замын тээврийн байгууллага үлдэж, хоёр хувийг падаанд хавсаргаж хүрэх өртөөнд явуулах ба үлдсэн нэг хувийг хүлээлгэн өгсөн тээвэрлэгчид төмөр замын тээврийн байгууллага дамжуулна;

27.3.3. Тээврийн актыг хувь бүрт өртөөний тэмдэг дарж, акт тогтооход оролцсон албан тушаалтан, ажилтан гарын үсэг зурна;

27.4. Тээврийн актыг бүртгэлийн хатуу тооцоот маягтан дээр үйлдэнэ. Бүртгэлийн хатуу тооцоот тээврийн актыг маягтыг буруу бөглөвөл актыг хувь бүрийг чагталж зураад "хүчингүй" гэсэн тэмдэглэл хийж өртөөний тээвэрлэгчийн төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий байгууллагын хэрэгт хадгална. Энэ тухай тээвэрлэгчийн төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий дээд шатны байгууллагын албан тушаалтанд 24 цагийн дотор мэдэгдэнэ. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага тээврийн актыг хуулбарлахдаа хэвлэлийн дугааргүй маягт дээр буулгана;

27.5. Тээврийн актыг илгээх өртөө буюу зам зуурын өртөөнд тогтоосон тохиолдолд актыг хоёр дахь хувийг тээврийн бичиг баримтанд хавсарган хүрэх өртөөнд явуулна. Тээврийн актыг тогтоосон өртөө падаан дахь "тээврийн актыг тэмдэглэгээ" гэсэн хүснэгтэд тухайн өртөөний тээвэрлэгчийн төмөр замын тээврийн байгууллага эрх бүхий байгууллагын холбогдох ажилтан, тогтоосон актыг дугаар, огноо, акт тогтоосон шалтгааныг бичиж гарын үсэг зурж, өртөөний хуанлийн дардсаар баталгаажуулна. Падаанд "тээврийн акттай" гэсэн тэмдэглэгээтэй боловч тээврийн бичиг баримтад тухайн акт хавсрагдаж ирээгүй бол шаардлагатай тохиолдолд ачааг буулгаж олгох үед тээврийн актыг тогтооно.

27.6. Илгээх болон зам зуурын өртөөний тээврийн акттай ачаанд хүрэх өртөөнд шинээр акт тогтоох шаардлагагүй бол өртөөний акт бүртгэлд бүртгэн авч тус тээврийн актыг хатуу дугаарын хуваарьт бүртгэлийн дугаарыг бичиж дугаарлана. Зам зуурын өртөөний тээврийн актад "тээврийн акттай тохирсон" гэсэн тэмдэглэл хийж өртөө, ачиж буулгах ажил хариуцсан байгууллагын тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга, тээвэрлэгчийн эрх бүхий ажилтан, ачаа хүлээн авагч гарын үсэг зурж, өртөөний хуанлийн тэмдгээр баталгаажуулан тээвэрлэгчийн эрх бүхий дээд шатны байгууллагад явуулна. Зам зуурын тавигдсан тээврийн ачаа хүлээн авагчид өгсөн бол актаар тээвэрлэгчид хариуцлага тооцож ачаа илгээгчид өгсөн бол актыг хуулбарыг тээвэрлэгчийн эрх бүхий дээд шатны байгууллагад явуулна. Хүрэх өртөөнд тээврийн акт дахин тогтоосон тохиолдолд зам зуурын өртөөний тээврийн актыг хуулбарыг уг тээврийн актад хавсаргаж тээвэрлэгчийн эрх бүхий дээд байгууллагад явуулна.

27.7. Хүрэх өртөөнд тээврийн актыг хуулбарлахдаа ямар нэг өөрчлөлт засвар хийхгүй. Тээврийн актад бичигдсэн зүйлтэй ачааны жинхэнэ байгаа байдал тохирохгүй байх эсхүл зам зуурын өртөөдөд хоёр буюу түүнээс олон акт тогтоогдсон бол уг ачааг хүрэх өртөөнд дээр заавал шалган буулгаж, байгаа байдлаар нь тээврийн актыг дахин тогтооно. Энэ тохиолдолд хүлээн авагчид зөвхөн сүүлд тогтоосон тээврийн актыг хувийг өгнө.

27.8. Тээврийн актыг ачааны бүрэн бүтэн байдал алдагдсаныг илрүүлсэн тухайн өдөрт нь илгээлт тус бүрээр тогтооно.

27.9. Ачаа шалгасан дүнг тээврийн актад бичих:

27.9.1. Тээврийн актыг зохих хүснэгтүүдийг асуултын дагуу бүрэн бөглөж, ачааны тоо ширхэг, жин, сав, баглаа, боодлын эвдэрч гэмтсэн байдлыг тодорхой бичих, ямар нөхцөлд ачааны бүрэн бүтэн байдлын алдагдал илэрснийг заана. Ачааны бүрэн бүтэн байдлын алдагдлын шалтгаан, илгээгч, тээвэрлэгчийн буруутайг заасан ямар нэг таамаглал, дүгнэлтийг

актад дурьдахгүй. Харин дүгнэлтийг тээврийн актны дагуу ачааны бүрэн бүтэн байдлын алдагдлыг бүрэн судалсны эцэст хийнэ;

27.9.2. Ачаа алдагдах, гэмтээхэд хүргэсэн вагон, чингэлгийн гэмтлийг /шал, хаалга, дээврийн цоорхой, шонгийн хугаралт, нээлхийн гэмтэл буюу дутуу хаагдалт, хаалганы цүүний гэмтэл г.м./ техникийн гэмтлийн актад тусгана. Ачааг хулгайлахаар санаатайгаар вагон, чингэлгийн дээвэр, шал, ханыг цоолсон болон ул мөрөө арилгахаар оролдсон нь тогтоогдвол энэ тухай актад тодорхой заана;

27.9.3. Тээврийн актад, вагон доторх ачааны ачилт, байрлуулалтаас шалтгаалсан ачааны гэмтлийн тохиолдол бүрт, ачааг зөв ачиж байрлуулсан эсэх, илгээгч эсхүл тээвэрлэгчийн хүч хэрэгслээр ачсан болохыг тодорхойлно. Ачилт, техникийн нөхцөлийг зөрчиж хийгдсэн байвал энэ тухай актад тодорхой заана;

27.9.4. Тээврийн актад ачааны жингийн тухай дараах зүйлсийг тодорхой заана;

- ачааны жинг ямар аргаар тодорхойлсон /стандартаар, тооцоолох аргаар, пүүлсэн/ болохыг;
- илгээх өртөөн дээр илгээгч болон тээвэрлэгчийн аль нь ачааны жинг тодорхойлсон болохыг;
- "ачааны бохир жин", "вагоны хоосон жин хэв бичээсээс авсан" эсхүл "вагоны хоосон жинг шалгасан", "ачааны жин" зэрэг болно.

27.9.5. Ачааны сав, баглаа, боодол болон ачаа гэмтэхэд хаана ямар хэсэгт чухам ямар гэмтэл байгааг тодорхой заана. Тухайлбал:

- баглаа боодол гэмтсэн буюу задалсан ул мөртэй эсэх, гэмтсэн ачааны баглаа боодол нь бүрэн бүтэн эсэх;
- баглааны татлага утас, хяналтын тууз бүтэн эсэх, татлага утас хяналтын туузыг гэмтээлгүйгээр ачааг гарган авч болох эсэх;
- ачаа вагон дотроо асгарсан эсэх, асгарсан бол хэдий хэмжээтэй асгарсан эсэх;
- ачааны дотоод баглаа нь бүтэн эсэх, жийрэглэсэн материал нь хүрэлцээтэй эсэх, баглааг засаж янзалсан бол засварын шинж тэмдэгтэй эсэх, мөн гэмтэлтэй байр вагоны аль хэсэгт байсныг.

27.9.6. Ачаа гэмтэх, дутах үед ачаа болон баглаа боодлын байдлыг "ачаа гэмтсэн", "сав эвдэрсэн" гэх мэтээр ерөнхийлөн бичихгүй.

27.9.7. Гэмтэлтэй байр бүрийн ачааны болон баглаа боодлын байдлыг тодорхой бичнэ. Төрөл бүрийн нэр бүхий ачааг нэг падаантай тээвэрлэх үед ачаа гэмтэж алдагдсан тохиолдолд, ачаа тус бүрээр нь байрын тооны дагуу ялгалт хийж, жинг шалгаад тээврийн актад бичнэ. Баглаа, боодол дээр нь ачааны жинг заасан буюу үндэсний стандартаар тодорхойлсон байвал зөвхөн гэмтэлтэй байрыг пүүлж бүтэн байрын жинг шалгаагүй гэж актад тусгана. Гэмтэлтэй байрын жинг тусад нь бичнэ.

• торхтой ачаанд гэмтсэн, дутсан байдал илэрвэл актад торхны гэмтэл /ёроол нь унасан, бүслүүр нь суларсан/, мөн бөглөөтэй талыг нь хааш нь харуулж ачсан, ачаа нь гоожсон эсэх, вагоны шалан дээр гоожсон ачааны ул мөр ямар байгаа эсэхийг заана. Торхыг бөөрөөр нь хэвтүүлж ачсан бол вагоны дагуу эсвэл хөндлөнгөөр нь ачсан эсэх, торхны хооронд зай, хөдөлгөөнгүй байлгах ивүүрийг вагоны шаланд бэхэлсэн эсэх, торхыг дангаар болон давхарлаж ачсан, завсарт нь жийрэг хийж ачсан эсэхийг тодорхойлно.

• цаас болон хуйлаастай ачаа гэмтвэл /огтлогдох, үрэгдэх холгогдох, цоорох, байр нь норох/ тээврийн актад баглааны төрөл, хэлбэр /модон, цаасан хайрцаг ба боодол/, баглаа нь тууз, төмөр утсан бүслүүртэй эсэх, гадаад дотоод баглааны гэмтлийн хэмжээ, ачааг вагон,

чингэлэгт байрлуулсан байдал зэргийг заана. Хуйлаастай ачаа гэмтэхэд тээврийн актад аль хэсэгт ямар хэмжээтэй урагдсан, холгогдсон, гэмтсэн болохыг тодорхой заана.

- сав, баглаа, боодол /шуудай, цаасан хайрцаг, г.м/ гэмтэлтэй тохиолдолд ачаа дутвал тээврийн актад баглаа боодлын материалын тухай, сав, баглаа, боодолд нь ачааны жинд тохирч байгаа эсэх, ачааны байр нь хоорондоо адил эсэхийг заана. Сав, баглаа, боодлыг илгээгчийн ломбоор битүүмжилсэн бол акт тогтоохдоо ломбоны байдал, ломбыг гэмтээлгүйгээр ачааг гарган авч болох эсэхийг заана.

- ачаа /гурил, ётон, элсэн чихэр г.м/ норсон тохиолдолд тээврийн актад уг ачааны гадна талын бүх шинж тэмдгийг тодорхой заана. Үүнд: норсон ачааны байрын тоо, ачаа хатуурч хатсан гэх мэт. Түүнчлэн норсон ачаа вагоны хаана /хаалга, нээлхийний ойролцоо, вагоны дунд хэсгээс, ачааны дээд дунд доод үеэс г.м/ ямар байдалтай байсныг заана. Сав, боодол нь чийгтэй, толботой байвал вагонд цас борооны ус нэвчсэн ул мөртэй /вагоны шал, хана/ эсэхийг заана.

27.9.8. Битүү вагонд тээвэрлэж байгаа ачаанаас дутагдал илрэхэд тээврийн актад вагоныг багтаамжийг ашиглан даацанд нь хүртэл ачсан эсэх, дутсан ачаа вагонд багтах эсэхийг заана.

27.9.9. Задгай хөдлөх бүрэлдэхүүнээр тээвэрлэсэн ачаа дутсан, гэмтсэн байвал тээврийн актад:

- тээвэрлэгдсэн ачааны угсралт, байрлуулалт, ивүүр, бүтээлэг, татлага зэрэг ачилттай холбогдолтой бүх зөрчлийг;

- ачааны сав, баглаа боодол нь ачааны жин, шинж чанарт тохирч байгаа эсэх;
- ачааг овоолон ачиж тээвэрлэсэн бол ачааны гадаргууд хөндөгдсөн шинж бий эсэхийг;
- ачилтын техникийн нөхцөл зөрчигдсэн, хяналтын зураас, тэмдэглэгээ арилсан, өөрчлөгдсөн эсэхийг тус тус заана.

27.9.10. Битүү вагонд хаалганы хашлагатай тээвэрлэсэн ачаанаас дутвал тээврийн актад хашлага нь вагоны хана, шаланд нягт шахагдсан, гэмтэлтэй, зөв байрласан эсэхийг бичнэ.

27.9.11. Цистернд тээвэрлэсэн ачаанаас дутвал ачааны юүлэлтийн өндөр, цистерны загвар, ачааны хувийн жин, орчны агаарын температур, түүнчлэн гоожиж байсан эсэхийг актад тодорхой заана. Ачаа гоожиж байгаа бол урсан гоожиж байгаа эсэх, дусалж байгаа бол минутанд хэдэн дусал дусалж байгааг бичнэ.

27.9.12. Хөргүүрт вагон, чингэлэгт тээвэрлэж байгаа хялбар муудах ачааг шалгаад тээврийн актад дараах зүйлүүдийг тодруулж бичнэ. Үүнд:

- баглаа, савгүй овоолж буюу баглаа, савтай ачааг ачмагтай, ивүүртэй, тавиур дээр болон өлгөж ачсан зэрэг ачилтын аргыг заахаас гадна хураалт нь техникийн нөхцөлтэй тохирч байгаа эсэх;

- сав, баглааны төрөл, түүний гэмтсэн эсэх, гэмтлийн шалтгаан зэрэг;
- вагоны шалан дээр муудсан ачаанаас гоожсон ул мөр байсан эсэх, муудсан ачаа вагоны аль хэсгээс илэрсэн болох;

- вагоны хана, хаалганы түгжээ гэмтэлтэй болон засвартай эсэх;
- өвөл, зуны аль ч улиралд гаднах агаарын температурын хэмжээ, тээвэрлэлтийн үед температурын дэглэмийг баримталсан эсэх;

- вагон, чингэлгийн хөргүүр нь хэвийн ажиллагаатай байгаа эсэх.

27.9.13. Тээвэрлэсэн мал амьтдад өвчин, хорогдол тохиолдвол тэр үед нь хүргэгч байсан эсэх, вагоныг сараалж болон бусад хэрэгслээр зөв тоногдсон эсэх, энэхүү журмын 11 дүгээр бүлэг /төмөр замаар мал амьтан тээвэрлэх/-т заасныг хүргэгч зөрчсөн эсэхийг актад бичнэ.

27.9.14. Хэд хэдэн илгээлттэй нэг илгээгчийн нэг хүлээн авагчтай нэг төрлийн ачаанд ижил төрлийн гэмтэл илэрсэн тохиолдолд нэг тээврийн акт тогтоож болно.

27.9.15. Нэг илгээгчээс нэг хүлээн авагчийн хаягаар явуулсан нэг төрлийн хэд хэдэн вагонтой шингэн, нурмаг, овоолмог ачааг бүгдийг нь нэг зэрэг олгон шалгахад бүх ачааний хэвийн хорогдлоос хэтэрсэн дутагдал болон илүүдэл илэрсэн, жингийн заалтын зөрүүгийн нормоос буюу ачааны жинг тодорхойлох нэгдсэн нормоос ачаа дутсан болон илүүдсэн тухай нэгдсэн нэг тээврийн акт тавьж болно. Энэ тохиолдолд ачаа нь дутсан, илүүдсэн, зөв жинтэй байсан гэж ялгалгүйгээр шалгаж олгосон бүх вагоныг актад бичнэ.

27.9.16. Задгай хөдлөх бүрэлдэхүүн дээр тээвэрлэсэн автомашин, трактор, өөрөө явдаг машин техникийн амархан авагддаг эд анги, багаж гэмтэж дутахад тээврийн актад дараах зүйлүүдийг тодруулж бичнэ. Үүнд:

- ачилтын бэхэлгээг буруу болон дутуу хийснээс эд ангийг эвдэрч гэмтэхэд хүргэсэн байж болзошгүй талаар;
- ломбыг гэмтээлгүйгээр техник болон машины кабин доторх эд анги, сэлбэгний хайрцаг доторх зүйлийг авагдахуйцаар ломбодсон зөрчлийн талаар;
- машинаас хялбар салгаж болох болон хагалж болох эд ангийг салган авч хаалт хамгаалалт хийх зааврыг ачаа илгээгч зөрчсөн талаар;
- эд ангийн жагсаалтын хуудсанд дурдсан зүйлсээс дутаж байгаа эд ангийн нэр, тоо, тэдгээрийн байрлалыг тус тус заана.

27.10. Ерөнхий маягтын акт нь ачаа тээвэрлэлтэд нөлөөлсөн эсвэл нөлөөлж болзошгүй шалтгааныг тогтоосон тээвэрлэгчийн бичиг баримт болно.

27.10.1. Ерөнхий маягтын актыг доорх тохиолдолд тогтооно:

- энэхүү журмын дагуу илгээгчийн падаанд хавсаргасан бичиг баримт дутвал;
- илгээгчээс үнийг нь зарласан ачааны үнэ ачааныхаа жинхэнэ үнээс хэтэрсэн үед тээвэрлэгч ачаа тээшийг хүлээн авахаас татгалзах;
- ачааны сав, баглаа нь эвдэрхий, эсвэл гэмтэж муудсаны улмаас тээвэрлэлтэд хүлээн авахаас татгалзах; энэ тохиолдолд ачаа илгээгчийн шаардлагаар акт тогтооно.
- хүргэгчтэй яваа ачаатай вагоноос хэрэгсэл дутах, эсвэл вагон нь гэмтэх;
- буулгалтад тавигдах ачаатай вагон болон чингэлгийг өртөөнөөс тавьж олгохыг саатуулах;
- техникийн нөхцөлийг зөрчиж бэхэлгээ буруу хийсэнд;
- ачаа хүлээн авагч болон дагнасан хэрэглээний зам эзэмшигчээс шалтгаалан ачаатай вагон буулгалтад тавигдахгүй хүрэх өртөөн дээр саатахад;
- ачаа хүлээн авагч, дагнасан хэрэглээний зам эзэмшигчээс, түүнчлэн хүрэх өртөөнд вагон хуримтлагдсанаас шалтгаалан вагон хүлээж авах техникийн боломжгүйгээс завсрын өртөөдөд вагон саатахад;
- ачаатай вагон болон чингэлгийн бодит жин нь вагон болон чингэлгийн зөвшөөрөгдсөн дээд даацаас хэтэрсэн тохиолдолд;
- ачаа илгээгч болон дагнасан хэрэглээний зам эзэмшигчээс шалтгаалан захиалгын дагуу хоосон вагон ачилтад тавигдахгүй саатахад;
- ачаа хүлээн авагчийн хүчээр ачааг буулгасны дараа вагон болон чингэлгийг цэвэрлээгүй тохиолдолд;
- цистерн болон бункерт вагоны ачилт буулгалтын дараа вагоны гадна талыг цэвэрлээгүй тохиолдолд;
- тээвэрлэгч бохир вагон, чингэлгийг ачаа илгээгчид ачилтад тавьж өгөхөд;
- вагон, чингэлгийн ломбо байхгүй, гэмтэлтэй байх эсвэл солигдсон байх, ломбоны хяналтын тэмдэг нь падаанд бичсэн тэмдэглэгээтэй тохирохгүй байх;

- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн мэдэгдлийн дагуу вагоны тавилт таталт хийхээр ирсэн зүтгүүрийг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн болон дагнасан хэрэглээний зам эзэмшигчийн буруугаар саатуулахад;

- энэхүү журмын 13 дугаар бүлэг /ачаа хүргэх хугацааг тооцох/-т заасны дагуу зам зуурт ачааг саатуулахад;

- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн ачаа хүргэгчийг солих тохиолдолд зам зуурт ачааг саатуулахад;

- хөдөлгөөний аюулгүй байдал болон ачааны бүрэн бүтэн байдалд саад болохуйц /ломбо байхгүй эсвэл гэмтэлтэй байх, вагоны нээлхий, вагон болон чингэлгийн ханаар ачаанд халдлага орсон шинжтэй/ вагоны, чингэлгийн гэмтэл илрүүлсэн тохиолдолд зам зуурт ачааг саатуулахад;

- вагон, чингэлгийн гэмтэлд;

- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч болон бусад байгууллагын эзэмшлийн вагон, чингэлгийг тээвэрлэгч буюу төмөр замын байгууллага дур мэдэн ашигласан тохиолдолд;

- тээвэрлэгчийн вагон, чингэлгийг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч болон бусад байгууллага дур мэдэн ашигласан тохиолдолд;

- ачаа хүлээн авагч тээврийн хөлс болон бусад хураамжийг төлөхөөс зайлхийсэн тохиолдолд тээвэрлэгч вагон, чингэлгийг буулгалтанд тавихгүй саатуулахад;

- тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хоорондын замд, хэсэглэх газар болон ачаа тээврийн ажиллагаанд хаалттай өртөө, зөрлөгт вагоны ачилт буулгалтын ажиллагаа дуусахыг хүлээх үед тээвэрлэгчийн зүтгүүрийн сул зогсолт гарахад;

- төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, дагнасан хэрэглээний зам эзэмшигч болон бусад хуулийн этгээд төмөр замын тээврийн ажлын технологит заагдсан баримтуудад /тээврийн бичиг баримт болон тооцооны хуудас, тээврийн захиалгыг гүйцэтгэсэн баримт, вагоны гэмтлийн акт, чингэлгийн гэмтлийн тухай акт, санамж, тавилт таталтын хүснэгт г. М/ гарын үсэг зурахаас зайлсхийх, татгалзахад;

- хилийн өртөөдөд хил, гааль, мэргэжлийн хяналтын болон хүчний байгууллага ачаатай вагон саатуулахад;

- төмөр замын тээврийн ажлын технологи, энэхүү журмаар заагдсан бусад тохиолдолд.

27.10.2. Ерөнхий маягтын актыг 3 /гурав/-аас доошгүй хувь үйлдэж, 2 /хоёр/-оос цөөнгүй ажилтан оролцож гарын үсэг зурна.

27.11. Магадлан шинжилгээний дүнг бүрдүүлэх:

27.11.1. Ачааны алдагдал, гэмтлийн шалтгаан, хохирлын хэмжээг тогтоохын тулд тээвэрлэгч буюу төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн санаачлагаар магадлан шинжээч, өртөө болон ачиж буулгах ажил эрхэлсэн тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын ажилтан, хүлээн авагч нарыг байлцуулж магадлан шинжилгээний акт тогтооно;

27.11.2. Магадлан шинжилгээг тээвэрлэгчийн санаачлагаар хийх тохиолдолд ачаа гэмтэж ирсэн хөдлөх бүрэлдэхүүн дотор нь эсхүл ачааг буулгах үед актыг тогтооно.

27.11.3. Магадлан шинжилгээний дүгнэлтэд тээвэрлэгч байгууллагын ажилтан доорх зүйлийг оруулахыг шаардана:

- ачааны гэмтэл, муудалтын зэрэг;

- гэмтсэн ачааг засаж болох эсэх, засахад гарах зардлын хэмжээ, гэмтсэн ачааны үнийг хэдэн хувиар бууруулах, бүрэн болон хэсэглэн хэрэглэж болох эсэх;

- ачааны гэмтлийн шалтгаан, ачааны төрөлд тохироогүй баглаанаас болсон эсэх, эсхүл ачааны өөрийн онцлог чанараас болж гэмтсэн муудсан эсэх, гэмтсэн хэсгийг нь сольж болох эсэх.

27.11.4. Шингэн ачаа гоожсон тохиолдолд савны магадлан шинжилгээгээр доорх зүйлийг тогтооно. Үүнд:

- ямар шалтгаанаар шингэн ачаа асгарч гоожиход хүргэсэн шалтгаан;
- сав нь зориулалтын болон тогтоосон стандартад тохирсон эсэх

27.11.5. Шинжээч нь сав, баглаа болон ачаа муудсан гэмтсэнийг тодорхойлж чадахгүйд хүрвэл өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга тодорхойлж чадахгүй байгаа шалтгааныг бичихийг шаардана.

27.11.6. Ачаа шалгасан тухай магадлан шинжилгээний акт тогтоож, магадлан шинжилгээнд оролцсон албан тушаалтнууд гарын үсэг зурна. Магадлан шинжилгээний акт тогтоосон тухай тээврийн актад тэмдэглэл хийнэ.

27.11.7. Шинжээчийн дүгнэлтийг өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын дарга үл зөвшөөрвөл шалтгаанаа заасан тэмдэглэл актад хийнэ.

27.11.8. Магадлан шинжилгээ хийхэд гарсан зардлыг буруутай тал төлнө.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ **ГОМДОЛ ГАРГАХ, ХЯНАН БАРАГДУУЛАХ**

28.1. Гомдол гаргагч нь ачаа үрэгдсэн, дутсан, гэмтсэн буюу муудсанаас үүссэн хохирол түүнчлэн тээврийн хөлсний зөрүүг буцааж олгох болон ачаа хүрэх хугацааг хожимдуулсан зэрэг гомдлыг падаан тус бүрээр гаргана.

28.2. Тээвэрлэгчийн эрх бүхий байгууллага нь гаргасан гомдлыг хянан үзэж, түүнийг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах тухай олон улсын төмөр замын ачааны харилцааны хэлэлцээр, түүний албан заавар, энэхүү журмын дагуу заасан хугацааны дотор гомдол гаргагчид мэдэгдэх үүрэгтэй.

28.3. Ирсэн гомдлын материалыг шалгаж хүлээн авахдаа:

- тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад гомдол зөв хаяглагдсан эсэх,
- гомдол гаргах эрх болон итгэмжлэл байгаа эсэх,
- гомдол гаргах хугацааг баримталсан эсэх,
- гомдолд хавсаргасан бичиг баримт нь гомдол гаргах нотлох баримт мөн эсэх, уг бичиг баримт нь зохих гомдолдоо хамаарах эсэх,
- хавсаргасан материалын эх хувь нь байгаа эсэх,
- гомдол гаргасан бичиг баримт нь буруутай этгээдэд эд материалын хариуцлага хүлээлгэх болон хохирлын хэмжээг нотлох үндэс болж чадах эсэхийг нягтлана.

28.4. Гомдлын материал бүрэн бүрдээгүй өргөдлийг судлалгүйгээр, хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор гомдол мэдүүлэгчид буцаана.

28.5. Гомдол гаргах хаяг:

28.5.1. Ачаа үрэгдсэн, дутсан, муудсан, гэмтсэн тухай гомдол гаргагчийн хүсэлтийг олон улсын төмөр замын ачаа харилцааны хэлэлцээр болон энэхүү журмын дагуу тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагад хаяглана;

28.5.2. Гомдлыг буруу хаяглан ирүүлсэн байвал уг гомдлыг хянан үзэхгүйгээр хавсаргасан баримтын хамт ирснээс хойш 15 хоногийн дотор гомдол мэдүүлэгчид буцаах бөгөөд гомдол мэдүүлэгчид гомдол гаргах хаягийг зааж бичгээр мэдэгдэнэ.

28.6. Гомдол мэдүүлэх эрх:

28.6.1. Гомдол мэдүүлэх эрхийг энэ журмын дагуу холбогдох бичиг баримт бүхий төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч эдэлнэ;

28.6.2. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч болон тээвэр зуучлагч тээврийн падааныг үндэслэн төмөр замын байгууллагад гомдол гаргаж болно;

28.6.3. Гомдлын хүсэлтэд холбогдох бичиг баримтыг хавсаргаагүй бол уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд тээвэрлэгч гомдол мэдүүлэгчид буцаана. Энэ тохиолдолд гомдол мэдүүлэгч тогтоосон хугацааны дотор шаардлагатай материалыг хавсарган гомдлоо дахин гаргах эрхтэй.

28.7. Гомдол мэдүүлэх хугацаа:

28.7.1. Ачаа үрэгдсэн, дутсан, муудсан, гэмтсэн тухай гомдлыг тээвэрлэгчид ачаа хүлээн авснаас хойш 9 сарын дотор, ачаа хүргэх хугацааны тухай гомдлыг 2 сарын дотор гаргана. Өргөдлийг шуудангаар илгээсэн өдрийг нь тогтоохын тулд шуудангийн дугтуйг бичиг баримтын нэг адил үзэж гомдлын хэрэгт хадгална;

28.7.2. Ачаа олгосон огноог падааны "ачаа олгосон өдөр" гэсэн хүснэгтэд дарсан өртөөний хуанлийн дардсаар тогтооно;

28.7.3. Энэхүү журмаар тогтоосон хугацааг баримтлаагүй ирүүлсэн гомдлыг буцааж, энэ тухай гомдол мэдүүлэгчид мэдэгдэнэ.

28.8. Нотлох бичиг баримт:

28.8.1. Гомдлын хүсэлтэд тээврийн үндсэн падаан, тээврийн акт, магадлан шинжээчийн акт, ачааны үнийг нотлох баримт болох ачаа илгээгчийн нэхэмжлэл буюу худалдааны гэрээний үнэ болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн байна;

28.8.2. Гомдлыг урьдчилан хянах явцад энэхүү журамд заасан бичиг баримтаас гадна өөр бичиг баримт шаардлагатай байвал гомдлыг буцаахгүйгээр уг баримтыг нэмж ирүүлэхийг шаардана;

28.8.3. Гомдол мэдүүлэгч нь тээвэрлэгч тээврийн акт тогтоохоос татгалзсаныг нотлох гэж байгаа бол хүсэлтдээ өртөөнд акт тогтоолгохыг хүссэн тухай бичигт өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргаас өгсөн хариу бичиг, хариу бичиг аваагүй бол өртөөний тээвэрлэгчийн эрх бүхий байгууллагын даргад явуулсан албан бичгийг хүлээн авсан ажилтны гарын үсэг эсхүл шуудангийн тасалбарыг хавсаргавал зохино.

28.9. Гомдлыг хянан барагдуулахын тулд:

- гомдлын дагуу хийсэн судалгааны материал бичиг хэрэгт бүрэн байгаа эсэхийг шалгах;
- тээвэрлэлтийн явцад ачаа хэдий хэмжээгээр үрэгдсэн гэмтсэн болохыг шалган тогтоох;
- чухам ямар нөхцөлд ачаа үрэгдсэн, гэмтсэн болохыг шалган тогтоох, шаардлагатай гэж үзвэл ачааны үрэгдэл гэмтлийн талаар дахин хяналт хийх;

- гомдол мэдүүлэгчийн гаргасан тооцоог шалгаж, ачаа үрэгдсэн, гэмтсэн хохирлын хэмжээг тодорхойлох;

- гомдолд хавсаргасан бичиг баримт үндсэн эхээрээ /ачааны падаан, тээврийн акт, шинжээчийн акт, нэхэмжлэх/ байгаа эсэхийг шалгах, түүнчлэн эдгээр бичиг баримтад ямар нэгэн нэмэлт засвар оруулаагүй болохыг тогтоох шаардлагатай.

28.10. Тээвэрлэгч, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн хүлээх хариуцлага:

28.10.1. Зохих илгээлтийн ачаа нь төмөр замын байгууллагын буруугаас болж үрэгдсэн, гэмтсэн болох нь нотлогдвол гомдол гаргагчийн гаргасан тооцоог шалган үзэж, үрэгдсэн гэмтсэн ачааны хэмжээг тогтоосны үндсэн дээр уг гомдлыг хүлээн зөвшөөрнө;

28.10.2. Гомдлын дагуу хохирлын хэмжээг тодорхойлохын өмнө чухам ямар нөхцөл байдалд үрэгдсэн, дутсан, муудсан, гэмтсэн болохыг шалган үзээд энэхүү журмын дагуу тээвэрлэлтийн үед үүссэн уг хохирлыг төмөр замын байгууллага нөхөн төлөх эсэхийг тогтооно;

28.10.3. Гомдол гаргагч тээвэрлэгчийн буруугаас ачаа үрэгдсэн, муудсан, гэмтсэн болохыг нотлож чадаагүй болон энэхүү журмын дагуу ачаа үрэгдсэн гэмтсэний хариуцлагыг тээвэрлэгч хүлээхээргүй байх шалтгааны аль нэгний улмаас ачаа үрэгдсэн гэмтсэн, муудсан болох нь тогтоогдсон бол энэ тухай хариу албан бичигт тодорхой заана.

28.11. Тээвэрлэлтийн үед үрэгдсэн гэмтсэн ачааны бодит хэмжээ:

28.11.1. Ачааны дутагдал, гэмтлийн бодит хэмжээг тээврийн акт, түүнд хавсаргаж ирүүлсэн дагалдах баримтуудыг үндэслэн тогтоох бөгөөд түүнчлэн хохирлын хэмжээг ачаа илгээгч, хүлээн авагчийн хооронд хийсэн гэрээ болон нэхэмжлэлийг үндэслэн тогтооно;

28.11.2. Шаардлагатай тохиолдолд ачаа олголтын үед магадлан шинжээчийг оролцуулан хохирлын бодит хэмжээг тогтооно.

28.12. Ачааны жингийн хэвийн хорогдлын нормыг тооцоолох, хэрэглэх:

28.12.1. Жингээр нь тооцож үнийг тооцдог ачааны жин, тээвэрлэлтийн явцад дутвал тухайн ачаанд тогтоосон жингийн хэвийн хорогдлын нормоор багасгаж бодит дутагдлын хэмжээг тогтооно;

28.12.2. Хэвийн хорогдлын нормыг падаан дахь ачааны нийт жинд тулгуурлан бодно. Төрөл бүрийн ачааг тээвэрлэлтэд хүлээн авахдаа тус бүрийн жинг заасан байвал жингийн хэвийн хорогдлын нормыг ачаа тус бүрээр бодно. Нэг буюу хэд хэдэн байр ачаа гэмтсэн, алдагдсан шинжтэй бөгөөд жингийн нийт дутагдал гэмтсэн ачааны жингийн дутагдлаас хэтрэхгүй байсан ч жингийн дутууг хэвийн хорогдлын нормонд тооцож болохгүй;

28.12.3. Ачаа бүхэлдээ үрэгдсэн буюу тусдаа байр үрэгдсэн үед ачааны хэвийн хорогдлын нормыг хэрэглэхгүй;

28.12.4. Нэг тээврийн акт тогтоогдсон хэд хэдэн илгээлттэй нэг төрлийн ачааны дутагдлыг тооцохдоо хэвийн хорогдлын нормыг зөвхөн дутсан илгээлтүүдийн падаанд заасан жингээс тооцно. Холимог тээвэр болон шилжүүлэн ачилт хийгдсэн хэд хэдэн илгээлттэй нэг төрлийн ачаанд хүрэх өртөөнд тээврийн акт тогтоогдсон бол жингийн хэвийн хорогдлын нормыг нийт жингээс тооцно.

28.13. Хохирлыг барагдуулах мөнгөн дүнг тодорхойлох:

28.13.1. Дутсан, гэмтсэн үрэгдсэн ачааны хохирлыг барагдуулах үнийн дүнг тодорхойлохдоо холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно. Гомдлын хүсэлтэд дутсан, гэмтсэн, алдагдсан ачааны үнэ өртгийг зөв тогтоосон эсэхийг шалгана. Тээвэрлэгч нь үнэ зарласан ачааны дутагдлын үнийн хэмжээг жинхэнэ үрэгдсэн ачааны өртгөөр, гэмтсэн ачааны өртгийг буурсан хэмжээгээр тус тус тогтооно;

28.13.2. Бараа нийлүүлэгч буюу илгээгч ачсан ачааныхаа хэмжээ, үнийг заасан баримтыг тээврийн бичиг баримтад хавсаргасан бол энэ нь ачаа хүлээн авагчийн хувьд ачааны жинхэнэ үнэ болно. Үрэгдсэн ачааны үнийг зөв тодорхойлохын тулд нэхэмжлэл гаргасан үнэд арилжааны ашиг тооцоогүй эсэхийг тогтооно;

28.13.3. Нэхэмжлэлийг гэрээний үнээр гаргасан байвал уг үнээр гомдлыг барагдуулна. Нэхэмжлэлийг жижиглэн худалдаалах үнээр гаргасан байвал гомдлын үнээс ашиг тооцсон хэсэг, бусад нэмэгдлийг хасч тооцно. Гомдлыг барагдуулахдаа төлөөгүй тээврийн хөлс, гүйлгээний татварыг нэхэмжлэхгүй. Гомдол мэдүүлэгч нэхэмжлэлд нэг ачааны хэд хэдэн зэрэг дугаарыг тоочиж төрөл бүрийн үнэ заасан боловч тээврийн актаар чухам ямар зэрэг дугаартай ачаа үрэгдсэнийг тогтоогоогүй бол үрэгдсэн ачааны өртгийг нэхэмжлэлд заасан тухайн ачааны доод үнээр барагдуулна.

28.13.4. Үнэ зарласан ачааны хохирлыг барагдуулах хэмжээг падаан, бусад бичиг баримтанд заасан болон энэ талаар хамааралтай мэдэгдлийг үндэслэн дараах байдлаар тогтооно:

- бүх ачааг үрэгдүүлбэл ачааны падаанд заасан зарласан үнээр хохирлыг бүрэн төлнө;
- зарим хэсгийг үрэгдүүлбэл үрэгдсэн ачааны зарласан үнээр ширхэг тус бүрт;
- зарим ширхэгийн зүйлийг үрэгдүүлбэл зарласан үнийн жагсаалтаар, жагсаалт хийгээгүй байвал тухайн байрын зарласан үнэ, жингээс үндэслэн нэг кг-ын дундаж өртгөөр.

28.13.5. Энэхүү журмын 28.13.4-т заасан мэдэгдлүүд байхгүй бол падаанд заасан нийт зарласан үнэ, ачааны нийт жинг үндэслэн тогтооно. Ачааны зарласан үнэ ачааны жинхэнэ үнээс хэтэрч байгааг төмөр замын байгууллага нотолж чадвал тээвэрлэлтийн явцад үүссэн хохирлыг жинхэнэ өртгөөр нь төлнө;

28.13.6. Ачааг гэмтээсэн хохирлыг тээврийн акт болон шинжээчийн актыг үндэслэн тогтооно. Гэмтсэн ачааг олгоход хохирлыг нь тодорхойлоогүй байвал нөхөн төлөх хэмжээг гэмтсэн ачааны буюу түүний хэсгийн өртгийн жинхэнэ буурсан үнээр тодорхойлно;

28.13.7. Тээвэрлэлтэд үнэ зарлаагүй хүлээн авсан иргэний /гэрийн хэрэглэл г.м./ ачааны үрэгдсэн ачааны өртгийг барагдуулахад гаргасан гомдлын үнийн дүнг ачааг хүлээлгэн өгөх тухайн үеийн зах зээлийн үнийн дүнтэй харьцуулан тооцно.

28.14. Хүлээн авагчид хүрээгүй ачааны талаарх гомдлыг хянан барагдуулах:

28.14.1. Тээвэрлэлтийн явцад бусдад шилжүүлсэн, хаяг сольж өөр хаягаар олгосон, үрэгдүүлсэн, саатуулсан түүнчлэн тодорхой бус шалтгаанаар эзэндээ хүрээгүй ачааны талаарх гомдлыг энэхүү журмын дагуу барагдуулна;

28.14.1. Тээвэрлэлтийн явцад бусдад шилжүүлсэн, хаяг сольж өөр хаягаар олгосон, үрэгдүүлсэн, саатуулсан түүнчлэн тодорхой бус шалтгаанаар эзэндээ хүрээгүй ачааны талаарх гомдлыг энэхүү журмын дагуу барагдуулна;

28.14.2. Ачаа хүрэх зам, уг ачааг замд нь хямд үнээр шилжүүлснийг тогтоовол ачаа борлуулсан үнийн дүнгээр гомдлыг барагдуулна;

28.14.3. Хаяг сольж өөр хүлээн авагчид ачааг олгосон шалтгаанаар ачаа нь анхныхаа эзэнд хүрээгүй тухай гомдлыг хэрэгсэхгүй. Гомдол мэдүүлэгчид ачааг хэнд, хаана олгосныг албан бичгээр хариу өгч, хүсэлтэд хавсаргасан баримтын хамт буцаана;

28.14.4. Ачааг өөр хүлээн авагч авсан нь баримтаар нотлогдвол эзэндээ хүрээгүй ачааны гомдлыг энэхүү журмын 28.14.3-т заасны адилаар шийдвэрлэнэ;

28.14.5. Ачаа алга болсон тухай гомдлыг барагдуулах хугацаанд ачаа байгаа газар, хэнд олгосныг тогтоогоогүй бол ачааг бүхэлд нь үрэгдсэнд тооцож, гомдлыг зохих журмын дагуу барагдуулна;

28.14.6. Эрлийн явцад ачаа үрэгдээгүй харин замд яваа нь тогтоогдвол, ачааг хүлээн авагчид хүргэхийг хурдасгах арга хэмжээ авах бөгөөд энэ тухай гомдол мэдүүлэгчид мэдэгдэнэ.

28.15. Хүлээн зөвшөөрсөн гомдлыг барагдуулах:

28.15.1. Тээвэрлэгч хүлээн зөвшөөрсөн гомдлын хэргийн төлбөрийн үнийн дүнг шалгаж тогтоосны дараа тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргана. Шийдвэрийн дагуу төлбөрийг барагдуулна;

28.15.2. Гомдлыг бүхэлд нь эсвэл заримыг нь хэрэгсэхгүй болговол гомдол мэдүүлэгчид хэрэгсэхгүй болгосон үндэслэлийг тодорхой зааж хариуг албан бичгээр өгнө. Гомдол мэдүүлэгчид ирүүлсэн баримтыг буцаана. Шаардлагатай бол гомдлын материалд эдгээр баримтын хуулбар болон шаардлагатай зарим хэсгийг хавсаргана;

28.15.3. Хүлээн зөвшөөрсөн гомдолд хавсаргасан баримтуудыг буцаалгүйгээр ачаа тээвэрлэлтийн албаны тээвэрлэгчийн эрх бүхий дээд байгууллагын акт гомдлын хэрэгт хадгална.

28.16. Тээвэрлэгчийн барагдуулсан гомдлын хариуцлагыг салбар нэгжтэй тооцох:

28.16.1. Тээвэрлэгч төлбөрийг барагдуулахаар шийдвэрлэгдсэн ачааны бүрэн бүтэн байдал алдагдсанаас үүссэн хохирлын төлбөрийг буруутай байгууллага, аж ахуйн нэгжтэй тооцно;

28.16.2. Өртөөдийн хариуцлагад тооцсон ачааны бүрэн байдлын алдагдлын төлбөрийг тээвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр, салбар нэгжийн бурууг тогтооход санал зөрсөн тохиолдолд тээвэрлэгчийн шийдвэрээр тус тус тогтооно;

28.17. Төмөр замын байгууллага нь ирүүлсэн гомдлыг хянаж үзээд түүнийг барагдуулсан буюу хэрэгсэхгүй болсон тухай хариуг байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд 3 сарын дотор өгнө.

--oOo--

Зам, тээврийн хөгжлийн сайдын
 ... оны .. дүгээр сарын ..-ны өдрийн
 ... дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
 тээвэрлэх дүрмийн нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ТЭЭВРИЙН ПАДААН

Нүүрэн тал

Орон нутгийн харилцааны тээврийн падаан №						
Байгууллагын нэр:						
Онцгой тэмдэглэл _____.			Хурд _____.			
			Илгээлтийн төрөл _____.			
Төлөвлөгөө гэрээний № _____.		Вагоны дугаар	6.1	Вагоны төрөл	Даац (тонн)	Голын тоо
Ачихыг зөвшөөрсөн _____ 20... он						
Өртөөний дарга _____.						
Илгээх өртөө		Хүрэх өртөө				
Илгээгч, түүний шуудангийн хаяг		Хүлээн авагч, түүний шуудангийн хаяг				
Илгээгчийн марк тэмдэг	Байрын тоо	Баглааны төрөл	Ачааны нэр	Ачааны жин		Төмөр замын марк
				Илгээгч	Төмөр зам	
						Ачаалсан ачаалалтын техникийн норм
Байрын тоо _____. (үсгээр) _____.		Жинг тодорхойлсон арга _____			Тарифын бүлэг _____	
Жингийн дүн _____. (үсгээр) _____.		Илгээгчийн төлөөлөгч (гарын үсэг, нэр)			Зай км _____	
Илгээхэд хураасан (дүн үсгээр) _____.		Илгээх үеийн хураамж				
Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус) _____.						
Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр) _____.						
Олгоход хураасан (дүн үсгээр)			Бүгд хураасан			
Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус) _____.		Олгох үеийн хураамж				
Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр) _____.						
Падаанд хавсаргасан баримтууд						
			Бүгд хураасан			

Ар тал

36. Ачиж бэхлэх тухай Дагуу ачиж бэхэлсэн (албан тушаалын гарын үсэг) (Батлагдсан ямар зураг, техникийн нөхцөл, стандартыг үндэслэн бэхэлснийг заана)			
37. Ломбоны тухай тэмдэглэл			
	Төмөр замын	Илгээгчийн	Ломбо зүүсэн нь (Ломбо хаана зүүснийг заана)
Ломбоны тоо			
Ломбоны хяналтын тэмдэг			
38. Төмөр замын тэмдэглэл		39. Илгээгчийн тэмдэглэл	
40. Актын тухай тэмдэглэл		41. Хаяг сольсон тухай тэмдэглэл	
42.Вагоныг буулгалтанд тавьсан он, сар, өдөр, цаг	43. Вагоныг буулгаж дууссан он, сар, өдөр, цаг	44. Ачааг олгох үед хийсэн тэмдэглэл	
45.Илгээх өртөөний хуанлийн тэмдэг	46.Хүрэх өртөөний хуанлийн тэмдэг	47.Ачаа ирсэн тухай мэдэгдэл	48. Ачаа олгосон тухай тэмдэглэл хуанлийн тэмдэг Хүлээн авсан (гарын үсэг, нэр)
Дамжин өнгөрсөн төмөр замын тээврийн байгууллагын өртөөний хуанлийн тэмдэг			
49.	50.	51.	52.
53.	54	55.	56

ТАЙЛБАР: Орлох падаан нь падаантай адилхан байна.

**ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ ТЭЭВРИЙН ПАДААН
ЗАМЫН ХҮСНЭГТ**

Орон нутгийн харилцааны тээврийн падаан замын хүснэгт №						
Байгууллагын нэр:						
Онцгой тэмдэглэл			Хурд			
			Илгээлтийн төрөл			
Төлөвлөгөө гэрээний №		Вагоны дугаар	6.1	Вагоны төрөл	Даац (тонн)	Голын тоо
Ачихыг зөвшөөрсөн _____ 20... он						
Өртөөний дарга						
Илгээх өртөө			Хүрэх өртөө			
Илгээгч, түүний шуудангийн хаяг			Хүлээн авагч, түүний шуудангийн хаяг			
Илгээгчийн марк тэмдэг	Байрын тоо	Баглааны төрөл	Ачааны нэр	Ачааны жин		Төмөр замын марк
				Илгээгч	Төмөр зам	
						Ачаалсан ачаалалтын техникийн норм
Байрын тоо _____ (үсгээр)			Жинг тодорхойлсон арга		Тарифын бүлэг _____	
Жингийн дүн _____ (үсгээр)			Илгээгчийн төлөөлөгч (гарын үсэг, нэр)		Зай _____ км	
Явуулахад хураасан (дүн үсгээр)		Хүлээлгээх үеийн хураамж				
Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус)						
Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр)						
Олгоход хураасан (дүн үсгээр)			Бүгд хураасан			
Тооцооны хэлбэр (бэлэн/бэлэн бус)		Олгох үеийн хураамж				
Тооцооны ажилтан (гарын үсэг, нэр)						
Падаанд хавсаргасан баримтууд						
			Бүгд хураасан			

Зам, тээврийн хөгжлийн сайдын
 ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 ... дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
 тээвэрлэх дүрмийн хоёрдугаар хавсралт

АЧААНЫ БИТҮҮМЖЛЭЛ, БҮРТГЭЛ, ТЭМДЭГЛЭГЭЭ

Нүүрэн тал

		М 20 ... он ... сар өдөр Ст 20 ... г ... месяц ... число				Вагоны төрөл Род вагоны	Вагон даац Подъёмная сила
Онцгой тэмдэглэл / Особые заявления							
Битүүмжлэлийн тухай Ведения о пломбах	Битүүмжлэгч станц Станция положения пломб						
	Ломбоны тоо Число пломб Месяц и число на пломбах						
	Шалгах тэмдгүүд Контрольные знаки						
Падааны № № наклада	Явуулах станц Станция отправления	Хүрэх станц Станция назначения	Хүрэх зам Дорога назначен	Баглааны төрөл Род упаковки	Ачааны нэр Наименование груза	Жин кг-аар Вес в кг	
1	2	3	4	8	9	10	
					НИЙТ БОХИР ЖИН /ВСЕГО БРУТТО		
Вагоныг ачилтанд өгсөн цаг мин өдөр сарын Вагон подан под выгрузку час мин числа месяц Средствами АВХ: Хянасан ААВХ:					Буулгасан цаг мин өдөр тоот барааны газарт Выгружен час, мин числа, пакта № АВХ Присмосдатчик		

Ар тал

	Илгээлт №							Илгээлт №			
	6-Вагон, 6-Вагон олгосон, 7- вагоны төрөл, 8-Вагоны даац, 9-Гол, 10-Вагоны жин, 11-Цистерний төрөл							37. Ломбо		38.Тээвэрлэгчийн тэмдэглэл	
								Температура, С -Хэм	Г/см ³ Нягт	Тоо	Тэмдэг, тэмдэглэг ээ
	6	6.1	7	8	9	10	11				
1											
2											
3											
4											
5											
6											
7											
8											
							ДҮН				

Илгээгчийн нэр, гарын үсэг:

Өртөөний хуанлийн тэмдэг:

ЧИНГЭЛГИЙН ХҮСНЭГТ

Чингэлгийн хүснэгт													Илгээлт №			
№	17. Ачааны нэр			37. Ломбо		15. Байр-ын тоо	18. Жин /кг-аар/			6-Вагон, 6.1-вагон олгосон, 7-вагоны төрөл 8-Вагоны даац, 9-Гол, 10-Чингэлгийн жин						38. Тээвэрлэгч-ийн тэмдэглэл
	Чингэлэг №	Чингэлгийн код, хэмжээ, төрөл	Ачааны нэр	Тоо	Тэмдэглэмдэглэгээ		Ачааны цэвэр жин	Чингэлгийн жин	Нийт жин	6	6.1	7	8	9	10	
					Дүн											

Зам, тээврийн хөгжлийн сайдын
 ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 ... дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
 тээвэрлэх дүрмийн гуравдугаар хавсралт

ЧИНГЭЛГИЙН ГАДНА, ДОТОР ТАЛЫН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Төрөл	фут		Чингэлгийн хэмжээ /гадна тал/			Чингэлгийн хэмжээ /дотор тал /		
			урт	өргөн	өндөр	урт	өргөн	өндөр
1EEE	45HC	L2G0	13716	2438	2896	13542	2330	2655
1EE	45 DC	L5G0			2591			2350
1AAA	40HC	45G0	12192	2438	2896	11998	2330	2655
1AA	40DC	42G0			2591			2350
1A	40DC	40G0			2438			2197
1AX								
1BBB	30HC	35G0	9125	2438	2896	8391	2330	2655
1BB	30DC	32G0			2591			2350
1B	30DC	30G0			2438			2197
1BX					<2438			
1CC	20DC	22G0	6058	2438	2591	5867	2330	2350
1C	20DC	20G0			2438			2197
1CX					<2438			
1D	10DC	10G0	2991	2438	2438	2802	2330	2197
1E			1968	2438	2438		2197	2330
1F	5		1460	2438	2438	1270	2197	2330

Зам, тээврийн хөгжлийн сайдын
 ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
 ... дүгээр тушаалын Төмөр замаар ачаа
 тээвэрлэх дүрмийн дөрөвдүгээр хавсралт

ВАГОН АЧИЛТ, БУУЛГАЛТ, ХҮЛЭЭЛГЭНД ТАВЬЖ ӨГСӨН,
 ХҮЛЭЭЛЦСЭН, БУУЛГАЖ ДУУССАН САНАМЖ /сери дугаар/

20..... оны.....-р сарын өдөр

Үйлчлүүлэгч байгууллагын нэр: _____

Салбар замын нэр, дугаар: _____

Д/Д	Вагон Дугаар /О,П/	Хүлээлэг				Тавьж өгсөн		Ачиж, дууссан буулгаж		Сэлгээ хийсэн хугацаа	Тайлбар
		эхэлсэн		дууссан		сар, өдөр	цаг, минут	сар, өдөр	цаг, минут		
		сар, өдөр	цаг, минут	сар, өдөр	цаг, минут						
1	2	3	4	5	6	7	8	9	0 1	1 1	2 1
2											
3											
4											
5											
6											
7											
8											

Үйлчлүүлэгч байгууллагын төлөөлөгч

Төмөр замын төлөөлөгч

Хүлээн авсан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут

Тушаасан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут

Тушаасан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут

Хүлээн авсан: _____
 /гарын үсэг, нэр/
 огноо.....цаг.....минут